



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7 - 86

1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	9
2. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	10 - 43
3. “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	43 - 46
4. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бэлтгэл ажил болон Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах	47 - 53
5. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан	53 – 78
6. Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан	78 - 86

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 02-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 88.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Ганибал, Б.Жавхлан;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын хаврын 2023 оны ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	1
Бүгд:	13

92.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Нийслэлийн Засаг даргын Эдийн

засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын дарга Х.Эрдэнэбулган, Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын дарга Д.Очирваань, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Б.Энхбаяр, Х.Ганхуяг, О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин, Т.Доржханд, Д.Батлут, Ч.Ундррам нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг үг хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	4
Бүгд:	15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг нар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бэлтгэл ажил болон Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бэлтгэл ажил болон Монгол Улсын Их Хурлын 2022 оны хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг тус тус үндэслэн боловсруулсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн Т.Цэрэнбадрал, Н.Хүдэрчулуун, мөн хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Зах зээлийн судалгаа хөгжлийн газрын дарга Н.Оюунчимэг, Даатгалын газрын дарга З.Батболд, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Хадгаламж, зээлийн хоршооны дарга Ц.Алтантуул, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн, Хууль эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Т.Билэгсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Д.Батлут, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн Т.Цэрэнбадрал, мөн хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, мэдээлэлтэй танилцав.

Уг асуудлыг 18 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Үндэсний статистикийн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Үндэсний статистикийн хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга Ш.Ариунболд, Эдийн засгийн статистикийн газрын дарга Ц.Тэгшжаргал, Хөдөө, аж ахуй, байгаль орчны статистикийн хэлтсийн дарга Э.Мягмарханд, Нэгдсэн статистикийн газрын дарга Б.Саранчимэг, Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн ахлах статистикч Э.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, мэдээлэлтэй танилцав.

Уг асуудлыг 18 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 05 минут үргэлжилж, 18 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 88.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 18 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя. Байнгын хорооны гишүүдээс Ж.Ганбаатар гишүүн өвчтэй.

Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирж, ирц 55.6 хувьтай бүрдсэн тул 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр Байнгын хороондоо танилцуулахад Д.Өнөрболор гишүүн маань Байнгын хорооны гишүүн болж байгаа шүү.

Ингээд Д.Өнөрболор гишүүндээ амжилт хүсье. Тавтай морилно уу.

Хэлэлцэх асуудал.

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 5 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Гурав. “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг боловсруулсан.

Дөрөв. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бэлтгэл ажил болон Монгол Улсын Их Хурлын 2022 оны хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлттэй танилцах.

Тав. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан. 2022 оны 03 сарын 30-нд ирүүлсэн. Хэлэлцэх.

Зургаа. Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан. 2022 оны 03 сарын 30-нд ирүүлсэн. Хэлэлцэх гэсэн нийт 6 асуудал хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Ж.Бат-Эрдэнэ гишүүн саналаа хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Өнгөрсөн бүтэн сайн өдөр Улсын Их Хурлын даргын үүрэг болгосноор 5 гишүүн энэ захуудаар явж танилцсан.

Тэгээд ер нь яах вэ, үүрэг болгохдоо мах, махан бүтээгдэхүүний, ер нь бараа, материалын үнийн өсөлттэй холбоотой асуудал дээр танилцах, дүгнэлт гаргах гэсэн үүрэг даалгавар өгсөн.

Та ажлын хэсгийг ахлаад явсан байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг Байнгын хороогоор оруулаад танилцуулаад. Ер нь асуудлын үр дүн мэдээж тодорхой.

Засгийн газар болон Улсын Их Хурал. Тэгээд цаашлаад Улаанбаатар хот гээд шат шатандаа хийх арга хэмжээг тодорхойлоход асуудлын гол учиг үүнд байгаа шүү дээ.

Тэгэхээр яг үүнтэй холбоотой асуудлууд. Дээрээс нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай холбоотой асуудлууд. Хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүн нийлүүлж байгаа асуудлууд. Улаанбаатар хоттой холбоотой асуудлууд гэх мэтчилэн.

Жишээ нь, нөөцийн мах бэлтгэлтэй холбоотой асуудлууд гээд нэлээн үзэх харах асуудлууд нэлээн байх шиг байна. Танд тэр танилцуулга юмнуудыг нь сонсох хэрэгтэй байна. Тэгж байж бид дараагийн арга хэмжээг авах ёстой л доо.

Тэгэхээр энэ асуудлыг хэзээ Байнгын хороогоор хэлцэх вэ гэдэг асуудлыг л танаас асууж байгаа юм.

Тэгээд ер нь ард иргэд маань ерөөсөө хэдэн гишүүн явлаа, үзлээ,

харлаа. Тэгээд л яг ямар үр дүн гарах юм гээд хараад байгаа шүү дээ. Хүлээлттэй байж байгаа.

Тэгэхээр энэ дээр бас нэг тодорхой хариулт хэлж өгөөч ээ. Хэзээ бид Байнгын хороогоороо энэ асуудлыг оруулж ирэх вэ?

Ц.Цэрэнпунцаг: Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуудлаа гаргаж ирж ярьж байгаад баярлаж байна.

Бид сая энэ амралтын өдрүүдээр явсан ажил. Ард иргэдээ сонссон. Ард иргэдийнхээ санал, хүсэлтийг үндэслээд энэ асуудлуудтай холбоотой төрийн байгууллагууд, Хөдөө аж ахуйн яам, мөн нийслэлээс мэдээлэл сонсоно гээд.

Тэгээд мөн хажуугаар нь Монголбанк, Статистикийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах газруудыг байлцуулан маргаашийн Эдийн засгийн байнгын хороо дахиж гурав дахь өдөр буюу маргааш хуралдуулахаар оруулсан.

Ингээд 13 цаг 30 минутаас хурал эхэлнэ. Энэ хурал дээр бид байгууллагуудаас мэдээлэл сонсож, ард иргэдийн асуусан асуултад энэ байгууллагуудаас нь шууд хариуцаж байгаа чиг үүрэг нь, хариуцаж байгаа яам, нийслэлээс нь асуултуудыг нь асууж мэдээлэл авна гэж хуваарьт орсон байгаа шүү. Баярлалаа.

Х.Ганхуяг гишүүн горимын санал гаргах юм уу? Шаардлагагүй юм байна.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн алга.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

2023 оны 5 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлбэ.

Та бүхэндээ тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 83 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаврыг хавсралтаар баталсугай.

2.Хууль хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын

хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т үүрэг болгосугай.

Гишүүд асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 2023 оны 5 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 92.3 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 2023 оны 5 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Дараагийнхаа асуудалд оръё.

*Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэх асуудал хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулна.

Ч.Хүрэлбаатар сайдын гишүүн сайдын микрофоныг нээе.

Ч.Хүрэлбаатар: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт “Хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичгийг Засгийн газарт санаачилна” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолын 2.3 дахь заалтад “улсын

хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар, чиглэлийг тодорхойлж, хөгжлийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн тусгах”-аар заасныг хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл нь “**Алсын хараа-2050**” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд өрхийн орлого нэмэгдүүлэхийг гол зорилгоо болгон экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах, засаглалтыг сайжруулах, ногоон хөгжлийг дэмжих гэсэн 8 бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон.

Энэхүү 8 бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, үндсэн хариуцах байгууллагыг тусгахын хамт жилийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээг “**Алсын хараа-2050**” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн

бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдууллаа.

Төлөвлөгөөний төсөлд салбарын яамд, байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллагуудаас 2024 онд хэрэгжүүлэхээр нийтдээ 80.2 их наяд төгрөг бүхий 1047 төсөл, арга хэмжээний санал ирүүлсэн.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2 дахь заалтын дагуу улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан 8 бодлогын тэргүүлэх чиглэл, 184 төсөл, арга хэмжээнд нийтдээ 13.4 их наяд төгрөгийг санхүүжүүлэхээс улсын төсвийн хөрөнгөөр 2.3 их наяд төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 0.2 их наяд төгрөг, гадаадын зээлээр 1.3 их наяд төгрөг, гадаадын тусламжаар 0.5 их наяд төгрөг, төр хувийн хэвшлийн түншлэлээр 4.5 их наяд төгрөг, хувийн хөрөнгө оруулалтаар 3.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээр 1.6 их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн боловсрууллаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг эцэслэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд баярлалаа.

Та бүхэнд ажлын хэсгийг танилцуулъя.

Чимэдийн Хүрэлбаатар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Цэрэнпилийн Даваасүрэн Барилга, хот байгуулалтын сайд, Содномын Чинзориг Эрүүл мэндийн сайд, Жамьянхорлоогийн Сүхбаатар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Чинбатын Номин Соёлын сайд, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Гантөмөрийн Түвдэндорж Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Жигжидсүрэнгийн Сандагсүрэн Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга, Даваасамбуугийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга, Хишигбаярын Эрдэнэбулган Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын дарга, Дэмбэрэлийн Очирваань Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга.

Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Төсөл санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Ч.Ундрам гишүүнээр тасаллаа.

М.Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Энэ бусад яам, салбар, байгууллага, орон нутаг гээд нийтдээ 2024 онд хэрэгжүүлэхээр 80.2 их наяд төгрөг бүхий 1047 төсөл, арга хэмжээг ирүүлсэн гээд ярьж байна.

Сая бид Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад Бундестагийн урилгаар манай Монгол, Германы парламентын бүлгийн төлөөлөгчид ажлын айлчлал хийсэн. Яг энэ үеэр Германы тал жишээ нь ярьж байна лээ л дээ.

Одоо тэр “**Global Gateway**” гээд том төсөл хэрэгжүүлэх ажил Европын Холбооны санаачилгаар эхэлж байгаа юм байна.

Ер нь бас энэ Герман Улс жишээлбэл Монгол Улсдаа энэ олон чиглэлээр жишээ нь хамтран ажиллах сонирхол байгаа. Гэхдээ танай улс яг ямар асуудлыг гол болгоод тэр талаараа маш тодорхой төсөл, тэр ТЭЗҮ, тэр өртөгтэйгөө ингэж ер нь өгөх хэрэгтэй байдаг. Энэ тал дээр ингээд дандаа дутагдалтай байгаа нь уулзалт болгоноос харагдаж байсан л даа.

Одоо жишээлбэл эрчим хүчний салбараа бүрэн шинэчилнэ гэсэн хэрнээ эрчим хүчний салбарынхаа яг л ийм юмыг шинэчилж, ийм өртөгтэй нь энэ хугацаанд хийх юм, энд ийм хөрөнгө оруулалт хэрэгтэй ч гэдэг юм уу. Эсвэл “**ногоон экспорт**” гэдэг дээр ийм юм хэрэгтэй гээд тэр яг тодорхой төслөө Монгол Улс тодорхой болгоо. Тэгээд

гаднын улс орнуудтай хэлэлцээрийн ширээний ард суувал асуудал үр дүн, хэрэгжилт сайн байдаг байсан. Гэтэл манайх ер нь тэгдэггүй.

Тэгээд маш олон төслүүд ярьдаг. Тэгээд юу нь, аль нь гол юм гэдэг нь тодорхойгүй байгаад байна л даа. Олон жил ингэж явж байна. Би өөрөө эдийн засгийн асуудал хариуцсан тоймчоос өгсүүлээд л өнөөдрийг хүртэл харж байхад гадаад уулзалт, айлчлал болоход нэг л олон юм яриад байдаг. Яг үр дүн, хэрэгжилт нь дандаа 10, 20, 30 хувьтай болоод л зогсчихдог.

Тэгэхээр одоо энэ олон төслөөс өрхийн орлогыг нэмэгдүүлэхийг гол зорилгоо болгож, энэ хүрээнд 8 чиглэлийг гол болгож байна гээд сая Ч.Хүрэлбаатар сайд хэлж байна л даа.

Тэгээд энэ нөгөө л экспортыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг гээд л, аялал жуулчлал гээд 8 зүйлүүд байна.

Эндээс яг ямар төслийг 2024 онд хэрэгжүүлэхээр бэлэн болж байгаа вэ? Яг л иймд өртөгтэй, тэгээд ийм улстай юм уу, эсвэл төсвийн хөрөнгө оруулалтаар.

Энэ нь өөрөө өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд ийм жин дарж, ийм нөлөө үзүүлэх юм гэсэн яг тодорхой аль төсөл нь бэлэн байгаа вэ?

Үүнийг жишээлбэл сая хэлж байна. Гаднын зээл, тусламжаар тэдэн хувь нь, улсын төсвөөр тэдэн хувь нь гээд хувь хувь ингээд зачихсан байна л даа.

Тэгэхээр юуны төлөө Эдийн засаг, хөгжлийн яамтай болсон билээ. Яг энэ өрхийн орлогыг нэмэгдүүлэх дээр тодорхой бэлэн болчихсон. Энэ төслийг бид хэрэгжүүлээд эхэлчихвэл энэ өрхийн орлогын яг 2024 онд инфляц тэдэн хувьтай байлаа гээд бодоход эдийн

засгийн өсөлт өнөөдөр 8 хувь. Ирэх жил бид тэдэд аваачихад ингэж нөлөөлөх юм. Өрх өрхийн орлогод.

Одоогийн байдлаас тэд дахин нэмэгдэх юм гээд яг тийм тооцоо, судалгаа урьдчилсан байдлаар хийсэн үү? Энэ дээр нэгдүгээрт хариулт авъя гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, Оюу Толгойн гүний уурхайн ашиглалтад орсонд Монголчууд маш их талархаж, баярлаж байгаа. Нөгөө талаасаа эндээс бас эдийн засгийн маш их үр дагавар гарна гэсэн тийм итгэл хүлээлт байгаад байгаа.

Гэхдээ одоогийн байдлаар гадаад валютын нөөц энэ тэр гээд зүгээр нүүрснээс орж ирж байгаа мөнгө нь л нэмэгдүүлж байна шүү дээ. Яг Оюу Толгойн тэр гүний уурхай ашиглалтад орсноор манай эдийн засагт өгч байгаа эерэг үзүүлэлт одоогоор гарч байгаа юу?

Тэгээд энэ хоёр дээр тодорхой хариулт авъя гэж бодож байна.

Бусад зүйлийг бид мэдэж байгаа. Нүүрсний хулгайг ил болгож, нүүрсийг шилэн болгох асуудал, Эрдэнэс Тавантолгойн нүүрс тээвэрлэлт, тээвэрлэлтээс олж байгаа татвар гээд энэ бусад зүйлийг харахад ямар ч байсан өнөөдөр нэг тэрбум гаруй валютын нөөц ашиг олсон тухай ярьж байсан л даа.

Гэхдээ энэ бол мэдээж бага мөнгө. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх энэ зорилттой уяад үзэхэд.

Тэгэхээр энэ зүйлүүд дээр тодорхой хариулт авъя гэж бодож байна.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Бид энэ хоёр бичиг баримтыг Та бүгдэд өгч байгаа юм.

Нэг нь, 2024 оны бодлогын тэргүүлэх чиглэл гээд нөгөө төсөв өргөн барихад. Тийм. Гэхдээ үүнийгээ өргөчихсөн. Үүнийг одоо бид хэвлэлтэд оруулчихсан байгаа юм. Өргөөд.

Өнгөрсөн долоо хоногийн тав дахь өдөр өргөчихсөн байгаа.

Энэ төсөв өргөхөд иргэдийн төсөв гээд энгийн үгээр ойлгомжтой болгоод биччихдэг нэг баримт бичиг.

Нөгөөх нь 2024 оны төлөвлөгөөний төсөл гэдэг хоёр бичиг баримт өгч байгаа.

Та бүгдэд өгөгдчихсөн байгаа нь энэ төлөвлөгөө одоо өгөгдчихсөн байж байгаа.

Энэ дээр бараг бүх юм нь бүгдээрээ байгаа юм. Яг ямар төслүүд хэрэгжүүлэх юм бэ гэдгээ энэ дээр бид нэг бүрчлэн заачихсан байгаа. Тухайлбал юу гэдэг юм, Гашуунсухайт-Ганц мод боомтын хил дамнасан нь 18.9 километр холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих, Ханги-Мандал боомтын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийг нь шилжүүлэн ачих терминалыг барих, Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх гээд. Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 километр төмөр зам гээд төсөл болгоноо нэг бүрчлэн биччихсэн байж байгаа. Яг энэ дээрээ.

Энэ төслүүдийг бид хэрэгжүүлнэ гэдгийг Та бүгдэд хэлье.

Бид бас нэлээд сууж үзэж, ярьж байгаад одоо нэгэнт зарцуулах эх үүсвэр нь өөрөө хязгаарлагдмал учраас бодлогын тийм 8 чиглэлийг сонгож аваад тэр дээрээ анхаарал тавьж явна гэдэг зарчим баримталсан байгаа гэдгийг хэлье.

Оюу Толгойн гүний уурхайн хувьд яг л төлөвлөгдсөнийхөө дагуу л үйл ажиллагаа нь явагдаж байгаа.

Тэгээд энэ жил 3 дугаар сард гүний уурхай ашиглалтад орно. Бүтээгдэхүүний хэмжээ нэг иймэрхүү байдлаар нэмэгдэнэ гэдгээ бид 2023 оныхоо төсөвтөө суулгачихсан.

Мөн ялгаагүй 2024 ондоо бүтээгдэхүүний олборлолтын хэмжээг төдий хувиар нэмнэ гээд гаргачихсан байж байгаа.

Тэгээд яг л тэр хэмжээндээ л үйл ажиллагаанууд нь явагдана гэдгийг хэлье.

Бид 2024 онд энэ арга хэмжээнүүдийг авснаар эдийн засгийн өсөлт 6-аас 7 хувийн дотор. Одоо төсвийн хүрээн дотроо бид тоогоо нэлээд нарийвчлаад ярих байх. Эдийн засаг дээр гарна.

Ард иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх зорилтыг тавьж байгаа.

Яагаад энэ дээр бид өрхийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагыг онцгой анхаарал тавиад байгаа юм бэ гэхээр Монгол Улсын хэмжээгээр нийт өрхийн орлого 0.2 хувиар буучихсан байгаа шүү дээ. Ялангуяа хөдөөгийн иргэдийн орлого бодитоор 15.6 хувиар уначихсан байж байгаа. Өрхийн орлого.

Тэгэхээр нийгэмд энэ нь өөрөө тодорхой хэмжээний зорилтууд тавьж байгаа.

Тэгэхээр ерөөсөө л бүх бодлогоо л иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бодлогыг л авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Төслүүд бүгд энэ дотор нэр усаараа байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Нэмж хариулах уу? Ажлын хэсгээс. М.Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Өрхийн орлогыг нэмэгдүүлэх асуудал одоо бүр нэгийн нэг номер байгаа гэдгийг хүн бүхэн мэдэж байна. Тэгээд энэ дээр бас жоохон удаащралтай байна л даа.

Өнөөдрийн статистикийн мэдээллээс харахад бодит нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар жишээ нь өрхийн сарын дундаж орлого буурсан гээд л үзүүлэлтүүд гарч байна.

Тэгээд бид нарыг иргэдтэй уулзахад та нар маш их хулгай ярьж байна. Зөв. Хулгайгаа ярьж байна. Гэхдээ бид нарын хармаатай холбоотой, орлоготой холбоотой асуудал дээрээ шуурхай арга хэмжээ аваач ээ гээд бүгд ярьж байна лээ.

Тийм учраас би танаас яг одоо тодорхой төсөл нь ямар байна вэ гэж асууж байгаа. Эдийн засгийн байнгын хороогоор ирэх оны чухал хөгжлийн бодлогоо оруулж ирэхэд бид хэлэлцсэнийхээ дараа гар дээрээ материал авахаар л болж байх шиг байх юм.

Тэгээд энэ тэртэйгээ танилцах цаг энэ дээр өгч байгаад бас Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийнхээ саналыг сонсоод, чухал зүйлүүд байвал тусгаад, тэгээд хамтраад Улсын Их Хурал,

Засгийн газар амьдралд хэрэгжих, жинхэнэ өрхийн орлогод бодитойгоор нөлөөлөөд. Буурсан биш өссөн гээд сууж байх тийм л бичиг баримт гаргамаар байна даа.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн санал хэлчихлээ. Тийм үү. Сүүлийнх нь.

Б.Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энэ материалыг дөнгөж сая 2 цагийн өмнө л авлаа. Тэгээд маш их уншиж юм яримаар юм байх юм. Тэгээд одоо тийм боломж бүрдсэнгүй.

Тэгээд энэ чинь одоо хэдийд барих хугацаа, цагтай юм. Тэгээд яагаад ингэж тулгаж оруулж ирж байгаа юм. Юм юм байна даа.

Хэд хэдэн асуултууд байна. 184 төсөл, арга хэмжээг 14.3 их наяд төгрөгөөр санхүүжүүлэх юм байна. Энд ажлын байрыг бий болгох чиглэлд та нар яаж тооцож байгаа вэ?

Орлого нэмэгдүүлэх чиглэлд юу гэж бодож байгаа вэ? Ямар тооцоонууд байна гэсэн эхний асуулт байна.

Хоёрдугаарт нь, нүүрсний экспортын хэмжээг 50 сая тонн болгох юм байна. Энэ нүүрсээ угаах чиглэлд, энэ нэмүү өртөг шингээх чиглэлд юм хийх үү? Юм хийхгүй юм уу.

Энэ төмөр замын холболтын төслүүдийг хэрэгжүүлнэ гэж байна. Нөгөө мухар төмөр замуудаа бүрэн холбож дуусах уу гэсэн асуулт байна.

Дараа нь энэ үйлдвэр, технологийн паркуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийнэ. Дарханы арьс, ширний үйлдвэрийн цогцолбор гээд

нэг хэрүүлтэй, маргаантай нэг явдаггүй юм байгаа. Энэ одоо энэ дотор явж байгаа юу?

Дараагийн асуулт. Энэ экспортыг нэмэгдүүлнэ гээд ноолуур, арьс, шир, самар, эмийн ургамал гээд явж байгаа.

Энэ самар экспортолно гэдэг Монголын төрийн бодлого мөн үү, үгүй юу?

Миний ойлгож байгаагаар өнөөдөр 1 килограмм самар бэлтгэхийн тулд 2 мод унагаж байгаа шүү.

Одоо хүмүүс чинь дээр нь гарч түүхээ болиод шууд унагаад авдаг болчихсон. Худлаа гэвэл хойшоо 30 минут нисээд үзээрэй. Дээрээс бүгд харагдаж байгаа.

Энэ зөв юм уу? Үүнийгээ та нар юу гэж бодож байгаа вэ?

Монгол Улс чинь зэсийн 51 хувийг хэрэглэдэг Хятад гэдэг улсын хажууд байгаа шүү дээ.

Оюу Толгой төсөлтэй хамтраад зэсийнхээ баяжмалдаа нэмүү өртөг шингээх чиглэл юм хийхгүй юм уу?

Энэ төлөвлөгөөн дотор шинжлэх ухаан гэдэг юм огт нэг үсэгч алга. Шинжлэх ухаангүйгээр хөгжих юм уу?

Бүтээмж тэг. 22.8 сая төгрөг оногдож байгаа шүү дээ. Нэг хүнд ногдох бүтээмжийн хэмжээ 0.3 хувиар өссөн. Тэгсэн мөртлөө цалин нэмнэ, тэтгэвэр нэмнэ гээд байдаг.

Тэтгэвэр нэмэх эдийн засгийн болзол үндсэндээ хангагдаагүй байна шүү дээ. Нөхцөл хангагдаагүй байна.

Хүний хөгжилд хөрөнгө оруулахгүй байна гээд олон улсын байгууллага бидэнд зөвлөөд байгаа шүү дээ. Хүний хөгжилд хөрөнгө оруулна гэдэг нь нэгдүгээрт эрүүл мэндэд оруулна.

Монголд эрт оношилгоогоор орж байгаа улсуудын бараг 70-аас 80 хувь нь хорт хавдартай гэж оношлогдож байна шүү дээ. Энэ ингээд цаашаа үргэлжлэх юм уу? Эрүүл мэндийн шинэчлэлээр юу хийх юм?

Энэ хувийн хэвшлийн сургууль, төрийн сургууль хоёрын хоорондын ялгаа асар их өндөр болчихсон байна.

Энэ яагаад ингэж байна гэхээр материаллаг бааз нь адилхан. Хүний сэтгэл дутаад байгаа. Боловсролд хөрөнгө оруулах чиглэлд юу хийх юм бэ?

Шинжлэх ухаанд ямар юм хийх юм бэ? Юу ч энэ дээр юм ерөөсөө юу ч харагдсангүй.

Энэ өр, зээлээ багасгах чиглэлд юу хийх вэ? Зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлнэ гэснийг. Монгол Улсын зээлжих хэрэглэлийг хэвээр хадгалж, сайжруулна гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ зээлжих зэрэглэлийг чинь бууруулж байгаа юм Монгол Улсын нийт гадаад өр байгаа шүү дээ. 33.4.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулья.

Ч.Хүрэлбаатар: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Бид хуулиараа 05 сарын 01-нээс өмнө өргөн мэдүүлэх ёстой. 04 сарын 28-нд өргөн мэдүүлсэн байгаа гэдгийг би хэлье.

Тэгээд Улсын Их Хурал өргөн мэдүүлээд дараагийн долоо хоногт нь шууд хэлэлцүүлэгт оруулж ирж байна гэж ойлгож байгаа.

Энэ дээр Засгийн газар бодлогоо тодорхойлоод явж байгаа. Ер нь жил болгон л манайхан газрын хөрсөн доорх баялгаа тэр чигт нь зөөгөөд гаргадаг.

Тэгэхээр боловсруулалтын түвшинг нэмэгдүүлье гэдэг зарчим барьж ажиллаж байгаа. Энэ нь өөрөө энэ бодлогын баримт бичиг дотор суусан байгаа гэдгийг би хэлье.

Тухайлбал, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах гээд. Эрдэнэт үйлдвэр дээрээ төлөвлөгөөндөө юмаа хийгээд, бас тусгаад явж байгаа юм билээ. Оюу Толгойтой ч гэсэн бид энэ чиглэлээр манай яам ажиллаж байгаа.

Тэгэхээр зэс хайлуулах үйлдвэр барьж байгуулах чиглэлээр ажиллаад явж байгаа юм.

Тэгэхээр энэ чиглэлийн ажлууд цаашаа үргэлжлээд хийгдэнэ.

Таны асуусан сая Эрдэнэс Тавантолгой дээр нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. Гангийн үйлдвэр байгуулна, ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулна, хот байгуулна, газрын тос дамжуулах хоолой барих ажлыг үргэлжлүүлнэ, газрын тос боловсруулах үйлдвэрийг үргэлжлүүлнэ зэрэг ажлууд.

Уул уурхай дээр боловсруулалтын үе шат, түвшинг нэмэгдүүлэх ажлуудыг бид жилийн төлөвлөгөөндөө оруулж ирээд явж байгаа.

Дээр нь тэр арьс, шир боловсруулахтай холбоотой зүйл байгаа

юм л даа. Үүнийг нэг хэсэг юу гэдэг юм зөвхөн Дарханы арьс, ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг л барина. Өөр хаана ч юу ч хийхгүй гэдэг бодлого барьдаг. Гэтэл манай хувийн хэвшлийнхэн өөрсдөө хэсэг нь бид Эмээлтэд хиймээр байна гэдэг асуудал тавьдаг.

Тэгэхээр бид Эмээлтээ ч барья, Дарханаа ч барья. Хоёуланг нь оруулж ирж байгаа.

Гэх мэтээр ийм зүйлүүд явагдаж байгаа гэдгийг энэ дээр хэлье.

Ер нь цаашдаа бүх салбарт шинжлэх ухаан орж ирж явах нь гарцаа байхгүй. Шинжлэх ухааны оролцоогүйгээр эдийн засгийн өсөлтүүд бий болж явна гэдэг үндсэндээ өрсөлдөх чадваргүй салбарууд л бий болно гэсэн үг.

Тийм учраас шинжлэх ухаан бол бүх салбар дээр ороод явна. Харин бид нарын хувьд энэ шинжлэх ухааныг яаж бодлого, төлөвлөлтдөө хэрэглэх вэ, яаж энэ салбаруудад нэвтрүүлэх вэ гэдэг дээрээ нэлээд ажиллаж эхэлж байгаа.

Тэгэхээр энэ дээр тодорхой хэмжээний заалтууд байгаа л даа. Их, дээд сургуулиудын магистр, докторын судалгааны сэдвийг төрийн болон хувийн хэвшилд хэрэгцээтэй байгаа судалгаатай уялдуулах, тогтолцоог нэвтрүүлэх, судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүллэг, бүтээл, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг ийм дотоодод байгаа шинжлэх ухаан, технологитой холбоотой, эрдэмтдийнхээ боломжуудыг, чадавхуудыг илүү дайчилж оруулах чиглэлийг нэлээд ярьсан.

Энэ дээрээ бид зүгээр энд тэндээс яамдаас ирсэн саналуудыг хамаад ч юм уу оруулчихсан зүйл биш. Нэлээд бодлогыг боловсруулахдаа бас бодож, хөрөнгө оруулалтаа хаана, юунд нь хийвэл дээр вэ зэрэг иймэрхүү юмнуудыг нэлээд л бодож хийсэн байгаа гэдгийг хэлье.

Зүгээр боловсролын хувьд бид ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиуд дээр ажлууд явагдаж байгаа. Ялангуяа энэ дээрээ бид техник, мэргэжлийн сургуулиуд, мэргэжлийн сургалтуудыг илүү онцгой анхаарал тавьж явах нь илүү л.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээгч 3 номер. Ажлын хэсгийн 3 номер. Б.Бат-Эрдэнэ сайд нэмж хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс самрын экспортоор нийт тоон үзүүлэлтийг авах юм бол дээгүүр тооцогдохоор хэмжээний үзүүлэлттэй.

Олон улсын зах зээл дээр 24-өөс 50 доллароор худалдаалагддаг самар маань Монгол Улсын хэмжээнд 1.5-аас 14 долларын хооронд худалдаалагддаг. 2021 онд дундаж нь 6.6 орчим доллартой байсан. 2022 онд 12.7 орчим долларт хүрсэн.

Хуш модтой холбоо бүхий асуудал дээр бид бодлогын шийдвэрүүдийг гаргаж байгаа.

Монгол Улсад яг энэ боловсруулах 20 орчим үйлдвэр байгаа. Энэ үйлдвэрүүдэд зөвхөн самар бэлтгэх зөвшөөрлийг олгох. Цаашлаад бид хуш модоо авч хамгаалж авч үлдэх, зохистой харьцааг хадгалах гэдэг утга агуулгын хүрээнд л явуулж байгаа.

Ер нь самар бид нийтдээ 24-өөс 50 зах зээлийн ерөнхий үнэлгээгээр гаргаж чадах юм бол жилдээ 360 орчим сая ам.долларыг төсөвт төвлөрүүлэх боломжтой.

Одоогоор ерөнхий явж байгаа дүнгээр нэг 90 орчим сая долларыг төвлөрүүлдэг гэсэн ийм тоон мэдээлэл байдаг.

Бид цаашдаа самрын зохистой хэрэглээг барих. Нөгөө талдаа модоо аварч, хамгаалж авч үлдэх тухай асуудал.

Гуравдугаарт, аж ахуйн нэгжийг хамаагүй хүссэн аж ахуйн нэгж болгонд өгөх гэхээсээ илүүтэй боловсруулах үйлдвэртэй ийм аж ахуйн нэгжүүдэд өгч, хяналтыг тавьж, хамтын ажиллагааны хүрээнд ажиллуулах. Самарт бэлтгэхээр хөлсөлж байгаа тухайн орон нутгийн иргэдийг үнэмлэхжүүлэх, хариуцлагажуулах, аж ахуйн нэгжүүдийг мөн гэрээгээр хангах гэдэг албан ёсны шаардлагуудыг тавьж байгаа.

2023 оны хувьд ялангуяа самрын болц бүрдээгүй байхад 9 дүгээр сараас авхуулаад унагаадаг энэ систем, ялангуяа тэр мунаар нь нүдэхтэй холбоо бүхий асуудал байдаг юм.

Тэгэхээр энэ дээр бид аль болох 10 сар гаргаж байж самбар бэлтгэх ажил руу оруулах төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Өнөөдөр хэлэлцэх асуудлыг нь шийдэх юм байна. Хэлэлцээд явах нь зүйтэй. Үүнийг явц дунд нь тодруулах янз бүрийн асуудлууд их байна.

Ж.Бат-Эрдэнэ сайд энэ самар дээрээ сайн тооцоо хийгээрэй.

Монгол Улсын нийт газар нутгийн 8 хувь нь ногоон ой модтой гэж ингэж үздэг. Үүнээс маш өчүүхэн хувь нь самар ургадаг хуш гэдэг мод байдаг юм гэнэ лээ шүү. Би нарийн юмыг нь мэдэхгүй л дээ.

Тэгээд сүүлийн үед яаж байна гэхээр зэрэг хятад хөрөөтэй очоод энд тэнд отоглосон улсуудын юун дээр хятад гөрөөний сэлбэгүүд маш их хэмжээгээр хаячихсан. Мод унагаад. Тэгээд ингэж байгалиа сүйтгэж 50, 60 сая доллар олох уу, олохгүй юу. Энэ тэрийгээ тэр экологийн үнэлгээ, хэчнээн га-д хамаарсан байдаг юм. Одоо ихэнх ойн маань үхэж байна шүү дээ. Сибирийн хүр гэдэг хорхой идээд дуусаж байгаа. Энэ тэрийгээ сайн тооцож яагаарай. Би чуулган дээр асууна шүү. Хуш модны самар их болгоомжтой хандахгүй эндээс.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Б.Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Төслийг дэмжиж байгаа. Хэлэлцэхийг. Хоёр асуулт байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурал, Засгийн газар ер нь 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт орж байгалийн баялгийн үр өгөөжийг нийт ард түмэнд хүртээх чиглэлээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан.

Үүнийг гол амилуулах өмчийн багц реформ Улсын Их Хурал дээр хийгдэхээр хүлээгдэж байгаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулиуд Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн баригдаж, Улсын Их Хурал

хэлэлцэгдэхийг нь шийдэж, Улсын Их Хурлын даргын захирамжаар миний бие ахлаад, манай Улсын Их Хурлын 10 гаруй гишүүд орсон нэлээн том ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа.

Ажлын дэд хэсэгт 50 гаруй хүнтэй. Ер нь бүхэлдээ 60 гаруй хүнтэй нэлээн том ажлын хэсэг ажиллаж байгаа.

Хаврын чуулганаар энэ өөрчлөлт явна гэсэн хүлээлттэй. Бид ирэх долоо хоногос эхэлж ер нь ажлын хэсгээрээ шууд вакуумжиж ажиллахаар төлөвлөгөөгөө гаргаж ажиллаж байгаа юм.

Тэгэхээр энэ төлөвлөгөөний засаглалын бодлогын 7.2.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэсэн ийм зорилт тавьсан байгаа. Энэ бодлогыг дэмжиж байгаа.

Тэгэхээр нэг тодруулах асуулт байгаа юм. Энэ заалт явснаараа эрх зүйн орчин хүлээгдэхгүйгээр жишээлбэл Засгийн газар төрийн өмчийн компаниудын хувьцааг олон нийтэд гаргах ажлыг хэрэгжүүлээд явах гэж байна уу? Эсвэл одоо байгаа хүчин төгөлдөр хууль, эрх зүйн орчиндоо явах гээд байна уу гэсэн нэг тодруулах асуулт байгаа юм.

Яагаад тэгж асууж байна вэ гэхээр төрийн өмчит компанийг хувьчлах шийдвэрийг Улсын Их Хурал гаргаад байгаа юм. Одоо хүчин төгөлдөр хуулиар. Тэгсэн мөртлөө хувьцааг олон нийтийн болгох асуудал Их Хурлаар орохгүй өнөөдөр ийм хуультай яваад байгаа юм.

Тэгэхээр Их Хурлаар оруулахгүйгээр хувьцааг олон нийтэд хөрөнгийн биржээр гаргах гэдгээр

магадгүй хувьчлал бас явуулчих боломж өнөөдрийн хуулиар байгаа.

Тийм учраас би үүнийг Засгийн газар юу гэж харж байна вэ гэсэн эхний асуулт байгаа юм.

Хоёр дахь асуултын тухайтад одоо Та бүхний өнөөдөр гар дээр 3 том судалгааны баримт бичгийг гишүүдэд тараасан байгаа. Манай ажлын хэсгээс.

Энэ бол газар болон өмчтэй холбоотой суурь судалгааны материалуудыг тараасан юм. Хэвлүүлж. Гишүүддээ.

Тэгээд энэ бүх ажлын хэсгийн гишүүддээ бас тарааж байгаа юм.

Энэ нь яаж явж байна вэ гэхээр ер нь энэ жоохон судалгаатай. Өмчийн реформ нөгөө суурь реформ учраас. Тэгээд төрийн өмчийн компанийн хувьцаа гэдэг маань саяын хэлсэн байгалийн баялгийг ард иргэдэд хүртээх хамгийн суурь реформ болох учраас нэлээн тооцоо, судалгаатай хандах шаардлага байгаа.

Тийм учраас судлаад үзэхээр өмчийн маань суурь нь газар байгаад байна.

Ер нь төрийн өмч гэдгийн 98 хувь нь газар байгаад байгаа юм.

Тэгэхээр Засгийн газар. Ц.Даваасүрэн сайд хааччихав. Газрын багц хуулиа татаад авчихсан. Энэ хэзээ буцаж оруулж ирэх вэ?

Өөрөөр хэлбэл Газрын багц, Өмчийн багц, Компанийн хууль гэдгийг ер нь хамтдаа ярь.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

7.2.1.2-т байгаа төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэрэгжүүлнэ гээд.

Энэ бол 2024 оны жилийн төлөвлөгөө. 2024 оны.

Тэгэхээр хууль эрх зүйн орчин 2023 ондоо шинэчлэгдээд батлагдчихна гэж бодож байгаа.

Шинэчлэгдээд батлагдчихвал шинэчлэгдээд батлагдсан хуулийн дагуу явчихна.

Хэрвээ тэр хууль батлагдаж чадахгүй бол одоо байгаа хуулиараа бид үүнийгээ хэрэгжүүлээд явчихна гэж бодож байгаа.

Ер нь төрийн өмчийн тодорхой хэмжээний хувьцааг олон нийтэд санал болгохдоо бид дандаа Улсын Их Хурлаар оруулж шийдвэрийг гаргуулж байгаа. Үндсэн чиглэл. Бүх асуудлууд дээр.

Тэгээд Их Хурлаар оруулж шийдвэр гарсны үндсэн дээр хувьцаануудыг тодорхой хэмжээний хувийг нь олон нийтэд ил болгох, худалдах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа гэдгийг хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Б.Энхбаяр гишүүн нэмж асуулт асуух уу? Тодруулж асуух уу? Ажлын хэсгээс нэмж хариулах.

Ц.Даваасүрэн сайд гараад явчихсан байна. Тэгвэл орж ирэхээр нь асуугаарай.

Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Хөгжлийн төлөвлөгөө дээрээс гадаад худалдааны чөлөөт хэлэлцээрүүд байгуулна гэсэн юмнууд маш зөв зүйтэй саналууд байна гэж харж байна.

Тэгээд яах вэ, энэ чөлөөт хэлэлцээрүүд явбал харин судалгаа сайтай байх ёстой болов уу гэж бодож байна. Энэ нөгөө стандартын шинэчлэлтүүд давхар хамт хийгдэх ёстой. Нөгөө чөлөөт хэлэлцээр хийж байгаа оронтойгоо.

Энэ дээрээс би нэг юм асуух гээд байгаа нь сая өнгөрсөн долоо хоногт эрчим хүчний салбарын асуулгыг Улсын Их Хурлын чуулган дээр хэлэлцсэн. Эрчим хүчний хангамжийн асуудлыг.

Тэгээд яах вэ, Эрчим хүчний яамнаас өгч байгаа мэдээллүүд нь харахаар ихэнх нь дандаа нөгөө нүүрсээр галлах цахилгаан станцуудын мэдээллийг өгсөн. Тэгээд тэр дээрээ хөгжлийн төлөвлөгөөндөө ч яваад байдаг. Тэгсэн мөртлөө тэрнийх нь санхүүжилт нь гадаадаас босох боломж нь хомс гэж харагдаад л байгаа юм л даа.

Тэгээд тэрийг болохоор босгоно л гээд байгаа юм. Тэгээд гадаадын зээл, тусламжаар бас заримыг нь хийнэ л гээд байгаа юм.

Тэгэхээр дэлхийн бараг 40 орны банкууд чинь санхүүжилт олгохгүй гээд гаргаад ирчихсэн.

Тэгэхээр цаашдаа хэрвээ тэр нүүрсээр галладаг цахилгаан станц барья гэвэл улсын төсвөөс хөрөнгө оруулалтыг шийдэх хэрэгтэй болно л гэсэн үг. Түүнээс биш гаднын зээл, тусламжаар

хийх боломж нь хомс юм гэж харж байгаа юм.

Тэгээд энэ тал дээр 2024 онд нэлээн олон төслүүд тусгагдсан байна л даа. Эд нар тэгээд яг явах боломжтой юу гэдэг асуудлыг асуух гэсэн. Тухайлбал III цахилгаан станцыг 325 мегаваттаар өргөтгөнө гэгчигсэн байгаа. Энэ дээр гадаадын зээлээр хийнэ гэгчигсэн байгаа байхгүй юу.

Тэгээд энэ дээр би гадаадын зээл олдоно гэдэгтэй жоохон эргэлзээд л байх юм.

Хоёрдугаар асуудал нь, Улаанбаатар төмөр замын вагон шинэчлэлтийн асуудлыг шийдэж, вагонуудыг нь цахилгаантай холбох ч байдаг юм уу, иймэрхүү шийдэл хийхгүй бол. Одоо төмөр замын сүлжээ нь өргөсөөд байдаг. Тэгээд бид экспортоо нэмэгдүүлнэ гээд байдаг. Вагон нь хуучирчихсан, толгойнууд нь хуучирчихсан. Тэгээд хоёр орны 50, 50 гэсэн байдлаар хамтарчихсан болохоор шинэ хөрөнгө оруулалт нь ч шийдэгддэггүй. Тэгээд нэгнийгээ хараад суугаад байдаг. Нэг ийм нөхцөл байдалтай байгаад байгаа юм.

Тэгээд энэ тал дээр ер нь цаашдын өмчийн харилцаанд ямар өөрчлөлт орох талаар танаас асууцихмаар байна.

Гуравдугаарт, ирэх жилийн ерөнхий төлөвлөгөөг харах юм бол 24 тэрбум долларын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй болох юм байна.

Ойролцоогоор 6800 мянган долларын нэг хүнд оногдсон бүтээгдэхүүнтэй болох юм байна гэж харагдаж байна.

Тэгээд яах вэ, бодит орлого маань яг энэ 6800 доллартой тэнцэхүйц

хэмжээний бодит өрхийн орлого тэр хэмжээгээр нэмэгдэж чадах уу? Эсвэл ганцхан улсын төсөв яг тэр хэмжээгээр нэмэгдэх гээд байна уу?

Өрхийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр яг ямар ямар ажил хийгдэх вэ гэдэг ийм гурван асуулт асуучаад дараа нь тодруулъя.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Улаанбаатар төмөр замтай холбоотой шинэчлэл.

Энэ дээр бодлого их олон сарниж явсан л даа. Богд хаан гэдгийг юу гэдэг юм Бодь компани барина гээд гэрээ байгуулаад л явдаг.

Тэгэхээр нөгөө Улаанбаатар төмөр зам нь хэрвээ Бодь төмөр замаа барих юм бол энэ дээр холболтын цэг бид уучлаарай амжихгүй. Яагаад гэвэл өндөр өртөгтэй баригдаж байгаа тохиолдолд төмөр замын тээврийн хөлс, үнэ нэмэгдэнэ гэдэг. асуудал тавиад энэ нь үндсэндээ гацаатай байсан.

Тэгээд сая Оросын Холбооны Улсад очиж энэ асуудлын талаар бас ярилцсан. Улаанбаатар төмөр зам 50, 50 хувийг эзэмшээд явж байгаа.

Тэгэхээр Улаанбаатар төмөр замын тэр Богд хаан төмөр зам болон Улаанбаатар төмөр замын шинэчлэлийн асуудлыг Улаанбаатар төмөр зам өөрөө санхүүжүүлэх учиртай. Улаанбаатар төмөр зам өөрөө санхүүжүүлэхийн тулд яах ёстой вэ гэхээр ашигтай ажиллаж эхлэх, бизнесийн зарчмаараа ажилладаг болох хэрэгтэй.

Түүнээс биш юу гэдэг юм тарифаа аягүй хямдхан тогтоочоод, байгаа вагонуудаа хувийн хэвшлийнхэнд өгч

түрээслүүлчхээд 4 дахин өндөр үнээр явуулаад тэгээд нэг захын нэг хурган даргынх нь гэрээс 7 тэрбум төгрөг гарч ирээд байдаг ийм нөхцөл байдлыг бид халах ёстой шүү дээ.

Тэгэхээр тарифын зөв тогтолцоог л нэвтрүүлээд Улаанбаатар төмөр зам өөрөө ашигтай ажиллаад эхлэх юм бол энэ дээр санхүүжилтүүд хийгдэх юм байна лээ. Тухайлбал, энэ дээр Газпром банкны хувьд энд санхүүжилтийг хийх бүрэн бололцоотой. Шинэчлэлтэй нь. Одоо юу байдаг юм. Одоо бол Улаанбаатар төмөр зам чинь 30 сая тонн ачаа жилд тээвэрлэж байгаа бол үүнийг 60 болгох боломжтой юм билээ.

Тэгэхээр Улаанбаатар төмөр замын бизнесийн ном журмаар нь ажиллуулъя. Тэгээд тэр дээр нь ашигтай ажиллаад эхэлбэл үүнийгээ бизнесийн журмаар санхүүжүүлээд явах бүрэн боломжтой юм байна гэж үзэж байгаа.

Тэгээд оросууд 50 хувиа хариуцах байх. Монголчууд 50 хувиа хариуцаад явчихвал энд шинэчлэлийн ажлууд энэ 2024 онд эхэлнэ гэж бид үзэж байгаа.

ТЭЦ-III-ын хувьд ер нь энэ эрчим хүчний үнэ дээр өөрийн чинь тэр чуулган дээр асуусан асуулт болон тэр явц дунд яригдсан зүйлүүдийг бүрэн дэмжиж байгаа.

Ер нь цаашдаа Монгол Улс өөрөө энэ карбон carbon-neutral буюу zero гэдэг баланс барихгүй санхүүжилт хэзээ ч орж ирэхгүй.

Тэгэхээр чиглэл ийшээгээ явна. ТЭЦ-III дээр урьд нь бас хийхээр яригдаж байгаад Оросын Холбооны Улсаас үүнийг хийе гэдэг санал тавигдаад санхүүжилтийнх нь санал нь ирсэн юм.

Тэр нь манай Улсын Их Хурлаар оруулж батлагддаг зээлийн шаардлагыг хангахгүй байгаа юм. Улсын Их Хурлаар зөвхөн хөнгөлөлттэй зээл орж батлагддаг. Тэгвэл энд орж орж санал болгож байгаа нь арилжааны зээл байгаа учраас энэ нь боломжгүй юм байна гэдгийг сая очиж ажиллахдаа энэ дээр Оросын холбогдох байгууллагын хүмүүсүүдэд нь хэлчихсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр цаашдаа яриа ахиад үргэлжилнэ. Өөрийн чинь хэлж байгаа, санаа зовниж байгаа зүйлтэй санал нэг.

Гэхдээ Улаанбаатар хотын дулааны асуудлыг бид зайлшгүй шийдэхээс өөр аргагүй шүү дээ. Дулааныг.

Тэгэхээр энэ дээр одоо яг энэ туссан хэлбэрээр буюу тэр нүүрсээр ажилладаг станцыг бид сэргээж шинэчлэхээс өөр гарц бидэнд бага байгаа. Дулааны асуудал цаана нь эрчим хүчнээс илүү чухлаар тавигдаж байгаа гэдгийг би хэлмээр байна.

Дараагийн асуудал өрхийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд юу хийх вэ гэж.

Үндсэндээ өрхийн орлогыг бид халамж ч юм уу, төсвөөс мөнгө өгөөд нэмэгдүүлнэ гэхээсээ илүүтэйгээр бид эдийн засгийг тэлж, ажлын байрыг бий болгох замаар хүмүүсийн цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлогыг барих.

Дээр нь тэр хөдөө аж ахуй гээд л ингэх чинь.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Нэмэх үү? Ч.Хүрэлбаатар та нэмж хариулах уу? Нэмж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Хөдөө аж ахуйн салбарт. Одоо сая би түрүүн хэлсэн. Өрхийн орлого хамгийн их унасан хэсэг бол хөдөөгийн иргэдийнх. Бодитоор 15.6 хувиар 2022 онд уначихсан байж байгаа. Хөдөөгийн иргэд.

Тэгэхээр энэ чиглэлээр яах вэ гэхээр бид үндсэндээ сая тэр арьс, шир гаргахыг хориглох ч юм уу, эсвэл зөвхөн самнасан ноолуур гаргана гээд. Болохгүй, хаана, хорино гэдэг ийм сэтгэхүйгээр хандсан зүйлүүдийг бид ерөнхийдөө энэ дээр өөрчилсөн юм.

Тэгээд хөдөө аж ахуйн салбар дээрээ санхүүжилтийнхээ схемүүдийг, дотацийн схемүүдээ ер нь шинэчилж салбар болгоны эдийн засгийн бодлогыг зөв болгох, хамгийн үр ашигтай хэлбэр лүү нь шилжүүлэх чиглэлийн ийм бодлогуудыг бид энэ дээрээ томъёолж оруулж ирсэн байгаа.

Ингэж чадах юм бол бид үндсэндээ одоо дөнгөж дээшээ өндийгөөд явж байгаа эдийн засгийн сэргэлт цаашдаа 2024 онд.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Тодруулж нэмэлт асуулт асууя. Х.Ганхуяг гишүүн нэмэлт асуулт.

Х.Ганхуяг: Тийм. Би харин яг эрчим хүчний холбоотой асуудлаар хэлээд байгаа юм. Энэ чинь дандаа бүгдээрээ гадаадын зээл бусад эх үүсвэр, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэлээр гээд тавьчхаад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ дээр магадгүйгээр улсын төсвөөс яг тэр дулааны станцтай холбоотой юмыг нь тавьж өгөхгүй бол ингээд бүгдээрээ гацах магадлал дарагдаад байгаа байхгүй юу.

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэлсэн ч гэсэн нөгөө хувийн хэвшил чинь яах вэ гэхээр гэрээгээ хийчхээд гадаадын банк, санхүү дээр очно. Нөгөө тал нь санхүүжилт өгөхгүй л гэнэ.

Тэгээд зарим нэг зүйлүүд нь уриа лоозонгийн шинж чанартай болчих вий. Та энэ дээр нэг анхаараарай гэж хэлэх гэсэн юм.

Хоёрдугаарт, нөгөө сангуудтай холбоотой энэ Аялал жуулчлалын хууль одоо яг Улсын Их Хурал дээр хэлэлцэгдээд явж байна л даа. Тэгээд бид тэр дээр нь сангийн асуудлыг аваад хаячихсан байгаа юм.

Тэгэхээр бид аялал жуулчлалыг дэмжинэ гээд 3 жил аялал жуулчны дэмжих жил болгоод зарлачихсан. Тэгээд энэ тал дээр бас та төсөв дээр ер нь ямар онцлох.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Энэ дээр тусгагдсан эрчим хүчний төслүүд нэг бол концессоор гэрээг нь өгчихсөн. Бид нараас өмнө нэлээд урт хугацаанд. Жишээлбэл, тэр Багахангайн Бөөрөлжүүт л гэнэ, Багануурын дулааны станц гээд.

Концессын гэрээ нь 2015, 2016 оны үед шийдэгдчихсэн асуудлууд байна шүү дээ.

Тэгэхээр эд нарыгаа бид хэрэгжүүлнэ. Урьд нь гэрээ нь хийгдсэн ажлууд үргэлжлээд явна. Зарим нь олон улс улсын банк, санхүүгийн байгууллагуудаар тэр дамжуулах шугамуудыг барина гэдэг төслүүдийг нь бүгдийг нь оруулаад ярьчихсан.

Өөрөөр хэлбэл ихэнх эх үүсвэрүүд нь баталгаажихсан, батлагдчихсан ийм төслүүд байгаа гэдгийг би хэлмээр байна.

Тэгэхээр хэрэгжилт дээр эрсдэлүүд үүсэхийг үгүйсгэхгүй байна. Гэхдээ яг өнөөдрийн байдлаар яриа хэлэлцээ, тогтчихсон ийм зүйл байгаа гэдгийг хэлье.

Сангийн талаар бас тодорхой мэдээлэл авч байж би хариулт өгье.

Ц.Цэрэнпунцаг: Тодруулж яах уу? Болсон уу? О.Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Ирэх онд 13 их наядын 200-гаад ажил хийх юм байна л даа.

Тэгээд энэ эх үүсвэрүүдийг харахаар яг төрийн оролцоогүй нь үндсэндээ 23 хувь байна л даа. Эх үүсвэр. Бусад нь улсын төсөв зээл, тусламж. Тэгж явснаа төр, хувийн хэвшил болоод.

Яг төрийн оролцоогүй хийгдэх нь. Энэ 13 их наядын 23 хувь нь. Бусад нь ямар нэгэн хэмжээгээр төрийн оролцоотой.

Тэгэхээр эндээс манайх чинь явсаар байгаад төсөв нь бараг эдийн засгийнхаа 40-өөд хувьд хүрчихсэн. Төрийн өмчит компаниуд нь өнгөрсөн хугацаанд улам томроод байдаг. Дахиад дээрээс нь одоо энэ арван хэдэн их наядын 70-аад хувь нь ямар нэгэн хэлбэрээр төрийн өмчийн оролцоотой төсөл, хөтөлбөрүүд.

Тэгээд энэ эдийн засаг чинь одоо ингээд улам төржөөд яваад өгвөл нөгөө үр ашиг, бид нарын барьж байгаа бодлого, зах зээлийн эдийн засаг, энэ олон зүйлээс чинь энэ бодлого чинь бүр нөгөө тийшээ явчих юм биш үү?

Тэгэхээр 2024 оны төлөвлөгөөнд Монгол Улсын төсвийг ер нь. Одоо 37 хувь байгаа билүү? Үүнийг яг яаж бодож байгаа билээ? Нэмэгдэж байгаа юм уу, хасагдаж байгаа юм уу? Ямар бодлого барьж байгаа юм?

Одоо байгаа төрийн өмчит компаниудыг олон нийтийн болгох, хувьчлах. Энэ дээр тодорхой тоо хэлбэл ямаршуу хувь процентын өөрчлөлтийг бодож байгаа вэ? Тэгэхгүй бол энэ чинь олон зөв зүйтэй ч мэдээж сонсогддог олон ажил байна. Дахиад л төрийн оролцоо, төсвийн оролцоо гэдэг зүйл асар ихээр нэмэгдэх нь.

Хоёрдугаарт нь, Хөгжлийн хөтөлбөрийн тэр Хүний хөгжил хэсгээс ч бас харлаа. Тодорхой зүйлүүд харсангүй.

Ер нь энэ эдийн засаг баахан ажил хийгдэх юм байна. Эдийн засаг өснө гэж тооцож байгаа юм байна. Тэгээд хүний нөөцийн бодлого яг хаана явж байгаа билээ? Ажиллах хүчний тооцоог яаж хийж байгаа вэ? Яг одоогийн нөхцөл байдал дээр ер нь энэ хувийн сектор болоод бусад газарт чинь. Төрд ч гэсэн тэр. Гадагшаагаа виз нь олдвол бүгдээрээ дайжчихаар байгаа шүү дээ.

Тэгэхээр яг энэ ажил хийх хүнээ ер нь хаанаасаа яг яаж бодож байгаа билээ.

Тэгэхээр хөдөлмөр оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшний энэ олон зүйл. Хүний нөөц тал дээр яаж тооцож байгаа юм? Яг хүн нь яг байгаа юм уу, үгүй юм уу? Лав л миний мэдэхээр хувийн секторууд, энэ барилга байшин, зам гүүр, олон зүйлүүд дээр лав л хүнгүй л болчхоод байгаа.

Тэгэхээр энэ дээр нэг тодорхой тайлбар өг.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Би сүүлийнх нь тэр хүний мэргэжилтэй боловсон хүчний тухай асуудлаар. Яг ингээд эдийн засгийг цаашаа тэлэх хэмжээн дээр яригдаад эхлэхээр яах аргагүй Монголд хурцаар дутагдаж байгаа зүйл бол энэ боловсон хүчний ажил, хүн нөөц.

Тэгэхээр бид боловсролын салбарыг аваад үзэхээр өнгөрсөн хугацаанд 10 жилийн ерөнхий боловсролын сургуулийнхаа тогтолцоог ярьж байна. Их дээд сургуулиудыг нэлээн сайн ярьж ирсэн.

Тэгэхээр 2024 оны жилийн төлөвлөгөөн дээр хамгийн онцлох зүйл бол боловсролын салбар дээр бид хамгийн гол асуудлыг. Хуучнаар одоо нөгөө ТМС ч гэдэг юм уу, техникум ч гэдэг ч юм уу тэр ойлголтоор.

Нөгөө КООСЕН сургалтын хөтөлбөрийг аймаг бүрд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад нэвтрүүлэх гээд бүр ийм онцгойлон үүнийг оруулж ирж байгаа юм.

Өөрөөр хэлбэл ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиуд дээр явж ирсэн юугаараа яваад тэр бодлого нь явах байх.

Гэхдээ энэ жилийн төлөвлөгөө дээрээ бүр онцгойлон улсын төсөв дээрээсээ ч гэсэн хөрөнгө тавьж анхаарах зүйл бол бид нарын хуучнаар ярьдаг нөгөө ТМС, техникум буюу хүмүүст яг мэргэжлийн ур чадвар өгдөг сургалтуудыг илүү түлхүү хөгжүүлэх төсөл оруулж ирж байгаа юм.

Үүнийгээ хийхдээ бид бусад одоо Солонгос ч байдаг ч юм уу, Япон ч байдаг ч юм уу энэ орнуудад амжилттай хэрэгжсэн тэр хөтөлбөрийг Монголд оруулж ирээд хэрэгжүүлээд нутагшуулаад явуулъя гээд ийм л чиглэлээр энэ дээр оруулж ирсэн байгаа юм. Энэ бас амжилттай Монголд хэрэгжээд явж байгаа юм билээ.

Үүнийгээ бүх аймгуудад жигд оруулж ирж байж боловсон хүчин бэлдэх ажлыг бэлдье гэж байгаа юм.

Улсын төсвөөс санхүүжих төр, хувийн хэвшлийн түншлэл, зээл гээд. Ер нь л Сангийн яамтай, манай яам нэлээд хамтарч сууж ажиллаад энэ санхүүжилтийнхээ схемүүдийг нэлээн сайн бодож гаргасан.

Ер нь төр өөрөө хувийн хэвшил хамгийн сайн хийчих зүйлийг хийхгүй байна. Хувийн хэвшлийг илүү дэмжинэ гэдэг зарчмыг хатуу баримталж байгаа. Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар ер нь төр өөрөө хийх юмаа л хийе. Хувийн хэвшил илүү сайн хийчих зүйл рүү төр оролцохгүй гэдэг бодлогыг хатуу баримталж явж ирж байгаа гэдгийг би хэлмээр байна.

Тэгээд урьд өмнө нь хийгдсэн ажлуудаа дуусгах чиглэлийн зүйлүүдийг энэ дээрээ нэлээд сайн оруулж ирсэн байгаа гэдгийг хэлье.

Тэгээд хувийн хэвшил сайн хийх зүйлүүдийг бүгдэнг нь энэ дээр хувийн хэвшил нь хийнэ гээд оруулаад өгчихсөн байгаа гэдгийг бас хэлье.

Ц.Цэрэнпунцаг: О.Цогтгэрэл гишүүн нэмж асуулт асууя.

О.Цогтгэрэл: Тэр түрүүн төрийн оролцоо ихдээд байна гэдэг зүйлийг л би

хэлсэн л дээ. Энэ чинь өөрөө явсаар байгаад Засгийн газар өнөөдөр авлигатай тэмцэж байна гээд байгаа юм. Үүнийг олон нийт бас дэмжиж байгаа байх. Авлигатай тэмцэх нь зөв.

Тэгэхээр энэ авлигын уг үндэс чинь тэр даргын гарын үсгээр асуудал шийдэгддэг тэр тогтолцоонд л байгаа шүү дээ. Төсөв нь нэмэгдээд байдаг, төрийн өмч нь нэмэгдээд байдаг. Нэг талаараа. Нөгөө талдаа авлигатай тэмцээд байна гээд байдаг. Энэ хоёр чинь яг уг үндэс, язгуур шалтгааныг үзвэл ийм логик зөрчилтэй хоёр зүйл л яриад байгаа шүү дээ.

Яг одоо энэ дээр төрийн өмчийн оролцоо нэмэгдээд байдаг, төсөв нэмэгдээд байдаг. Нэг гараараа авлигыг бид цавчина л гээд байдаг. Энэ чинь одоо сүүлдээ бараг худлаа хэлбэрдэлт. Үнэхээр л авлигыг бууруулъя гэвэл та нарын энэ төсөв, төрийн өмчийн оролцоо л эрс буурвал жинхэнээсээ уг үндэс язгуураараа л буурна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр нэг их тийм яг бодит тоо баримт жаахан харагдахгүй байгаад байгаа нь л харамсалтай байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: О.Цогтгэрэл гишүүн санал хэлчихлээ.

Ингээд Т.Энхтүвшин гэсэн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг дэмжиж байна.

Тэгээд гол асуудлууд ерөнхийдөө орчихсон байж байна.

Ялангуяа энэ боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, боловсруулалтын түвшнийг ахиулах, эрчим хүчний

дутагдлаас гарах, чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, гаднын хөрөнгө оруулалт болон дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих гээд гол зүйлүүд орчихсон байна.

Хамгийн гол нь бид хэрэгжилт дээр нь их сайн анхаарах ёстой юм болов уу л гэсэн бодолтой байна. Ялангуяа гаднын хөрөнгө оруулагчдыг яаж татаж оруулж ирэх вэ, дотоодын хөрөнгө оруулагчдаа яаж дэмжих вэ. Ялангуяа хүрэн нүүрсний ордууд дээр чинь олон компаниуд цахилгаан станц барина гээд зөвшөөрөл авчихсан байдаг юм билээ шүү дээ.

Тэгээд яагаад одоо хүртэл энэ хүмүүс юу гэдэг юм цахилгаан станц барихгүй байна вэ гэдэг дээр нэлээн анализ хийж судалгаа хийх ёстой юм болов уу л гэсэн бодолтой явж байна.

Чөлөөт бүс байж байна. Мөн л ялгаа байхгүй Монгол Улсын Засгийн газар хариуцсан ажлаа 2021 онд л бид нэг дулааны станцаа ашиглалтад оруулсан шүү дээ. Маш олон газрууд авчихсан байж байгаа.

Тэгэхээр энэ хүмүүсээ дуудаж татаж уулзаад санаа бодлыг нь сонсоод хөрөнгө оруулалтыг нь яаж оруулах вэ, яаж дэмжих вэ гэдэг асуудал дээр дэмжээд ажиллавал энэ төлөвлөгөө нэлээн дэмжигдээд явах болов уу л гэсэн бодолтой явж байна.

Тэгээд гол зүйлүүд ерөнхийдөө орсон байна. Тэр арьс, ширний үйлдвэр дээр ч гэсэн санал нэг байна.

Үнэхээр Дархан гэхээсээ илүү юу гэдэг юм арьс, ширнийг боловсруулах үйлдвэрүүд Эмээлт дээр байвал илүү их зохимжтой юм билээ. Ялангуяа зүүн аймаг, говийн бүсийн аймаг гээд.

Эмээлт дээр ирж тэр арьс, ширээ боловсруулах юм бол илүү бага зардлаар өндөр бүтээмжтэй ажиллах бололцоо боломж байдаг юм билээ.

Тэгээд үүнтэй санал нэг байна.

Боомтын сайдаас хоёр асуулт асууя.

Энэ боомтыг дагасан суурьшлын бүс ер нь Боомтын сайдад ер нь хамаарах юм уу? Хамаарч байгаа юу гэдэг дээр асуулт асууя.

Хоёрдугаарт, боомт доторх замын асуудал ер нь Боомтын сайд ер нь хариуцах уу? Энэ дээр бас нэг хариулт хэлээд өгөөч.

Энэ боомт доторх замыг хийгээд өгье гэсэн гадна дотнын компаниуд бас байж байна.

Боомт руу цахилгаан татаад өгье гэсэн гадна дотнын компаниуд бас байгаад байх шиг байгаа юм. Тэгээд яг үүнийг хэн хариуцаж байгаа юм гэдгийг сайн мэдэхгүй. Эрчим хүчний яам руу нэг яваад, Зам тээврийн яам руу нэг яваад. Ингээд эзэнгүй л яваад байх шиг харагдаад байж байна.

Тийм учраас энэ боомтын замын асуудал, боомтын суурьшлын асуудал, суурьшлын бүс рүү татсан цахилгааны асуудал гээд энэ асуудал тань дээр ер нь хамаарч байгаа юу, хамаарахгүй байгаа юу.

Дараагийн асуудал. 2023 онд 3 тэрбум төгрөг боомт дагасан юу гэдэг юм усны асуудлыг шийдэх, боомтын барилга байгууламжийг жоохон сэргээх гээд 3 тэрбум төгрөгийн асуудал тавьж өгсөн. Энэ асуудлаа бас хурдан шийдээд одоо ингээд 5 сар гарч байна.

Энэ Ханги-Мандал байдаг ч юм уу, Гашуунсухайт ч байдаг юм уу энэ газрууд дээр тэр суурьшлын бүс дээр нь худаг усыг нь гаргаж өгөх, усны асуудлыг нь шийдэж өгөх. Ялангуяа бид Ханги-Мандал дээр Хятад Улсаас тог импортоор оруулж ирдэг. Тогны хэрэгцээ нь хүрэхгүй болсон. Тэрний шугамыг өргөтгөх ч гэдэг юм уу, суурьшлын бүс рүү нь татаж өгөх ч гэдэг ч юм уу ийм ажлуудаа яаралтай эхлүүлээд явбал нэлээн үр дүн бас гарахаар байна.

Ер нь боомт руу төр, хувийн хэвшлийн түншлэлээр зам бариад өгье, цахилгаан татаад өгье гэсэн хүмүүс их олон байгаа шүү. Тэгээд энэ асуудал дээр ч гэсэн би бас холбогдох хүмүүсийг тантай холбож өгье. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Боомтын сайд эхэлж хариулах уу? Та хариулах уу? Боомтын сайд Б.Тулга сайд хариулах уу.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр боомтыг дагасан суурьшлын бүс, боомтын асуудал манай сайдын ажлын хамрах асуудал хамаарах уу гэж байна. Би хамаарах байх гэж бодож байна.

Ер нь манай боомтуудын үндсэн байгууламжийг сайжруулах энэ төслүүд хэрэгжээд явж байгаа. Одоо Боомтын сэргэлтийн Үндэсний хороон дээр энэ боомттой холбоотой төлөвлөлтийн асуудал, бүтээн байгуулалтын ажлуудыг ерөнхий төлөвлөгөө гаргаж тэр дагуу хөгжүүлэх шаардлага байгаа.

Энэ төлөвлөгөөг яаралтай гаргаж Боомтын Үндэсний хороогоор хэлэлцүүлээд Засгийн газарт оруулаад, тэгээд хөрөнгө оруулагч нарыг урьж

оруулж явуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг танд хэлье.

Үүнд боомтын суурьшлын бүс, мөн замын асуудал аль аль нь хамаарч орох байх.

Тэр тодорхой боомтууд дээрх усны хайгуул судалгаа, барилга, байгууламжийн сайжруулах асуудлууд энэ хөгжлийн төлөвлөгөөнд тодорхой хэмжээгээр суусан байгаа.

Хувийн хэвшлийн гадна дотнын хөрөнгө оруулагч нар энэ дээр бас ажиллая гэдэг саналаа ирүүлсэн байгаа.

Тэгэхээр үүнийг Үндэсний хороогоороо хэлэлцүүлээд Үндэсний хорооны гишүүн яамд бүгдээрээ саналаа оруулаад нэгдсэн нэг шийдвэр гаргаад цаашаа явна гэж ингэж ойлгож байгаа.

Ханги-Мандал, бусад боомтууд дээр шаардлагатай байгаа эрчим хүчний дутагдал, үүнийг өргөжүүлэх асуудал, усны асуудлыг маш сайн мэдэж байгаа.

Усны хайгуулын төсвүүд, ялангуяа говийн бүсийн төсвүүд 2023 оны төсөвт суусан байсан. Хайгуулын. Харамсалтай нь нөгөө хэмнэлтийн хуулиар бас энэ маань нэлээн танагдчихсан байгаа.

Тэгээд 2024 оных дээр мөн дахин энэ хайгуулын төсвийг суулгасан байгаа гэдгийг танд бас хэлье.

Тэгээд энэ хайгуулын төсөвтэй холбоотой асуудал дээр илүү Эдийн засгийн хөгжлийн яам маань бас хариулт өгөх байх.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя. Нэмж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Т.Энхтүвшин гишүүн хүрэн нүүрсний ордуудтай хүмүүс цахилгаан станц барина гээд яригддаг гэж.

Ер нь санхүүжилт олдохгүй юм билээ. Түүрүүн Х.Ганхуяг гишүүн өнгөрсөн тав дахь өдрөөс хойш л яриад байгаа.

Ер нь хүрэн нүүрс дээр түшиглэсэн цахилгаан станц барина гээд мөнгө олно гэдэг бол ер нь магадлал бараг тэг рүүгээ болчихсон юм байна лээ.

Бид энэ ТЭЦ-III дээрээ л гэхэд өргөтгөл шинэчлэл дээр ч гэсэн энэ дээр бас л нэлээд хүндрэлтэй явах юм байна лээ.

Тэгэхээр одоо энэ хүрэн нүүрсний уурхайг түшиглээд цахилгаан станц барина гэдэг бол зүйл магадлал ер нь муу юм байна гэдэг. Санхүүжилт босгох талаар магадлал маш муу юм байна. Одоогийн бодлого өөрчлөгдөхгүй бол.

Дэлхий нийтээрээ уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэнэ, “ногоон санхүүжилт” гээд явж байгаа үед энэ санхүүжилт ер нь магадлал багатай.

Дараагийн асуулт, чөлөөт бүс дээрээ бид бодлогын хувьд бүр нэг бүрчлэн нарийн авч үзэж байгаа. Тэгээд хилийн цаана байгаа чөлөөт бүстэйгээ уялдуулах маягаар явбал илүү хурдан бөгөөд бодитой үр дүн гарчих болов уу гэсэн бодлоор ажиллаж байгаа. Тэгээд удахгүй бид бас танилцуулга хийнэ.

Эдийн засгийн байнгын хороон дээр.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн хариуд хангалттай гэж үзэж байгаа бол Т.Доржханд гишүүн асуултаа

асууя. Т.Доржханд гишүүн алга байна.
Д.Батлут гишүүн асуултаа асууя.

Уучлаарай..., Т.Доржханд гишүүн.

Т.Доржханд: Тодорхой ганц хоёр л юм асуучихъя.

Ирэх жил чинь Ч.Хүрэлбаатар сайд аа, сонгуулийн жил байдаг. Тэгээд баахан тууз хайчилсан ажил хийгддэггүй юмнууд болчих вий дээ гээд болгоомжлоод.

Тэгээд ингээд харахаар 13.4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт байна гээд. Тэгээд энэ тоо маань яг бодитой байж чадах уу л гэж асуумаар байх юм. Тухайлбал, нийт санхүүжилтийн эх үүсвэрийн 33.4 хувь нь төр, хувийн хэвшлийн түншлэл байна гээд. Тэгээд яг энэ эх үүсвэр нь баталгаажсан буюу гэрээ байгуулсан түвшинд явж байна уу? Төлөвлөлтийн түвшинд явж байна уу? Нэг.

Хоёрдугаарт, 3 их наяд төгрөг буюу 22.8 хувь нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалт гэхчхэн байна. Яг үүнээс гадаадын хөрөнгө оруулалт нь хэд юм? Тэрийг нэг тоо байвал хэлчхээч.

Тэгээд ийм орчинд өнөөдөр гаднаас хөрөнгө оруулна гэдэгт би итгэхгүй л байна.

Одоо ингээд хөрөнгө оруулалтууд чинь энэ бүсээс чинь гараад явчихсан байгаа шүү дээ. Тэгээд хойд бүс чинь дайн байлдаантай байгаа. Өмнөд хэсэг чинь бас цэгцрээгүй байна. Эдийн засгийн нөхцөл байдал нь. Тэгээд үзүүлэлтүүд сайнгүй байгаа. Тэгээд Монголд сонгуулийн жилээр хөрөнгө оруулаад явах тийм эрсдэл хийх үү?

Тэгэхээр гаднын хөрөнгө оруулалт маань бас өөдрөг төсөөлж болж байна уу,

үгүй юу гэдэг дээр нэг тайлбар авчихмаар байх юм.

Аялал жуулчлалыг хөгжүүлнэ гэсэн байх юм. Тэгээд төсөвт арга хэмжээ 24, санхүүжилтийн хэмжээ 654 гээд.

Уг нь КОВИД-ын дараа дэлхий ертөнц хамгийн их анхаарч байгаа юм бол аялал жуулчлал байгаад байдаг. Аялал жуулчлалынхаа салбарт илүү их мөнгө хийж байж илүү их орлого олох прогноз яваад байдаг.

Бусад улсууд аялал жуулчлал руугаа мөнгө хийгээд байдаг. Манайх болохоор яг юунд хийх юм бэ гэдэг дээр л нэг асуудал байгаад байна л даа. Энэ салбарын сайд нь хийх юм уу, яах юм?

Аялал жуулчлалыг хөгжүүлэхгүй байгаа хамгийн чухал зүйл юу вэ гэхээр бүгд мэдэж байгаа шүү дээ. Онгоцны тийзийн үнэ өндөр. Олон улсад нэг цагийн нислэг чинь 100 доллар байдаг. Гэтэл манайд чинь нэг цагийн нислэг наашаа ирэхэд чинь 300 доллар байгаад байна шүү дээ. Өндөр.

Тэгээд агаарын тээвэр нь өөрөө либералчлал байхгүй, өрсөлдөөн байхгүй, үнэ өндөр болохоороо аялал жуулчлал маань хөгжихгүй байгаа нь маш энгийн.

Тэгээд яг энэ чиглэлээр илүү анхаарах ёстой юм биш үү. Илүү тэр урсгалыг нь нэмэх. Тэгээд шаардлагатай бол онгоцнуудынх нь худалдан авалтыг нь нэмэх. Ийшээгээ хөрөнгө оруулалт хийх нь илүү их бодитой аялал жуулчлалын дэмжлэг байх болов уу гэж.

Олон улсад жуулчлалын салбар хөгжсөн тэр дараалал маш энгийн юм билээ шүү дээ.

Эхлээд дэд бүтцэдээ хөрөнгө оруулалт хийгээд боловсон нойлтой байх

эд нар биш. Эхлээд зүгээр л жуулчдыг асгаад бай, асгаад бай, асгаад бай. Хямдхан яриад л асгаад бай. Зах зээлийг бий болго.

Дараа нь түүнийгээ дагаад хувийн сектор нь өөрсдөө хөрөнгө оруулалтаа хийгээд тэгээд аялал жуулчлалын салбарт босож ирдэг дэлхий нийтийн жишиг байна гээд.

Гэтэл Монгол чинь болохоор ингээд хоёр хөрштэй. Одоо ингээд хойд талаас жуулчлах газраар байхгүй, урдаас КОВИД гээд байхгүй. Ганцхан агаарын тээвэр. Тэгээд агаарын тээвэр нь ийм их үнэтэй болохоор аялал жуулчлал чинь явахгүй байна л даа.

Тэгэхээр яг энэ дээр илүү нөгөө хөрөнгө мөнгөө төсөвлөөд нэг зоригтойхон шиг явчаж болохгүй юм уу гэдэг асуулт байна.

Тэгээд манай Хөгжлийн яам маань энэ дээр ямар байдлаар бодлого барьж байгаа юм бэ? Тодорхой гурван асуулт байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Монголд ер нь хөрөнгө оруулагч орж ирэх юм болов уу гэдэг асуулт байгаа.

Би итгэлтэй байгаа. Хөрөнгө оруулагчид Монголыг сонирхсон хэвээрээ л байна гэж үзэж байна. Бид өөрсдөө л жоохон учиртайхан байх шаардлагатай.

Эдийн засгийн бодлогоо зөв явуулдаг, эдийн засгийн тогтвортой байдлуудыг хангадаг, үзүүлэлтүүдээ сайжруулж явдаг, зээлжих зэрэглэл дээрээ анхаарлаа тавьдаг, хууль эрх зүйн

орчнууд дээр анхаарлаа тавьдаг байвал Монголыг сонирхож байгаа.

Монгол Улс өөрөө зэсийн их нөөцтэй улс байна шүү дээ.

Зэсийн томоохон тоглогч болох боломжтой. Газрын ховор ордын боломжтой. Хоёр том зах зээлийн дунд оршиж байна.

Боломж бий. Сонирхлоо илэрхийлж байгаа хөрөнгө оруулагч нар байна. Уулзаж байна, учирч байна, танилцуулгууд хийгдэж байна.

Тэгээд энэ хөрөнгө оруулалтын төрөл бүрийн уулзалтууд дээр ирж сонирхлоо илэрхийлж байна.

Би бол байна. Үүнийг харин бид зөв ашиглаад явах учиртай. Одоо нөгөө үлгэрээ ярьдаг. Өргөн, нарийн цариг барьчихвал урдаас танк ороод ирнэ гэдэг нэг иймэрхүү тэнэглэлүүдийг бид гаргахгүй л байвал Монголд хөрөнгө оруулагч нар орж ирнэ. Орж ирэхэд ч бэлэн байна гэдгийг би энд онцлоод хэлмээр байна.

Нийтдээ концессоор төр, хувийн хэвшил дээр баригдах 17 төслийг оруулж ирээд энд тавьсан байж байгаа. Тухайлбал, Налайх, Замын-Үүдийн чиглэлийн авто зам байж байгаа. 4 эгнээ хурдны зам гээд. Энэ дээр бид оруулж ирж байгаа.

Яагаад вэ гэхээр энэ Орос, Украины тэр дайнтай холбоотойгоор ерөөсөө Ази руу Оросын бүх харилцаа чиглэгдсэн байна лээ.

Тэгэхээр Ази гэхээр Хятад байна, Энэтхэг байна, Пакистан байна, Индонез руу. Тэгээд ийшээгээ явж байгаад бүх урсгал нэмэгдчихсэн байж байгаа үед бид

Улаанбаатар төмөр замаа шинэчлээд авчих бүрэн боломжтой.

Дээр нь энэ авто замаар явах тээврийн хэмжээ эрс нэмэгдэх ийм боломж нь бэлэн бий болчихсон байгаа.

Тэгэхээр бид хүлээгээд суух биш жоохон түрүүлээд санаачилга гаргаад энэ бий болж байгаа боломжуудыг ашиглаад хийх юм бол энэ бүх боломжууд нь байна.

Тийм учраас бид Европт болж байгаа дайн, Европт хаагдсан тэр нөлөөлөл нь Ази руу явах дэд бүтцийг бүрдүүлэх энэ ажлыг бид нэлээн сайн ашиглаж хийх юм бол энэ дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэх ажлууд байгаа юм.

Тэр 17 ажлаас нэлээд нь урьд өмнө гэрээ нь хийгдчихсэн энэ ажлууд үргэлжлээд явах зүйл байгаа.

Улаанбаатар хотын түгжрэлтэй холбоотой зарим нэг концессын гэрээнүүд байгаа. Туул голтой холбоотой, Шинэ тойрог замтай холбоотой зүйлүүдийг бид бас энд оруулж ирээд явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Аялал жуулчлал угаасаа Монгол Улсын хувьд анхаарал тавьж хөгжүүлэх ийм л салбарын нэг.

Тэгэхээр би бол одоо яг л өөрийн чинь хэлдгээр зөв бодлогын дагуу явж байгаа юм болов уу. Эхлээд тэр визүүдийг чөлөөлж байна. Хүмүүсийг орж ирэх боломжийг нь хангаж өгч байна.

Тэгээд энэ дээрээ үндэслээд аялал жуулчлал хөгжих боломжийг нь л бид хангаж өгч явна гэдэг тэр зарчмын дагуу бодлогууд явагдаж байгаа.

Тэгэхээр аялал жуулчлалын салбараар сайд байгаа. Нэмээд хариулаад явах байх.

Ц.Цэрэнпунцаг: Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя. 3 номер.

Б.Бат-Эрдэнэ: Т.Доржханд гишүүний асуултад хариулъя.

05 дугаар сарын 01-ний байдлаар 140 мянган жуулчин ирсэн.

Сая Ч.Хүрэлбаатар сайдын хэлсэнчлэн бид визгүй болгох, таны хэлсэнчлэн аль болох асгах гэдэг энэ бодлогыг барьж ажиллаж байгаа.

Өнгөрсөн хугацаанд ирсэн 140 мянган жуулчны 75 хувь нь визгүй орнуудаас ирсэн байгаа. 21.9 хувь нь визтэй орнуудаас ирсэн. Боомтын хувьд Чингис хаан боомтоор нийт 33.7 хувь, Алтанбулагийн боомтоор 22.6 хувь, Боршоогийн боомтоор 18.8, Замын-Үүдийн боомтоор 13.9 гэх мэтчилнээр гээд бүх боомтуудыг бид аль болох боомтуудаар жуулчдыг хүлээж авахтай холбоо бүхий асуудал дээр ажиллаж байгаа.

Боомтын сайд маань бас энэ дээр дэмжиж ажиллаж байна.

Нийт ирсэн зорчиж байгаа улсуудын хувьд мэдээж Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас орж ирж байгаа жуулчид дээр бид маш сайн анхаарах ёстой.

Таны хэлсэнчлэн автомашинаар зорчих боломжоор хангах.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас зөвхөн автобусаар, жуулчны автобусаар нэвтрэх энэ боломжийг өнгөрсөн хугацаанд байсан. Үүнийг хэвээр үргэлжлүүлэхээр бид Гадаад

харилцааны сайд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох талуудтай хөндөөд яриад явж байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас автомашинтай ороод хил орчмын аялал жуулчлал дамжаад гарах нэг. Нөгөөдөх нь “Цайны зам” буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол, Оросын Холбооны Улс гэсэн энэ “Цайны зам”-ыг эргэн сэргээх асуудлыг бас албан ёсоор хөндөөд явж байгаа.

Энэ бол Монгол Улсад бас ашигтай гэж тооцогдож байгаа.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд бас таны хэлсэнчлэн КОВИД-той холбоотой эргэн сэргэлт 100 хувь биш байгаа. Цэнхэр, ногоон үнэмлэхтэй холбоо бүхий асуудал байдаг.

03 дугаар сарын 06-ны өдөр Гадаад хэргийн яамнаас нот бичиг явуулсан. Гадаад харилцааны сайд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад айлчилж байгаа. Яг энэ асуудлыг давхар хөндөөд явж байгаа.

Хэрвээ визгүй цэнхэр үнэмлэхээр орж ирэх боломж бүрдэх юм бол.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Т.Доржханд гишүүн нэмэлт асуулт асууя.

Т.Доржханд: Зөв зөв.

Тэгэхээр миний асуулт нь хөрөнгө мөнгөө илүү төвлөрүүлээд зоригтойгоор агаарын тээвэр лүүгээ зарцуулахгүй юм уу гэдэг асуулт байгаад байгаа юм. Тийм.

Тэгээд тэр нэг өдрийн аялал гэж байдаг юм байна лээ шүү дээ. Тийм ээ. Тухайлбал, манай Хэнтий, Сүхбаатарын урдхан талд Рашаантын нэг халуун усны рашаан байдаг. Тэнд зундаа 10 сая хятад

хүн ирдэг гэж байгаа байхгүй юу. Тэндээс нэг саяыг нь аваад л нэг өдөр нэг морь унуулаад л, хорхог чулуу л бариулаад л явах юм бол нэг хүнээс тухайлбал хамгийн багадаа 100 доллар болох боломж байна гээд.

Гэх мэтчилэн мөнгө олох юман дээрээ Та бүгд маань яаж төлөвлөж байна вэ?

Тэгээд тэр агаарын тээвэр маш чухал байна. КОВИД-ын нөлөө аялал жуулчлалын boost хийгээд байгаа байхгүй юу. Тэгээд бүгд энэ дээр бэлдээд байгаа. Бүгд дэлхий ертөнц рүү аялах гээд байдаг.

Тэгээд Монгол бол өөрөө аялах асар тийм давуу талтай. Нүүдлийнхээ соёл иргэншлийг 20 хувьдаа авч үлдсэн улс шүү дээ.

Гэтэл Америк бол мөнгө төлж байгаад.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулья.

Дараа нь Б.Бат-Эрдэнэ сайд гүйцээж хариулаарай. Ч.Хүрэлбаатар сайд хариулья.

Ч.Хүрэлбаатар: Би Т.Доржханд гишүүнтэй 100 хувь санал нэг байна.

Монголд нисье, компани байгуулья гэдэг хүсэлтүүд чинь зөндөө л ирдэг юм байна лээ.

Тэгээд тэрийг нь өгдөггүй. Эдийн засаг, хөгжлийн яам болсон чинь манай дээр тэр компаниуд гомдол ирүүлж байгаа юм. Ачаа тээвэр хийе, энэ чиглэлүүд рүү нисье гэдэг хүсэлт ирэхээр дарчихдаг. Тэгээд өгдөггүй ийм л юм байна лээ.

Тэгээд гуйлгадаг. Иймэрхүү хүмүүсийг зүгээр ажлаас нь чөлөөлөөд л явчихвал.

Монгол Улс өөрөө жижигхэн улс. Маш жоохон сэргэнэ шүү дээ. Эдийн засаг. Би бол иргэний агаарын тээвэр дээр зүгээр орж ирж хүсэлтээ ном журмын дагуу хүсэлтээ тавьчихсан байхад түүнийг нь л зөвшөөрөөд яваад байхад өөрөө хөгжчих бүрэн боломжтой.

Ц.Цэрэнпунцаг: 3 номер нэмж гүйцээж хариулья. Б.Бат-Эрдэнэ сайдын микрофоныг нээе.

Б.Бат-Эрдэнэ: Т.Доржханд гишүүний асуултад нэмж хариулья.

Өнөөдөр Зам, тээврийн хөгжлийн сайдтай бас яг энэ асуудлаар уулзалт ярилцлага хийсэн.

Нийт онгоцны зардлын 40 хувь нь шатахуунаас хамааралтай буюу шатахуун хэт монопол хэлбэр дээр байгаа. Энэ дээр монополыг задлах сонгон шалгаруулалтыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас зарлаж байгаа юм билээ.

Агаарын тээвэр дээр Бүгд Найрамдах Солонгос Улсаас авхуулаад яг саяын Ч.Хүрэлбаатар сайдын хэлсэн шиг **Low-Cost Airline** [Хямд өртөгтэй агаарын тээврийн компаниуд]-ууд орж ирэх хүсэлт байсан. Тэрийг өнгөрсөн жил хүртэл тодорхой хэмжээнд гацааж өнгөрсөн жилээс **Low-Cost Airline**-ууд Монгол Улсад нэвтэрч ирсэн байгаа.

Сөүл-Улаанбаатар-Сөүлийн чиглэлд хоёр талдаа 200-аас 230 мянган воноор жишээлбэл ниссэн. Тэр нь энэ жилээс 06 сарын 01-ний өдрөөс нисэхээр боломж хангаад явж байгаа.

Одоо С.Бямбацогт сайд бас энэ агаарын тээврийн либералчлалтай холбоо

бүхий асуудал дээр маш сайн оролцож ажиллаж байгаа. Маш олон авиа компаниудыг Монгол Улс руу нислэг үйлдэхтэй холбоо бүхий асуудлууд дээр гэрээ контракт.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Өдрийн мэнд хүргэе. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт нь, эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэх гээд. Тэр дотроо эрчим хүчний салбар эдийн засгийн үр ашигтай байдлыг бий болгоно гэсэн байгаа юм.

Тэгэхээр эрчим хүчний салбарын одоогийн байгаа нөхцөл байдал ямар байгааг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. Тухайлах юм бол 9 аж ахуйн нэгж байх. Сэргээгдэх эрчим хүчээр үйл ажиллагаа явуулдаг. Ерэн хэдэн оноос авхуулаад гэрээ контракт байгуулчихсан байдаг. 9 компани.

Төвийн эрчим хүчний системд 3 хувийн нийлүүлэлт хийгээд нийт орлогын 27 хувийг нь авч байгаа.

Компани нь 60, 70 тэрбумын ашигтай ажилладаг. Эсрэгээрээ манай эрчим хүчний салбар төдий хэмжээний алдагдалтай ажиллаж байгаа. Ийм нөхцөл байдал байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ бид яах юм? Зарцуулуулж чадах юм уу? Энэ хүрээнд яг юу хийх юм бэ гэдэг дээр нэг хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь, нийгмийн баталгааг сайжруулна гэхчхэн байна. Энэ дотроо цалин хөлс нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудал,

зорилт бүлгүүд рүү харсан асуудлууд гээд байна.

Тэгэхээр өнөөдөр юмны үнэ нэмэгдчихсэн, инфляц нэлээн хөөрөгдчихсөн цаг хугацаа байна. Ирэх онд ямар байхыг бас мэдэхгүй байна. Бид өөрсдөө энэ дээр төдийлөн хяналт тавьж чадахгүй байна уу? Яагаад юмны үнэ өсөөд байгаа вэ? Учиг холбоос зөндөө л юмнууд байгаа байх.

Тэгэхээр бид цаашид ирэх онд тэтгэвэр нэмнэ, цалин нэмэгдүүлэх тийм боломжууд байгаа юм уу? Эдийн засгийн чадавх чансаа нь боломжтой байгаа юу? Энэ тал дээр барьж байгаа бодлогоо хэлээч ээ гэж.

Гуравдугаарт нь, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр томоохон хөрөнгө оруулалтууд хийгдэхээр байгаа юм байна.

Тэгэхдээ энэ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч гэдэг том нэр дотор өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нар зүгээр хаягдаад яваад байдаг зүйл байгаа.

Нийт жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 53.6 хувь нь өрхийн буюу бичил бизнес эрхлэгч нар байгаа. Яг үнэндээ эд нар чинь нөгөө банкны шалгуур үзүүлэлт хангаж чаддаггүй ийм л хүмүүс шүү дээ.

Тэгээд энэ хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх боломж байгаа юм уу? Энэ дээр ямар зохицуулалтууд хийх юм бэ? Хууль эрх зүйн хувьд нь ч гэсэн. Үүнийг нэмэгдүүлж байж бид өрхийн орлогыг нэмэгдүүлсэн гэж зөв ярих ёстой гэж. Үүнийг нэмэгдүүлж байж, дэмжиж байж өрхийн орлогыг нэмэгдүүлсэн гэж ярих нь илүү оновчтой байх гэж харж байгаа.

Тэгэхээр энэ тал дээр ямар бодлого барьж байгаа юм бол гэж.

Дөрөвдүгээрт нь, шинжлэх ухааны салбар дээр томоохон хөрөнгө оруулалтуудыг хийх шаардлага байгаа юм. Уг нь Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлдээ тодорхой зорилт тавьсан боловч төдийлөн түүндээ хүрсэн хөрөнгө оруулалтуудыг хийж чадахгүй байгаа.

Өнөөдөр бид шинжлэх ухааны салбарт хөрөнгө оруулалт хийж байгаа нэртэй нэг сан байгуулдаг. Тэр сангаас тодорхой хэмжээний дэмжлэг авч байгаа аж ахуйн нэгж, хүмүүст нь ямархуу байдаг юм бол?

Өнөөдөр тэр эрдэмтэн судлаачдын гаргаж тавьсан төслүүдийг, эрдэм шинжилгээний судалгааны ажлуудыг нийгэмд өгөөжтэй төсөл болгож хэрэгжүүлсэн бодит тийм практик хэд байгаа юм бэ?

Өнөөдөр бид уул уурхай түшиглэсэн, хөдөө аж ахуйн салбарыг түшиглэсэн эдийн засагтай орон. Яагаад бид илүүтэй үйлдвэрлэх чиглэл рүүгээ хандах, энэ шинжлэх ухаанч байдалд тулгуурласан хөрөнгө оруулалт. Дээрээс нь шинжлэх ухааны ололт амжилтад тулгуурласан үйлдвэрлэлийг байгуулах тал дээр тодорхой санал санаачилга гаргахгүй байгаа юм бэ гэдэг дээр бас анализ хийх ёстой гэж харж байгаа. Энэ бидний ирээдүйн хамгийн том зорилт байх ёстой.

Тэгэхээр энэ дээр ямар бодлого барьж байна аа?

Эцэст нь Эрдэнэт үйлдвэр дээр уул уурхай, металлурги, химийн үйлдвэр барьж байгуулна гээд Монгол Улсын хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон байгаа.

Тэгээд энэ ажил маань явцын хувьд хэдэн хувьтай явж байгаа юм бэ? Цаашдаа ер нь хэдэн онд дуусах вэ? 2025 онд дуусна гэдгийг би ойлгож байгаа. Тэгэхдээ энэ хугацаандаа амжих юм уу, яах юм бол. Салбарын яамд нь хариулт өгөх байх гэж бодож байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Эрчим хүчний салбар яг үндсэндээ манай Монгол Улсын хөгжлийн хязгаарлаж байгаа тийм салбар болчихсон.

Хүчин чадал нь хүрэлцдэггүй. Тэгээд үйлдвэр үйлчилгээнүүд бий болъё гэхэд эх үүсвэр байхгүй. Ингээд хамгийн том асуудал энэ болчихсон байж байгаа. Тэгээд үүнийг бид яадаг юм гаднаас зээл аваад л, станц бариад л, тэгээд л хангаад явна гэдэг нь өөрөө энэ бол буруу л загвар болчихоод байгаа юм.

Тэгэхээр ер нь яах ёстой вэ гэхээр сая 3 хувийг нь үйлдвэрлэдэг мөртлөө орлогын 27 хувийг авчхаж байна гэж. Үүний шийдэл бол тэгээд л эрчим хүчний үнийг бид өсгөхөөс өөр аргагүй шүү дээ.

Хэрвээ эрчим хүчний үнэ өсгөхгүй бол энэ салбар хэзээ ч хөгжихгүй. Бидэнд өөр сонголт бараг байхгүй дээ.

Тэгэхээр эрчим хүчнийхээ үнийг бид өсгөнө. Энэ дээр нь тэр холбогдох хувийн хэвшлийнхэн нь орж ирж хөрөнгө оруулалтаа хийдэг боломжийг нь бий болгож өгнө. Одоо ажиллаж байгаа компаниуд ядахдаа авч нэг засвараа хийдэг, хүчин чадлаа нэмдэг, тэлдэг боломжийг нь бүрдүүлж өгөхгүй бол эдийн засгийн хөгжлийг гацаадаг. Нөгөө юугаар нэг **bottleneck**_[гацаа] гээд байдаг юм бүр нарийссан, хөгжлийг гацаадаг ийм зүйл болчихоод байгаа юм.

Тэгэхээр яах аргагүй бид жилийн төлөвлөгөө дээр оруулчихсан байгаа. Тарифыг бид шинэчилж зах зээлийнх нь нөхцөлөөр хөгжих боломжийг нь хангаж өгөхгүй бол эрчим хүчний салбар Монгол Улсын хөгжлийг хойш нь татсан хэвээрээ л байна.

Хэрвээ бид эрчим хүчнийхээ салбарыг шинэчилж чадахгүй бол эдийн засгийн өсөлт хөгжил гарахгүй.

Тийм учраас бид хөгжлийн бодлогын жилийн төлөвлөгөөндөө оруулаад биччихсэн байгаа. Яг энэ тарифтай холбоотой.

Хоёрдугаарт нь, цалин, тэтгэврийг нэмэх боломж бий юу гэж. 2024 онд боломжоо гаргаад явна.

Ер нь У.Хүрэлсүх Ерөнхий сайд байх үед цалин, тэтгэвэр дандаа инфляцтай уялдуулаад л нэмээд яваад байдаг байсан. Ингэхэд янз бүрийн сөрөг юм гардаггүй байсан.

Тэгэхээр бид цаашдаа цалин, тэтгэврийг инфляцтай уялдуулаад нэмдэг тогтмол юу руу л шилжих хэрэгтэй гэсэн санаагаараа бид энд оруулж ирж байгаа юм.

Боломжийг гаргаад бид үүнийг хийгээд явах учиртай. Тэгэхгүй бол боломжгүй байна гээд аваад үлдчихдэг ч юм уу, хойш нь хийхгүй болгочихоор түүнээс гарах үр дагавар нь илүү их үр дагавартай.

Одоо ингээд л бид аваад үзэхэд чинь Монгол Улсын иргэдийн орлого буучихсан, өрхийн орлого буучихсан ийм л байгаа шүү дээ. Гэтэл бид энэ инфляцтай уялдуулаад л нэмэх энэ арга хэмжээг ямар ч тохиолдолд хэрэгжүүлээд яваад байсан бол ийм байдал үүсэхгүй байсан болов уу гэж бодож байгаа.

Тийм учраас цалин, тэтгэврийг цаашдаа бид инфляцын түвшинтэй нь уялдуулаад нэмэгдүүлэх ёстой гэж бодож байгаа. Ер нь цаашдаа. Зөвхөн 2024 ондоо ч биш. Ер нь цаашдаа ийм бодлогоо баримтлаад явах нь зөв болов уу гэж бодож байгаа.

Шинжлэх ухаан гэхээр ер нь цаашдаа Монгол Улсын хөгжил дэвшил шинжлэх ухаан дээр үндэслэхгүйгээр явах ямар ч боломж байхгүй.

Тэгэхээр шинжлэх ухааны ололт, нээлтийг учиргүй юу гэдэг юм сансрын тоног төхөөрөмжүүдийг хийнэ, ракет хийнэ, пуужин хийнэ гэдгээсээ илүүтэйгээр хөдөө аж ахуйн салбарт гэхэд чинь одоо яг Монголын нөхцөлд ургачихаар хүнсний ногооны үрийг бий болгох ажлууд зүгээр энгийнээс авахад байгаа байхгүй юу. Захиалгаар өгөөд ажиллуулаад явах боломжууд нь байгаа. Заавал сансрын юм ярихгүйгээр яг хөрсөн дээр буугаад хийчих ажлууд зөндөө л байгаа юм.

Тэгэхээр үүнийг гэрээлж хийдэг ийм л боломжийг бүрдүүлж ажиллах ёстой болов уу гэж бодож байгаа.

Шинжлэх ухааны байгууллагууд дээрээ онцгой анхаарал тавьж явах ёстой. Нэг байгууллагын харьяа байгууллагууд болоод явчихаар тэр нь хөгжихгүй байгаад байгаа учраас энэ дээр санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 0.8 хувь ч билүү. Үүнийг болгоно гээд л явж байгаа.

Ер нь цаашдаа.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн та нэмж асуулт байна уу? Хариулт дутуу байна уу? Хэдэн номероос хариулах юм. Д.Батлут гишүүн 5 асуулт асуусан.

Манай ажлын хэсгийнхэн ерөөсөө бүгдийг нь Ч.Хүрэлбаатар сайд хариулчихаар бүр сүүлдээ нам унтаж байгаа юм байна шүү дээ. Та бүгдээс тэгвэл тус тусад нь асууя. Бүгдээрээ.

Ер нь цохоод цохоод гишүүд асуултаа асууя. Ч.Хүрэлбаатар сайд гүйцээгээд хариулчихъя.

Ч.Хүрэлбаатар: Манай ажлын хэсэг, манай яам, холбогдох яамд их сайн ажилласан юм. Маш сайн ажилласан юм.

Тэгээд жишээлбэл энэ дээр биччихсэн байна л даа. 2.2.3.8 дээр Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн уул уурхай, металлург, химийн үйлдвэрийн цогцолбор, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах. Шалгуур үзүүлэлт нь барилгын ажлын гүйцэтгэл. Хэмжих нэгж нь хувиараа. Ингээд 2024 онд дуусна гээд тавьчихсан байгаа юм. Зорилтот түвшин нь 100. Үүнээс 50 хувь хэрэгжээд явна. Хариуцагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гээд биччихсэн. Дуусах юм байна л гэж ойлгож байгаа шүү дээ, бид.

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн та нэмэлт асуултаа асуух ёстой. Тийм ээ. Нэмэлт асуултаа асууя. Д.Батлут гишүүний микрофоныг нээе.

Д.Батлут: Хариултуудаа бас төдийлөн бүрэн дүүрэн авч чадсангүй.

Тэгэхээр эрчим хүчний тэр гэрээг. Нөгөө 9 аж ахуйн нэгжүүдтэй холбоотой гэрээг яах юм бэ? Цаашдаа. Тэр дээр ахиад нэг хариулт өгөөч. Яг точный хариулт.

Ер нь тэгэхдээ эрчим хүчний энэ үнийг нэмэгдүүлснээрээ бас асуудал шийдэх боломжгүй шүү дээ. Бас өөр гарцууд байгаа. Тухайлах юм бол одоо

орчин үед атомын цахилгаан станцууд маш аюулгүйгээр үйл ажиллагаа явуулах боломжтой болчихсон байна.

Манай Монголд түүхий эд нь байна уу, уран байна. Түүнийгээ түшиглэсэн атомын станцтай болох боломжууд байгаа.

Ингэснээрээ бид хамгийн хямд цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болох боломж бололцоо байна. Энэ тал дээр манай Хөгжлийн яам юу бодож байгаа юм бэ? Энэ тал дээр ер нь тодорхой шийдэл байна уу, гарц байна уу? Энэ дээр судалсан зүйлүүд байна уу гэдэг дээр бас нэг хариулт өгөөч ээ.

Шинжлэх ухааны салбар. Энэ бол зүгээр нөгөө судалгааны ажлыг нийгэмд өгөөжтэй төсөл болгох ажлууд байхгүй юу. Тэр дээр ямар өөрчлөлтүүд.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Нэг дэх асуулт нь атомын цахилгаан станцын талаар юу бодож байна гэж асуулаа.

Хоёр дахь нь, хамгийн гол нь судалгаа, шинжилгээний бүтээлүүдийг цааш нь эдийн засагжуулах чиглэл рүү ямар бодлого хийж байгаа юм бэ гээд хоёр асуулт асуулаа. Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Тийм. Би гэрээтэй л холбоотой яриад байгаа юм. Тэр 5, 6 компанийн.

Эрчим хүчний үнээ чөлөөлөх ёстой.

Дээр нь үнийг худалдаж авахдаа аль эрчим хүчийг холбох вэ гэдгийг хийхдээ акциондах ёстой. Тэгээд өгч байгаа үнийн саналаар нь авахгүй бол тэр сэргээгдэх эрчим хүчний өндөр үнэтэй эрчим хүчийг авах ийм л юм руугаа орно.

Энэ чиглэлээрээ ажиллаж байгаа юм. Тэгээд ярихаар авах сончихъё л гэдгийг бүгдээрээ хүлээн зөвшөөрөөд байгаа юм.

Тэгэхээр бид энэ дээр механизмаа зөв болгохгүй бол тэдэнтэй юу ч яриад үр дүн гарахгүй.

Тэгэхээр механизмаа зөв болгоод явчихвал. Жишээлбэл, үнэ өсөөд ирэх хэрээр алдагдал зөрүү нь буураад эхэлчихнэ шүү дээ. Тэгээд 3 хувь чинь арай өөр болно. 27 хувь чинь арай өөр болно. Тэгээд ирэхэд энэ дээр шийдлүүд нь гарах юм байна гэж үзэж байгаа юм.

Зүгээр атомын цахилгаан станц нь юу юм? Эхлээд юу ч гэсэн энэ ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн та хариулт хангалтгүй гэж үзвэл тодруулж асууж болно. Та тодруулаад асуучих.

Д.Батлут: Ер нь Европын улс орнууд ч юм уу, хөгжингүй улс орнууд ерөнхийдөө тийм атомын станцыг маш сайн ашигладаг болчихсон. Хямд төсөр эрчим хүчний хэрэглээтэй болчихсон байгаа.

Тэгэхээр манай түүхий эд нь байна уу. Тийм хөгжингүй орнуудтай хамтарсан баяжуулах үйлдвэр, цаашлаад атомын станц байгуулах бодлыг бид агуулж л байх хэрэгтэй байхгүй юу. Ингэж байж цаашаа бас явна гэж харж байгаа юм. Дэлхий нийттэй хөл нийлүүлж алхана.

Хоёрдугаарт нь, эрчим хүчний асуудал. Энэ 9 компанийн асуудлыг гэрээг нь дуусгавар болгохгүй бол хэзээ ч засагдахгүй байхгүй юу. Ерөөсөө л авахад үүрэгтэй. Тэгэхдээ өөрсдийнх нь үнээр.

Тэгэхээр үүнийг дуусахгүй юм уу гэдэг л асуудал их сонирхоод байгаа юм. Би. Тэр дээр л хариулт авах гэсэн юм л даа. Тэрийг хариулаад өгөөч ээ л гэдэг.

Тэр бичил бизнес дээр ерөөсөө юм яригдахгүй байна. Сайд аа. Бичил бизнес. Энэ бол жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 53.6 хувь нь бичил бизнес эрхлэгч, өрхийн бизнес эрхлэгч нар. Эднийг дэмжих хууль эрх зүйн орчин төдийлөн сайн биш. Тэд ажил хийх гэдэг. Боломж нь олддоггүй.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Тэр сэргээгдэх эрчим хүчний компаниудын гэрээг тас гээд хүчингүй болгочихоор асуудал дүүсэн л дээ.

Тэгэхдээ хэтэрхий өндөр үнэтэй байгааг бүгдээрээ л мэдэж байна. Тухайн үеийн дарга нар юу ч бодож гэрээнүүдийг байгуулж байсан юм. Бөөн хэл ам шүү дээ. Одоо манай яаман дээр байгаа гомдол бол дандаа л үүнтэй л холбоотой. Дийлэнх нь гомдлууд байгаа юм.

Тэгэхээр үнэ чөлөөлөх, тэгээд аукциондох гэдэг энэ зарчим руу шилжүүлэхээс өөр юу байхгүй. Гэхдээ тэд нар ихэнх нь үүнийгээ хүлээн зөвшөөрч байгаа. Ийшээгээ шилжихийг.

Тэгэхгүйгээр бид яг гаргалгаа гарцыг нь зөв зааж өгөхгүйгээр хүчээр гэрээг нь дуусгана ч гэдэг юм уу, тэр яриа нэг их үр дүнгүй л болов уу гэж бодоод байгаа. Д.Батлут гишүүн ээ.

Ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах чиглэл одоо энэ байгаа ажлаа эхлүүлчихмээр байгаа юм. Тэгж байж дараа нь тэр ураны, тэр

цөмийн цахилгаан станцын тухай ярьсан нь дээр болов уу.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Би гурван зүйл л асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, жил болгон л миний ярьдаг нэг сэдэв. Энэ Алтанбулаг боомт. Одоо энэ гаалийн барилгыг нь буулгаад хоёр өвөл ажилчид нь контейнерт ажлаа хийж байна. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах ямар ч боломжгүй.

Тэгээд энэ чинь одоо манай хойд хил шүү дээ. Манай хойд үүд хаалга. Гаднаас хүмүүс ороод ирэхээр нэг аймшгийн нурангид дунд л явж байна.

Тэгээд нэг шалгаруулсан компани нь ажлаа хийхээ байчихсан. Ингэсэн, тэгсэн гээд л янз бүрийн шалтаг хэлээд одоо ингээд өчнөөн жил болж байна. Энэ асуудлыг яаж шийдэх юм бэ? Одоо ямар түвшинд явж байгаа юм бэ?

Үүнтэй бас яг уялдаатай “Алтанбулаг чөлөөт бүс”. Нэг хэсэг хүмүүс шүүмжлээд л архи, тамхинаас өөр юм зардаггүй гээд. Одоо бүр юу ч зарахаа больсон. Хэн ч орохоо больсон. Тэнд үхмэл. Баахан хөрөнгө оруулчхаад өчнөөн жил. Тэгээд үхсэн үхмэл газар л байж байна.

Тэгэхээр үүнийг 2024 оны манай хөгжлийн төлөвлөгөөнд яаж хөгжүүлнэ гэж оруулж ирж байгаа юм бэ?

Дараагийн багц асуудал нь, энэ Дарханы арьс, ширний цогцолбор гээд бас өчнөөн жил яригдаж байгаа. 2020 онд сонгуульд нэр дэвшихэд л үүнийг ярьж байсан. Одоо тэгээд юу ч байхгүй л харагдаад байгаа.

Тэгэхээр энэ ямар түвшинд явж байгаа юм бэ? Одоо суурь түвшин гэнгүүтээ зураас тавьчихаж. Юу гэсэн ч үг юм.

Тэгээд 50 хувийг нь барина гэж байгаа юм уу? Энэ одоо ямар байгаа юм, ямар болох юм бэ гэдгийг хэлж өгөөч ээ.

Гурав дахь асуудал нь, ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламжийн асуудал гээд бидний эмэгтэй гишүүд нийлээд 819 сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламж нь гадаа нүхэн жорлон байна. Үүнийг өөрчилье гээд 100 тэрбум төгрөг уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд 2 жил дотор багтааж барихаар Улсын Их Хурлын тогтоол батлуулаад, тэгээд нөгөө Эрдэнэт үйлдвэр нь бас мөнгөө яг хүссэнээр чинь төлөвлөгөөний чинь дагуу өгье гэсэн.

Тэгсэн одоо энэ төлөвлөгөө дээр болохоор суурь түвшин нь 174, зорилтот түвшин нь 346 гээд ороод ирсэн байна.

Үүнийг 2021 оны бид тэр Төсвийн тухай хуулийг хэлэлцэж байхад Улсын Их Хурлын тогтоол гаргуулж байсан. Тэгээд 2021, 2022 он гээд л бүрэн хийчихсэн байх ёстой байхгүй юу. Гэтэл 2024 онд 346 гээд 50 хувьд нь ч хүрэхээргүй ийм зорилтот түвшин дэвшүүлээд явж байгаагийн учир нь юу юм бэ?

Тэгэхээр энэ Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлж чадаагүй гол буруутан нь хэн юм бэ? Энэ хүн дээр нэг бол хариуцлага тооцох ёстой. Ажлаа хийж чадахгүй ажлаа хийж чаддаг хүнд нь даалгамаар байна.

Тэгэхээр энэ гурван зүйл дээр хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Боомтын сайд. Ажлын хэсгийн 2 номер уу? 2 номер Б.Тулга сайд хариулъя.

Б.Тулга: Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын ажил эхлээд тодорхой хугацаа өнгөрсөн. Энэ оны 7 сард багтаж дуусах хуваарьтай.

Харамсалтай нь КОВИД-ын үеийн хүндрэл, барилгын салбарт тулгамдсан энэ хүндрэлүүдтэй холбоотойгоор удааширч байгаа.

Миний бие ажил авснаас хойш миний өмнөх сайд нар ч гэсэн өөрсдөө энэ бүтээн байгуулалтыг хийж байгаа компанитай очиж уулзаж ажлыг хурдлуулахын тулд ажилласан байдаг.

10 хоногийн өмнө бас ерөнхийдөө энэ асуудлаар оролцогч бүх талуудыг цуглуулж уулзаад Алтанбулаг боомтын бүтээн байгуулалт, тэр дотроо хоёр хэсэгт хуваасан байгаа.

Нэг нь, ачаа тээврийн хэсэг зорчигч тээврийн хэсэг гээд.

Ачаа тээврийн хэсгийн бүтээн байгуулалтын ажил нийтдээ 96 хувийн бүтээн байгуулалт нь бэлэн болсон.

Замын компанийг энэ дээр яг тэр ачаа тээврийн хэсэгт нь яаралтай та нар энэ хаврынхаа бүтээн байгуулалтыг хий гээд. 06 сарын 01-н гэхэд замын хучилтыг дуусах чиглэл өгсөн байгаа. 06 сарын 01 дуусчихна. 7 сардаа багтаагаад ачаа тээврийн хэсгийг ямар ч гэсэн бүрэн дуусгах зорилтыг тавиад ажиллаж байна.

Зорчигч тээврийн хувь дээр нийт ажил 70 орчим хувьтай байгаа. Анх

төсөл, тендер шалгаруулахдаа шалгаруулж байгаа тал, мөн шалгарсан компанийн хувьд тооцоо судалгаагаа дутуу хийсэн. Үүнтэй холбоотойгоор тодорхой хэмжээний зөрчил үүссэн байгаа юм билээ.

Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлэхээр тухайн компанитай ажиллаж байгаа.

Компанийн хувьд бас төрийн маш олон ажлууд хийж байсан гадна дотнын хөрөнгө оруулалттай маш олон бүтээн байгуулалтаар ажиллаж байсан компани юм билээ. Тэгээд энэ компанитай нүүр тулж уулзаад Алтан боомт булаг боомтын асуудал, ялангуяа энэ Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн нэг болсон боомтын бүтээн байгуулалтын асуудал дээр онцгой анхаарал хандуулж ажиллахыг шаардаж шаардлага тавьсан байгаа.

Тэгэхээр удахгүй бас одоо энэ долоо хоногт багт бид дахиж уулзана. Тэгээд энэ жилдээ багтааж энэ зорчигч тээврийн терминалын бүтээн байгуулалтыг дуусгахаар тэр хувийн хэвшлээ шахааж шаардаж, хаана гацаж байна. Тэр гацаатай байгаа асуудлууд дээр аль болох зөв шийдвэрийг болохоор ажиллаж байна гэж ийм л мэдээллийг өгөхөөр байна.

Ц.Цэрэнпунцаг: Та гүйцээж хариулах уу? Ч.Хүрэлбаатар сайд гүйцээж хариулья.

Ч.Хүрэлбаатар: Дарханы арьс, ширний цогцолбор гээд энэ их хэл амтай юм байгаад байгаа юм. Баахан хулгай нүүрлэчихсэн. Тэгээд л бас л хэрэг үүсээд л шалгагдаад л. Чиний хөрөнгө, миний хөрөнгө гээд л яриа хэлцэл нь явагдаад л явж байгаа юм байна лээ.

Тэгээд 2024 ондоо 50 хувийн ажил хийгдэнэ гэдэг ийм зүйл энэ дээр оруулж ирсэн байж байгаа.

Анхнаасаа буруу эхлүүлчихсэн юмнууд яг л нөгөө буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо тээнэ гэдгийн л үлгэр болсон. Энэ Дарханы цогцолбор үйлдвэр.

Анхнаасаа тэр аймгийнхныг дуудаад л Ерөнхийлөгч байсан Х.Баттулга гэдэг хүн дуудаж газрыг нь чиглүүлээд л, шахаад л, ийшээгээ ингэж явуулаад л тэр хувийн ажил барьж хийх гэж байсан хүмүүсийг татаж оруулсаар байгаад л ийм л хулгай нүүрлэсэн л юм болсон шүү дээ.

Үүний хэл ам цэгцэлтэл бид энэ дээр шийдэл гаргаж явахаас өөр арга байхгүй. Тэгээд хоорондоо нэг учраа олж байгаа болов уу гэж бид найдаж байгаа.

Тийм учраас энэ дээр ингэж 50 хувь гэж оруулж ирсэн байгаа. Тодорхой хэмжээний мөнгө бас зарчихсан байдаг. Тэгээд ялгаж салгаад л нэг талдаа гарчих болов уу гэсэн бодолтой байгаа гэдгийг хэлье.

Тэр сургууль, цэцэрлэг дээр гадна нолийн асуудлыг энэ 2023 онд дуусгачих байлгүй дээ. Энэ 2024 оны төлөвлөгөө.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Ундрам гишүүн та нэмээд асуултаа асуучих.

Ч.Хүрэлбаатар: Боловсролын яамны хүмүүс хариулаарай.

Ц.Цэрэнпунцаг: Боловсролын яамнаас хэн байна? Гараа өргөөрэй. Хэдэн номер дээр байна?

Ч.Ундрам гишүүн нэмэлт асуултаа асууя.

Ч.Ундрaм: Сая Ч.Хүрэлбаатар сайд та Алтанбулаг чөлөөт бүстэй холбоотой цаашид яаж хөгжих юм бэ гэдэг дээр нэмэлт тайлбар өгөөч.

Энэ төслийн 3.1 нь боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна гээд. Тэгээд 3.1.4.5 дээр ариун цэврийн байгууламжийн асуудал нь зорилтот түвшин нь 346 гэхихсэн байгаа.

Ер нь анх бид энэ Улсын Их Хурлын тогтоолыг батлуулж байхад 819 сургууль, цэцэрлэг, дотуур байр байсан. Бүгдийг нь шийдэхэд 100 тэрбум төгрөг шаардлагатай гээд. Би тантай хүртэл ярьж байсан шүү дээ. Танаас мөнгө гуйгаад л явж байсан.

Тэгээд Эрдэнэт үйлдвэрээс бид мөнгө олоод Улсын Их Хурлын тогтоолоор баталгаажуулсан. Одоо гэтэл энэ 819 болоод байж байх ёстой байхгүй юу. Эсвэл энэ 2023 он дууссан гээд энэ асуудал эндээс хасагдсан байх ёстой. Гэтэл 346 гээд ороод ирчихсэн байна.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд гүйцээж хариулья.

Ч.Хүрэлбаатар: “Алтанбулагийн чөлөөт бүс” гээд байгаа.

Яг энэ чиглэл дээр түрүүн бас Т.Энхтүвшин гишүүн асуусан. Бид энэ чөлөөт бүсийн асуудлуудаар бүгдийг нь концепцын хувьд нэг эргэж харж үзэж байгаа юм.

Тэгээд яавал бодитой ажил болгох вэ гээд. Түүнээс биш өнгөрсөн арван хэдэн жилийн хугацаанд чөлөөт бүс хөгжөөд архи, пиво, тамхи зардаг л газар болчихсон байна лээ шүү дээ.

Тэгэхээр үүнийг арай өөр болгоод эдийн засгийн хувьд яаж эдийн засгийн зөв эргэлтэд оруулж болох вэ гэдэг талаас

нь бас бид нэлээд ажиллаж байгаа юм. Тэгж байгаад удахгүй Эдийн засгийн байнгын хороон дээрээ танилцуулна. Бэлэн биш. Бэлэн болоогүй учраас бид оруулж чадаагүй гэдгийг хэлье.

Сургуулийг энэ Боловсролын яам хариулахгүй бол. Бид тодруулаад Ч.Ундрaм гишүүнд хариулт өгье. Тэгэх үү? Бид Боловсролын яамнаас тодруулья.

Уг нь тэр үед ярьж байсан. Дуусаж байгаа юм байх гэж ойлгосон шүү. Уучлаарай.

Ц.Цэрэнпунцаг: Боловсролын яамнаас алга байна шүү.

Ингээд гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. /алх цохив/

Ингээд тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Үг хэлэх гишүүд байхгүй учраас би нэг үг хэлчихье.

Ингээд өнөөдөр бид жилийнхээ хөгжлийн төлөвлөгөөг сонсож байна. Тийм ээ. Тэгээд Та бүхэнд бас энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл Засгийн газартай, бас яамууд дээр ажиллаж байгаа юм байна гэж ойлгосон. Ялангуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр төсөл хэрэгжүүлсэн юм байна лээ.

Энэ дээр бид нарын энэ төсөл, төлөвлөгөө, төсөвлөлт. Үүнийгээ удирддаг, энэ нэг бодлогоо, хөгжлийнхөө бодлогыг удирддаг энэ арга барилаа өөрчлөх, хандлагаа өөрчлөх, бидний хандлагыг өөрчлөх, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлт, удирдлага гэсэн энэ чиглэлээр төсөл, хөтөлбөр явж байгаа юм байна лээ.

Тэгэхээр зэрэг бид энэ төсөл, хөтөлбөр Засгийн газрын хэмжээнд хамтарч ажиллаад явсны дараа Их Хурал дээр Байнгын хороодтой хамтарч ажиллая, Эдийн засгийн байнгын хороо бас хамтарч ажиллая гээд санал хүсэлтээ тавьсан.

Тэгээд тодорхой саналууд яваад бид Их Хурал дээрээ энэ төсөл, хөтөлбөрийг бас хэрэгжүүлж, Байнгын хороон дээрээ ажиллах. Энэ хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх бодолтой байгаа.

Тэгэхээр зэрэг алсдаа бид дараа дараа цаашдаа урт хугацаа, дунд хугацаа, энэ жилийннхаа төлөвлөгөө хэрэгжсэн эсэхийг нь ярилцдаг үедээ энэ яриа.

Сая Ч.Ундрам гишүүнээс гарч ирж байгаа асуултууд. Нөгөө талаасаа хариулж байгаа хариулт маань бас ингээд л заримдаа хоорондоо авцалдаж өгөхгүй юм шиг нэг байдал бидэнд үүсээд байгаа нь бид нарын энэ төлөвлөлт, төсөвлөлт, удирдлагаа бид хэрэгжүүлдэг арга барил маань бас жоохон учир дутагдалтай юм байна гэж би төслийнхний тэр танилцуулгатай холбогдуулаад бодсон юм.

Тэгэхээр зэрэг зүгээр энэ дээр жишээлбэл бид одоо ингээд нэг жилийн дотор бид гол тэргүүлэх чиглэлүүдээрээ ямар зорилт, түвшинд хүрэх гэж байгаа юм бэ гэдгээ тодорхойлоод бид чинь явдаг юм байна.

Тэгээд зүгээр тэр дээр нэг жишээ танилцуулж байсан юм бид нарт. Тэгтэл бид жишээлбэл хүний хөгжил гээд ерөнхий тэргүүлэх чиглэл гээд тавьчихдаг гэнэ. Одоо бид нарын явж байгаа өнөөгийн туршлага.

Тэгээд энэ дээр чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалттай, аз жаргалтай, амьдралын ээлтэй орчинд гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн, нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ гээд ерөнхий уриа лоозон маягтай юм тавьчихдаг.

Тэгээд бид чинь үүнийгээ яаж хэрэгжүүлэх гэж байгаа юм. Түвшин түвшиндээ үүнийгээ яаж хэрэгжүүлэх нь тодорхой бус. Хоорондоо уялдаа холбоо байдаггүй. Төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт шинжилгээ бүгд хоорондоо уялдаагүй болчихдог гэнэ.

Тэгээд үүнийг өөрчилнө өө. Энэ төсөл хэрэгжээд, бид үүнийг авч хэрэгжүүлээд явах юм бол. Жишээлбэл, бид яг бодлогынхоо хүлээгдэж буй үр дүнг бодитоор төлөвлөдөг болно гэж байна. Төлөвлөсөн үр дүнгээ дүндээ төсвөө зарцуулна. Тэгээд төлөвлөсний дагуу гүйцэтгэнэ.

Ингээд төлөвлөсөн үр дүнгээ хэмжих хэмжүүрүүд нь тодорхой байдаг юм байна.

Тэгтэл би сая уншсан юм шүү дээ. Хүний хөгжлөө тавьчихсан байхад одоо энэ шинэ хандлагаар үр дүнд суурилсан бид удирдлагатай, төлөвлөлттэй, төлөвлөгөө төсөвлөдөг, төлөвлөдөг болчих юм бол. Жишээлбэл, зорилго. Ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгана гээд. Энэ удаан хугацаандаа юм уу, дунд хугацаандаа тавьчихна. Одоо бид урт хугацааны алсын хараа дээр жишээлбэл 2050 он гэхэд ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах гээд тавьж байгаа юм.

Тэгээд жишээлбэл Зорилго 1.1 гээд. 2030 он гэхэд туйлын ядуурлыг устгах буюу өнөөгийн тооцоогоор өдөрт

1.25 амдоллороос бага орлогоор амьдарч байгаа хүмүүсийн туйлыг ядуурлаас гаргах гээд бүр тодорхой тавьчихдаг юм байна.

Тэгээд үүнийгээ жишээлбэл Засгийн газар энэ түвшин түвшиндээ. Үндэстний хэмжээнд, салбарынхаа хэмжээнд. Тэгээд төсвийн ерөнхийлөн зарцуулагчийн хөтөлбөрөө авч явж байгаа хөтөлбөрийн менежер гэсэн энэ түвшнүүдээрээ ялгаад хийх ажлуудыг нь тавьчихдаг.

Ингээд тодорхой болгочих юм бол бид төлөвлөгөөгөө ч ярилцаж байхад амар, тайлангаа сонсоод үр дүнг нь дүгнээд ярилцах ч гэсэн бидний асуусан асуулт ч тодорхой, хариулах хариулт ч тодорхой болно гэж төсөл, хөтөлбөрийн хүмүүс сайхан танилцуулж байна лээ.

Тэгэхээр мэдээж Хөгжлийн яам шинээр байгуулагдсан. Цэгцэрч байгаа учраас танай яамтай хамтарч ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Тийм ээ. Тэгээд Их Хурал дээр бид хамтарч ажиллаж гэж ярьсан шүү. Ч.Хүрэлбаатар сайд аа.

Тэгээд Их Хурал дээр явагддаг асуулт хариулт, Их Хурлын үйл ажиллагаа их цэгцтэй сайхан болох байх гэж бодож байна.

Гурав. “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Гурав. “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлбэ.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаярыг тогтоолын төслийн талаар танилцуулга хийхийг урьж байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.
/алх цохив/

Ингээд санал хураалтаа явуулж эхэлбэ.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуульа.

Гишүүдийн 73.3 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут гишүүн танилцуулна.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

Дараагийн асуудалдаа орёе. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Гарч болно.

Б.Энхбаяр гишүүний микрофоныг нээе.

Б.Энхбаяр: Би түрүүн хэлсэнчлэн Улсын Их Хурлын даргын захирамжаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг Байнгын

хорооны хуралдаан, чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх ажлын хэсэг 10 гаруй гишүүний бүрэлдэхүүнтэй. Ажлын дэд хэсэг нь 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй. Нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан.

Ирэх долоо хоногоос ер нь вакуумжиж ажиллах гэж байгаа.

Энэ бол нөгөө байгалийн баялгийн сангийн гол суурь болно.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон өөрчлөлтийг амилуулах өмчийн багц хуулийн реформ болно.

Энэ хүрээнд ажлын хэсэг бас нэлээн шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо, онолын суурьтай ер нь үзэж байгаа.

Та бүхэнд сая 3 багц судалгааны материалыг хэвлүүлж, Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд бас тараасан.

Олон нийтийн түвшинд маш их хэлэлцүүлгүүд хийх шаардлагатай юм билээ. Яагаад гэхээр энэ маш их суурь асуудал байгаа.

Өнөөдөр төрийн өмчийн компаниуд дээр 40, 50, 60 их наядын хөрөнгө бүртгэлтэй гэгддэг.

Хэрвээ үүнийг нөгөө газрын багц хуультайгаа уяад шийдэх юм бол их тийм цогц асуудал байдаг. Одоогоор манайд 400 гаруй төрийн болон орон нутгийн өмчит компаниуд байдаг гэдэг. 2-хон компаниас бусад нь ашиггүй байдаг.

Тэгээд олон нийтэд публик компани болохтой холбоотой нэлээн тийм цогц. Ялангуяа хувьцааны засаглалтай холбоотой. Хувьцааг ард

иргэдэд хэрхэн эзэмшүүлэх, төрийн өмчийн компаниудын удирдлага, түүний эрх хэмжээ, шийдвэр гаргалт. Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутаг гээд.

Энэ нэлээн тийм олон эрх ашгийг хөндсөн тийм суурь реформ болох учраас нэлээн тооцоо судалгаатай хандъя гэж байгаа.

Сая хоёр долоо хоногийн өмнө манай ажлын дэд хэсгийн ахлагч Б.Солонгоо сайдаар ахлуулсан ажлын хэсэг Олон улсын эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын ээлжит хуралдаанд энэ хуулийн төслийн танилцуулгыг хийсэн байгаа.

Ингээд тэндээс зөвлөх ажиллуулъя буюу Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс баталсан төрийн өмчийн компанийн сайн засаглалын загвар стандартыг.

Хоёр янзын стандарт байдаг юм байна. Нэг нь загвар стандарт. Нэг нь төрийн өмчийн компаниудад авлигаас урьдчилан сэргийлэх стандарт гэж хоёр янзын стандарт байдаг юм байна.

Бид хоёр дахь стандартыг нь ажлын хэсгийнхээ хүрээнд бүгдийг нь орчуулчихсан. Ажлын хэсгийн гишүүддээ тараачихсан байгаа.

Тэгээд энэ сайн туршлагуудыг бас нэлээн авч байж ингэж ажиллая гэж байгаа.

Тийм учраас ажлын хэсгийн хүрээнд нэлээн тийм туршлага судалж, энэ сайн стандартуудыг нутагшуулж, нэлээн тооцоо судалгаатайгаар явж хуулиа батлах хэрэгтэй гэж үзэж байгаа.

Ер нь энэ багц хуулиуд батлагдвал миний хувьд их өөдрөг байгаа.

Ер нь Монголын эдийн засаг 2-оос 3 дахин одоогийнхоосоо шууд тэлнэ гэж харж байгаа.

Яагаад гэхээр зах зээлийн бүртгэлгүй байгаа өмчүүдийг, төрийн өмчийн компаниудад байгаа том хулгайнууд цэгцлэгдэх ёстой. Ард иргэдэд хувь хувьцаагаар дамжуулж байгалийн баялгийн тэгш, шударга тогтолцоо үйлчлэх учиртай гээд.

Тийм учраас ажлын хэсэг дээрээ Байнгын хорооноосоо нэг чиглэл гаргасан ийм тогтоол баталж өгөөч ээ гэж ажлын хэсгийн ахлагчийн хувьд хүсэж байгаа.

Эрхэм гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ингээд “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэндээ уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1.Улсын Их Хурлын даргын 2022 оны 198 дугаар захирамжаар байгуулагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд”-ийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг /Б.Энхбаяр/-т дараах

арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1/хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, төслийг иргэд, олон нийтэд нээлттэй хүргэж, хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох саналыг авч ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэх;

2/төрийн болон орон нутгийн өмчийн ойлголт, талуудын оролцоо, олон нийтийн хяналт, өмчийн удирдлагын талаарх баримт, мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хүргэх зорилгоор танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн түгээх, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

3/төрийн өмчийн компанийг байгуулах, удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоо, хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа, ногдол ашгийг хэрхэн хуваарилдаг талаарх гаднын орны сайн туршлагыг судалж, хуулийн төсөлд тусгах;

4/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, даван туулах арга замын талаар санал солилцож ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэх.

2.Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан гадаад орны турш туршлага судлах ажлын хүрээнд зорчих улсыг тогтох, ажлын төлөвлөгөө гаргах, айлчлалын бүрэлдэхүүнийг сонгох, айлчлалыг зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярт зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолд заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг

санхүүжүүлэхийг “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газар /Г.Ёндон/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Т.Энхтүвшин гишүүнээр тасаллаа.

Ч.Хүрэлбаатар сайд асуултаа асууя.

Ч.Хүрэлбаатар: Энэ зардлыг Эрдэнэт үйлдвэрээс гаргана гээд л биччихсэн байх юм. Ингэж болж байгаа юм уу?

Ц.Цэрэнпунцаг: Б.Энхбаяр гишүүн та хариулна уу?

Б.Энхбаяр: Энэ зардал нь Эрдэнэт үйлдвэрээс гарах нь Эрдэнэс Монголын Эрдэнэт үйлдвэрийн төлөөлөн удирдах зөвлөлөөр зардлыг нь баталчихсан юм билээ. Яг Улсын Их Хурлын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэлэлцүүлгийг яг саяын хэлсэн энэ 4 зорилгын хүрээнд зарцуулах төсвийг нь ТУЗ нь баталчихсан юм билээ.

Нэг тогтоол ажлын хэсгийн хүрээнд чиглэл болгоод гаргаад өгчихвөл бас зүгээр байгаа юм гэж байгаа юм.

Тэгэхээр төсөвт нь батлагдчихсан гэсэн үг.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд нэмж асуулт асууя.

Ч.Хүрэлбаатар: Баталчихсан юм бол энд ингэж оруулаад хэрэггүй дээ. Маш буруу практик шүү.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Асуулт ерөнхийдөө давхацлаа даа. Ч.Хүрэлбаатар сайдтай.

Тэгээд цаашдаа буруу жишиг тогтоод явчих вий дээ гэж. Нээрээ. Дараа нь нэг хууль баталлаа гээд л Оюу Толгойгоос тэдэн төгрөг гаргая ч гэдэг юм уу, Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс тэдэн төгрөг гаргая ч гэдэг юм уу ийм жишиг болоод тогтчихвол бас л хэцүү л болох байх даа.

Тэртээ тэргүй л батлагдсан бол одоо юу гэдэг юм ТУЗ-ийнхаа юугаар явчхаж болохгүй юу. Тийм үү.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт, санал хоёр цуг байгаа. Санал хэлж дууслаа.

Ингээд гишүүд ээ, санал хураалт явуулж эхэлье. “Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүдийн 66.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт хураалт явуулж дууслаа.

“Ажлын хэсэгт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Дараагийнхаа асуудалд орёе.

Дөрөв. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бэлтгэл ажил болон Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах

Дөрөв. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бэлтгэл ажил болон Монгол Улсын Их Хурлын 2022 оны хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн санал, дүгнэлтээ танилцуулахыг урьж байна.

Х.Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр хуульд зааснаас бусад үйл ажиллагааг иргэн, аж ахуйн нэгж чөлөөтэй эрхлэх боломж бүрдэж төрийн байгууллагаас хуулиас гадуур захиргааны хэм хэмжээний акт гарган зөвшөөрлийн тоог нэмдэг байдлыг халж, зөвшөөрлийг цахимаар, олон нийтэд нээлттэй, ил тод олгох, байгалийн баялаг, төрийн нийтийн өмч хязгаартайгаар ашиглуулахдаа шударга өрсөлдөөний зарчмын дагуу явуулах зэрэг томоохон өөрчлөлтийг хуульчилсан.

Улсын Их Хурлын 2022 оны Хууль баталсантай холбогдуулан авах

арга хэмжээний тухай 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 162 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж нар ажиллалаа.

Ажлын хэсэг Зөвшөөрлийн тухай хууль, Улсын Их Хурлын тогтоол, хэрэгжилтийн явцтай танилцаж, дараах санал, дүгнэлтийг Байнгын хороонд танилцуулж байна. Үүнд:

Улсын Их Хурлын 2022 оны хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар.

1.Тогтоолын 1-д зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж заасан бөгөөд уг арга хэмжээний хүрээнд ажлын хэсэг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 04-ний өдрийг дуустал хугацаанд ажиллаж, холбогдох албан

тушаалтнуудтай уулзан хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх талаар чиглэл өгч ажилласан бөгөөд энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хурал Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлж 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хурал эцэслэн баталсан.

Дээрх хууль тогтоомжид туссан өөрчлөлтүүдийг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.18 дахь хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1, 8.2 дугаар зүйлтэй уялдуулан тусгасан хэдий ч зарим хууль хоорондын нийцлийг хангаагүйгээс хууль, хэрэглээнд алдаа гарч байна.

Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр мэдүүлсэн 6 дугаар зүйлд, 13 дахь хэсгийн 13.16 дахь заалт хүчингүй болсонд тооцсугай гэж заасан бөгөөд өөрөөр хэлбэл биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх зөвшөөрлийг хүчингүйд тооцож, иргэн хуулийн этгээд зөвшөөрөлгүй эрхлэх боломж бүрдсэн хэдий ч тухайн салбар хууль буюу Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлтийг тусгаагүйгээс зөрчил үүссэн гэж ажлын хэсэг дүгнэж байна.

Дээрх арга хэмжээний хүрээнд хууль хоорондын нийцлийг хангаагүйгээс зөрчил үүссэн хэдий ч өөрийн эрхлэх асуудлын хүрээний хуулийн төслийг хугацаанд нь бүрэн гүйцэд боловсруулж

ажилласан төрийн байгууллагыг нь нэрлэн дурдах нь зүйтэй байна.

Тухайлбал, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Харилцаа, холбооны зохицуулах хороо зэрэг болно.

2.Тогтоолын 2-т Зөвшөөрлийн тухай хуулиар зөвшөөрлийг нэгтгэсэн, хассан, шилжүүлсэн, харьяалал өөрчилсөнтэй холбогдуулан зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа шийдвэрийг энэ хуульд нийцүүлэх, холбогдох арга хэмжээ авах гэж заасан бөгөөд уг арга хэмжээний хүрээнд дээрх арга хэмжээтэй холбоотой зарим нэг зөвшөөрлийн асуудлаар иргэн, хуулийн этгээдээс өргөдөл, гомдол ирүүлсээр байгаа бөгөөд ажлын хэсэг үүнтэй холбогдуулан төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнаас хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тодруулсан.

Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулиар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгодог байсан тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих зөвшөөрлийн тухай аймаг, нийслэлийг Засаг дарга олгохоор.

Мөн эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас давхардуулан олгодог байсан химийн болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор тус тус хувьчилсан.

Гэтэл өнөөдрийг хүртэл хугацаанд Засгийн газар болон холбогдох төрийн

байгууллагаас зохих шийдвэр гараагүй байгаа нь Зөвшөөрлийн тухай хууль, Улсын Их Хурлын тогтоолын дээрх арга хэмжээний биелэлт хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

3.Тогтоолын 3-д зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж Монгол Улсын Их Хуралд 2023 оны 1 дүгээр сарын дотор танилцуулах гэж заасан бөгөөд уг арга хэмжээний хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд 14 чиглэлээр 244 зөвшөөрлийг давхардсан тоогоор 87 эрх бүхий этгээд, 12 чиглэлээр 123 энгийн зөвшөөрөл давхардсан тоогоор 34 эрх бүхий этгээдэд зөвшөөрөл олгохоор туссан.

Давхардсан тоогоор 121 зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтоолд заасан хугацаанд хэрэгжүүлж ажиллах нь Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чухал нөлөөтэй юм.

Уг арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах талаар Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагчийн ахлагч Х.Ганхуяг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн УИХ/032186 дугаарын албан бичгээр Засгийн газар хандсан бөгөөд Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн ХЭГ/881 дугаарын албан бичигт тус асуудлын талаар холбогдох хариуг ирүүлээгүй болохыг дурдах нь бас зүйтэй байна.

Улсын Их Хурлаас холбогдох эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх боломжит хугацааг Засгийн газарт өгсөн хэдий ч өнөөдрийг хүртэл Улсын Их Хуралд танилцуулаагүй байгаа нь уг арга хэмжээний биелэлт мөн адил хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар.

Ажлын хэсэг байгуулагдсан цагаас хойш Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон хэрэгжиж эхэлснээс хойш хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу холбогдох ажлыг эрчимжүүлэх, биелэлтийг хангахад анхаарч ажиллалаа.

1.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглосон.

Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 2-т хуульд заасан журмын дагуу хүчингүй болсон бол хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага энэ тухай албан бичгийг хүчингүй болгосон захиргааны хэм хэмжээний актын хуулбарын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ гэж тус тус заасан.

Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар давхардсан тоогоор 87 эрх бүхий этгээд 244 тусгай зөвшөөрөлтэй холбоотой, 34 энгийн зөвшөөрөлтэй холбоотой 123 нарийвчилсан дүрэм, журам мөрдөгдөж байгаа талаарх судалгааг ажлын хэсэг гаргасан.

Өөрөөр хэлбэл хуулийн зохицуулалттай нийцүүлэн 270 захиргааны хэм хэмжээний актад холбогдох өөрчлөлтийг хийх ёстой.

Дээрх асуудалтай холбогдуулан Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн ХЭГ/881 дүгээр албан бичигт дурдсанаар 3 төрийн

байгууллагын 4 захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлээс хассан мэдээллийг ирүүлсэн байна.

2.Зөвшөөрлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлээр зөвшөөрлийг кодлох асуудлыг асуудлыг 7.1 дүгээр зүйлээр зөвшөөрлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн асуудлыг тус тус зогсоосон.

Өөрөөр хэлбэл зөвшөөрлийг кодлох, зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн өргөдлийг цахимаар хүлээн авах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эдийн засаг хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллахаар. Уг мэдээллийн нэгдсэн санд эрх бүхий этгээд өргөдлийн явцын мэдээлэл, шийдвэр бүртгүүлж байх үүргийг хуулиар хүлээсэн.

Энэ ажлын хүрээнд Засгийн газраас шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд үүний нэг нь нэгдсэн сангийн системийн хөгжүүлэлт болох “**license.mn**” вебсайтыг ажиллуулж эхэлсэн байна.

Өнөөдрийн байдлаар уг вебсайтад Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон 12 төрийн захиргааны төв байгууллага, 4 захиргааны байгууллага, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагаас олгож буй зөвшөөрлийн төрөл, тухайн зөвшөөрлийг авсан хүн, хуулийн этгээдийн мэдээллийг байршуулсан байна.

Гэсэн хэдий ч зарим төрийн байгууллага хуульд заагаагүй үйл ажиллагааг зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаанд тооцож тус вебсайтад байршуулсан байна.

Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зөвшөөрлийн тухай хуульд тусгаагүй 60 гаруй үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл дээр эрхлэхээр оруулсан байх бөгөөд тухайн мэдээлэл Засгийн газарт хяналт тавихгүйгээр олон нийтэд хүргэж байна.

Мөн зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг сан зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөхтэй холбогдсон журам өнөөдрийг хүртэл батлагдаагүй байна.

3.Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлээр зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээд, түүний чиг үүргийг хуульчилсан.

Засгийн газраас ирүүлсэн мэдээлэлд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөл байгуулагдаагүй байна.

Холбогдох журам батлагдаагүй байна.

Ер нь Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхлээд 5 сар өнгөрч байгааг онцлон дурдмаар байна.

Ажлын хэсэг байгуулагдсан цагаас хойш төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтантай уулзаж хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцтай танилцахад дээр дурдсан асуудлуудаас гадна Засгийн газар хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, сургалт зохион байгуулах зэрэг ажлыг нэгдсэн журмаар хийгээгүй.

Олон нийт тус хуулийн талаар төдийлөн сайн ойлголтгүй байна.

Иймд ажлын хэсэг Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хангуулах талаар Байнгын хорооноос холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулах саналыг гаргаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн танилцуулга хийсэнд баярлалаа.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Та дэндүү сайн дүгнэлтээ уншсан учраас ерөөсөө бүгдийг нь ойлгоод, хариултаа аваад ингээд дуусчихлаа шүү дээ.

Ингээд гишүүд асуулт асууж, санал хэлэлцэж дууслаа.

Ингээд ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцаж дууслаа.

Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг тус тус үндэслэн боловсруулсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тогтоолын төслөө танилцуулахыг урьж байна.

Х.Ганхуяг гишүүний микрофоныг нээнэ үү.

Х.Ганхуяг: Үүнтэй холбоотойгоор саяын санал, дүгнэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулж батлуулмаар байгаа юм.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль болон нэмэлт, өөрчлөлт.

Тухайлбал, 6 дугаар зүйл буюу зарим зөвшөөрлүүдийг хүчингүй болгочоод байхад тухайн салбарынхаа хуулийг өргөн мэдүүлэхгүй байснаараа нөгөө зөвшөөрлөө нэхээд яваад байгаа асуудал үүсчээд байгаа юм.

Одоо тухайлбал, нөгөө биологийн идэвхт бүтээгдэхүүн витамин гээд бид чуулган дээр зөвшөөрөл нь асчихсан чинь нөхдүүд өөрсдөө салбарын хуулиараа нөгөө зөвшөөрлөө нэхсэн хэвээрээ, нөгөө бүртгэлд авдаг хэвээрээ. Тэгээд гааль дээр ирэхээр хурааж авдаг хэвээрээ байгаад байгаа юм. Тийм.

Тэгэхээр энэ дээр яалт ч үгүй бид энэ юуг нь нийцүүлж оруулж ир гэдэг шаардлагыг тавих гэж байгаа юм.

Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн бүрэн хамруулах, холболт хийх, нэвтрүүлэлт хийх.

Зөвшөөрлийн нэгдсэн сангийн цахим системийг үүсгэх, хөгжүүлэх, хяналт тавих, цахим системийн мэдээллийн чанар, уялдаа холбоо сайжруулах, мэдээллийн олон нийтэд нээлтэй, ил тод байлгах зэрэг арга хэмжээнүүдийг авахыг энэ тогтоолоор даалгах гэж байгаа юм. Засгийн газарт.

Байнгын хорооны дарга үүнийг нь танд өгчих үү. Байгаа. Тийм ээ.

Иймэрхүү байдлаар тогтоолын төсөл гарах юм.

Ц.Цэрэнпунцаг: Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэл хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. /алх цохив/

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1/Улсын Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлээр зарим зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсонтой холбогдуулан салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг бүрэн хамруулах, холбох, нэвтрүүлэлт хийх, зөвшөөрлийн нэгдсэн сангийн цахим системийг үүсгэх, хөгжүүлэх, хяналт тавих, цахим системийн мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулах, мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод байлгах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлыг эрчимжүүлэх;

3/тогтоолын 2 дахь заалтад заасан арга хэмжээний талаарх тайланг Улсын Их Хуралд 2023 оны 10 дугаар сард багтаан танилцуулах;

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд санал хураалт явуулж эхэлбэ.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжбэ гэсэн томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 53.8 хувийг нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе. Ажлын хэсгийг оруулаарай.

Тав. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны нэгдсэн тайланг хэлэлцэж эхэлье.

Тайлангийн танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хийнэ. Д.Баярсайхан дарга та танилцуулгаа хийнэ үү. Д.Баярсайхан дарга 3 номер дээр. Ажлын хэсгийн 3 номерыг нэе.

Д.Баярсайхан: Эдийн засгийн байнгын хороон дарга болон гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг дараах байдлаар Та бүхэнд танилцуулъя.

Агуулгын хувьд хорооны үйл ажиллагаа, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ, сургалт, судалгаа, хамтын ажиллагаа, хяналт шалгалт болон сэндбоксын зохицуулалт, Монгол Улсын терроризмын санхүүжилттэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг хангах, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн онцлог зохицуулалт болон цаашдын буюу 2023 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний танилцуулга хэлбэрээр гишүүдэд хүргэе.

Санхүүгийн зохицуулах хороо 2022 онд 9 газар, 5 хэлтэс, 6 алба, 198 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Энд нэг онцлогтой зүйл байгаа. Ялангуяа Мөнгөн зээлийн тухай хууль батлагдсантай холбогдон Мөнгөн

зээлийн зохицуулалтын албыг шинээр байгуулсан.

Дээрээс нь мөн Сэндбоксын албыг тусад нь гаргаж хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд ажиллаж байна.

Мөн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль батлагдсантай холбоотой виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтэс нэмэгдсэн байгаа.

Өөрөөр хэлбэл 2022 онд хороонд шинээр 2 алба, 1 хэлтсийг зохион байгуулалтдаа шинээр оруулж ажиллаж байгаа гэдгийг дурдах байна.

Санхүүгийн зохицуулах хороо үйл ажиллагаандаа нийт 27 хууль, 119 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.

Хороо маань 2022-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг баталсан байгаа.

Энэ хүрээндээ хөрөнгө оруулагчид үйлчлэлийн итгэлийг хүлээсэн ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлооно гэсэн ийм зорилт, зорилгын хүрээнд нэлээдгүй ажлуудыг хэрэгжүүлээд явж байна.

Үндсэндээ энэ арга хэмжээний хүрээнд 78 ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байгаа.

Хорооны энэ дунд хугацааны стратегийг боловсруулахдаа юуны өмнө санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх 2023-2024 оны төлөвлөгөө Санхүүгийн

тогтвортой байдлын зөвлөлөөр батлагдсан төлөвлөгөө байдаг.

Дээрээс нь “Алсын хараа-2050” ухаалаг санхүүгийн зах зээлийн хэсгүүдийн үйл ажиллагааг мөрдлөг болгож хамтад нь боловсруулсан байгаа гэдгийг хэлэхэд таатай байна.

Хорооны үндсэн үйл ажиллагаа хорооны хуралдаан байдаг.

Өнгөрсөн 2022 онд нийт 25 удаа хуралдаж, 739 тогтоол гаргасан байгаа.

Хуралдаан сардаа 2 удаа явагддаг. Хуваарийн дагуу хоёр дахь болон дөрөв дэх долоо хоногуудад Мягмар гарагт тус тус хуралддаг байгаа.

Хорооны үйл ажиллагаа хэвийн тогтмол байгаа гэдгийг хэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 оны 11 сарын 17-нд батлагдсан байдаг.

Хорооны үйл ажиллагаа хорооны дарга болон гишүүд томилогдсоноор 2006 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

2020 оны 01 сарын 01-н гэхэд Санхүүгийн зохицуулах хороо үндсэн 4 салбарын хяналт зохицуулалтын ажлыг хийж гүйцэтгэж ирсэн. Өөрөөр хэлбэл хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааны хяналт зохицуулалтыг хийсэн бол, нэлээдгүй олон хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбоотойгоор яг өнөөдрийн байдлаар 11 салбарын хяналт зохицуулалтын үйл ажиллагааг хариуцаж хийж гүйцэтгэж байна.

Өөрөөр хэлбэл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 1 сард өөрчлөлт орсон.

Монгол Улс мөнгө угаалт, терроризмын санхүүжилттэй тэмцэх олон улсын байгууллагуудаас стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орсонтой холбоотойгоор үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт металл, түүгээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарыг яаралтай хяналт зохицуулалтад авах шаардлагатай байна гэж үзсэний үндсэн дээр өөрөөр хэлбэл санхүүгийн бус бизнесийн хоёр салбарыг нэмж хяналт, зохицуулалтад оруулаад явж байгаа.

Дээрээс нь Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой системийн нөлөө бүхий банкнуудыг олон нийтийн болгох үйл явц хэвийн төлөвлөгөөний дагуу явж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Дээрээс нь Санхүүгийн зохицуулах хорооноос сүүлийн үед энэ санхүүгийн зах зээл дээр ялангуяа технологийн дэвшилтэй холбоотойгоор шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ олон улсад их гарч байгаа.

Үүнийг зохицуулах шинэ зохицуулалтын орчин нь сэндбоксын зохицуулалтын орчин байдаг. Үүнийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр оруулаад сэндбоксын зохицуулалтыг Монгол Улсад бий болгосонтой холбоотойгоор манайх олон нэр төрлийн, ялангуяа хууль эрх зүйн тийм зохицуулалт байхгүй салбаруудыг туршиж бойжуулаад амьдрах чадвартай бүтээгдэхүүн гаргах зориулалтаар Сэндбоксын зохицуулалтын албыг бий болгоод нэлээдгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаад ажиллаж байна.

Дээрээс нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсан байгаа.

Ялангуяа ФАТФ-аас бодлогын зөвлөмжийн 15-д энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдэд тодорхой хэмжээний хяналт тавьж бүртгэлжүүлэх үйл ажиллагаа тавихыг Монгол Улсад шаардлага болгосон байгаа.

Энэ хүрээнд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль батлагдсантай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо энэ салбарын үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдэд хяналт, бүртгэлийн үйл ажиллагааг 2022 оноос хэрэгжүүлээд явж байна.

Он гарсны дараагаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль 03 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бас энэ бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлээд явж байна.

Энэ дотор иргэд болон ломбард, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгч этгээдүүдийг бүртгэж, хяналт зохицуулахаар ийм хуулийн заалт туссан байгаа.

Дээрээс нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 07 сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ.

Энэ хүртэл нүүрсийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулж арилжаа хийгддэг болсон. Энэ хүрээнд бас хяналт зохицуулалтын ажлыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байгаа гэдгийг хэлмээр байна.

Ингээд одоо яг өнөөдрийн байдлаар нийт 11 салбарын хяналт зохицуулалтын үйл ажиллагааг хороо хариуцан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж явж байна.

Бидний хувьд өнгөрсөн 2022 онд КОВИД болон цар тахлаас үүдэлтэй.

Дээрээс нь Улсын Их Хурлаас баталсан бодлого, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.

Анх удаагаа зээлийн хүү бууруулах стратеги батлахад энэ дотор Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, тэр дотроо бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах гээд заалт тусгасан.

4 чиглэлийн 18 дэд арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр байгаа. Биелэлт нь 97.2 хувьтай явж байгаа гэдгийг хэлмээр байна.

КОВИД-19 цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх гээд Улсын Их Хурлын 32 дугаар тогтоол байгаа.

Энэ хүрээнд 4 чиглэлийн 6 дэд арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Дээрээс нь Монгол Улсын санхүүгийн салбарын хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийг санхүүгийн зохицуулах хороо өөрсдөө санаачилж Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлуулсан байгаа.

Энэ биелэлт нэг 83.8 хувьтай байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Ер нь санхүүгийн үйлчилгээний хүртээмжид онцгой анхаарч байгаа нь Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн гишүүнээр ажилладаг.

Энэ ерөөсөө тухайн улсуудын санхүүгийн салбарын зохицуулагч

байгууллага төв банкнууд гишүүнчлэлтэй ийм байгууллага байдаг. Энэ хүрээндээ Монгол Улсыг төлөөлөөд Санхүүгийн зохицуулах хороо гишүүнээр ажиллаж байгаа.

Энэ хууль эрх зүйн хүрээнд нэмэлт, өөрчлөлт орсон салбарууд маань өсөхийн хэрээр манай зохицуулалттай этгээдүүдийн тоо огцом нэмэгдэж байгаа. 2018 онтой харьцуулахад манай зохицуулагч этгээдүүдийн тоо 58.3 хувийн өсөлттэй харагдаж байна.

Нийт даатгалын төлөөлөгчдийг оролцуулах юм бол 6092 хуулийн этгээдтэй Санхүүгийн зохицуулах хороо ажиллаж байна гэдгийг хэлмээр байна.

Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтад байдаг салбарын хувьд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар нь харах юм бол 23.2 хувь нь Санхүүгийн зохицуулах хорооны манай үндсэн салбаруудад харьяалагдаж байна.

Зүгээр энд бас нэг зүйлийг хэлэхэд юу гэдэг юм, үл хөдлөх хөрөнгө, үнэт металл, түүгээр арилжаа эрхлэгчид, банкнууд, бас системийн нөлөө бүхий банкнууд олон нийтийн компани болсонтой холбоотой. Бусад статистикийг оруулаагүй байгаа. Зөвхөн хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоод тус тус энэ график дээр үзүүлсэн хувь хэмжээтэй байгаа.

Энэ дотроо сүүлийн жилүүдэд хамгийн өндөр өсөлт үзүүлсэн салбар хөрөнгийн зах зээл байгаа. Одоогоор дотоодын нийт бүтээгдэхүүний 14.3 хувьтай тэнцэж байна.

Салбар тус бүрээр бас Санхүүгийн зохицуулах хорооноос бодлого,

зохицуулалтын ямар арга хэмжээ авав. Тухайн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар товчхон танилцуулгыг хийе гэж бодож байна.

2022 онд Санхүүгийн зохицуулах хорооноос нэлээдгүй бодлогын шийдвэрүүдийг гаргасан байгаа. Ялангуяа энэ хөрөнгийн зах зээл дээрх бүртгэлийн журмыг олон улсын стандартад нийцүүлж хувьцааны болон бондын бүртгэл гэж ангилж өгсөн.

Дээрээс нь давхар бүртгэлийн журмыг баталсантай холбоотойгоор олон улсын бирж хооронд бүртгэлтэй байгаа компаниудын хувьцаа чөлөөтэй хөрвүүлэлт хийгддэг боллоо.

Төлбөрийн эсрэг нийлүүлэлт буюу олон улсын жишигт нийцүүлээд “Т+2” горимд шилжсэн байгаа.

Дээрх олон үзүүлэлтүүдийн үр дүнд FTSE /Financial Times Stock Exchange/-ийн Хөгжиж буй зах зээлийн ангилалд Монгол Улс ажиглагчаар орсон. Энэ үйл ажиллагаа энэ оны 9 сараас эхэлж хэрэгжихээр байгаа гэдгийг хэлмээр байна.

Өөрөөр хэлбэл энэ урьдчилсан нөхцөлүүдийг хангасны үндсэн дээр системийн нөлөө бүхий банкнууд олон нийтийн болох.

Дээрээс нь төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг биржээр дамжиж олон нийтийн болох энэ үйл ажиллагаа амжилттай хэрэгжээд явж байна гэдгийг дурдах нь зөв байх.

Бас нэг онцгой анхаарч ажилласан ажил бол одоо ялангуяа энэ хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгох, арилжаа эрхлэгч байгууллагуудын бүртгэлд бүртгүүлэхдээ анхдагч болон хоёрдогч дахь зах зээлийн

арилжааг эхлүүлэх зохицуулалтыг олон улсын жишигт нь нийцүүлээ.

Дээрээс нь анхны нээлттэй буюу хаалттай сангууд бий болж, хөрөнгийн зах зээл дээр нэгж эрхээ амжилттай арилжаалаад, эндээс татсан хөрөнгөөрөө юу гэдэг юм байгаа юм бусад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ энд энэ “**institutional investor**” бий болох хүрээндээ ороод ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Энэ том зургаар нь харах юм бол одоо бидний хувьд хөрөнгийн зах зээл мэргэжлийн оролцогчдын талбар байгаа.

Энэ хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, суурь баазыг бэхжүүлэхэд ажиллаж байна.

Гэхдээ цаашдаа энэ тал дээр илүү их ажиллах, анхаарах асуудлууд байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулсан. Энэ нь үнэт цаас болон хувьцааны арилжааны идэвхжилийг бий болгоход бас тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байгаа.

Өөрөөр хэлбэл арилжаа эрхлэгч байгууллагын авдаг хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсийг үнийн дүнгийн 1 хувиас 0.25-аас 0.5 хувь болгож бууруулсан байгаа.

2023 оны төсвийг Улсын Их Хуралд өргөн барихтай холбоотойгоор Монгол Улсын Засгийн газраас хөрөнгийн зах зээлийгээ дэмжих гэдэг агуулгын хүрээнд татварын нэлээдгүй хөнгөлөлтүүдийг хөрөнгийн зах зээл дээр хүлээж байсан. Энэ хөнгөлөлтүүдийг үзүүлдэг болсон. Хөрөнгө оруулалтын сангаас авах татварыг тэглэсэн байгаа.

Дээрээс нь энэ IPO-той холбогдсон зардлыг татвараас суутгаж тооцохоос чөлөөлдөг болсон гэх мэтчилэн олон хөнгөлөлтүүдийг дурдах нь зөв байх.

Банкны IPO болон төрийн өмчит хувьцаа компаниудын олон нийтийн болох үйл явц яг төлөвлөсөн хуваарийн дагуу явж байна.

Энэ оны 06 сарын 31 гэхэд арилжааны системийн нөлөө бүхий 5 банк бүгдээрээ олон нийтийн болох ёстой. Өнөөдрийн байдлаар Төрийн банк, Голомт, ХААН банкнууд IPO-гоо амжилттай хийгээд энэ олон нийтийн компани болсон.

Өнөөдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд Худалдаа хөгжлийн банк болон Хас банкнууд IPO хийх хүсэлтээ хүргүүлсэн. Материалыг нь хянаж байна.

Улсын Их Хурлаас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2022 оны 12 сарын 23-ны өдөр баталсан байгаа.

Үүнтэй холбоотойгоор хэрэгжилтийг хангуулах, холбогдох дүрэм журам, заавруудыг гаргах, дэд бүтцийг бэлэн байдалд шилжүүлэх талаар онцгой анхаарч холбогдох газрууддаа ажиллаж байна.

Засгийн газраас экспортод гаргасан нүүрсний нээлттэй цахим арилжааны журмыг энэ оны 01 сарын 12-ны өдөр баталж анхны нүүрсний арилжаа амжилттай хийгдсэн гэдгийг хэлмээр байна.

Хорооны зүгээс дээрх нүүрсний арилжаанд хяналт тавьж ажиллаж байна.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өчигдөр 8.7 их наяд байсан бол яг өнөөдрийн байдлаар 9 их наяд давчихлаа. Хамгийн өндөр өсөлттэй жилүүд гэдэг юм уу 2008, 2009 оны хувьд зах зээлийн үнэлгээ 3 их наяд л байсан.

Ингээд зах зээлийн идэвхжил нэмэгдсэн. Тодорхой хууль, эрх зүйн зохицуулалт, хорооноос гаргасан бодлогын шийдвэрүүдийн үр дүнд өнөөдөр манай дэд бүтцийн байгууллагуудын оролцоотойгоор энэ хөрөнгийн зах зээлийн өсөлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.4 хувиар өссөн байгаа. 2022 оны жилийн эцсээр 6.8 их наяд төгрөгт хүрсэн байна.

Хөрөнгийн зах зээл дээр ер нь түүхэндээ 3 бүтээгдэхүүнтэй л явж ирсэн л дээ. Бидний хувьд сүүлийн 30-аад жилийн хугацаанд. Тийм ээ. Үнэт цаас, бонд, тэгээд Засгийн газрын үнэт цаас гэсэн л 3 төрлийн бүтээгдэхүүнтэй байсан бол одоо сүүлийн 2 жилийн хугацаанд хөрөнгийн зах зээл дээр 58 шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй болсон гэдгийг хэлмээр байна.

Ангилаад үзэх юм бол бидний хувьд компанийн бонд, хувьцаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан.

Дээрээс нь анхны төгрөг, долларын хосолсон бонд, дижитал цахим бонд ч байдаг юм уу олон нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ гарсан гэдгийг хэлмээр байна.

Ингээд сүүлийн 32 жилийн хугацаанд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах үндсэн хэлбэр маань Монголын хөрөнгийн биржээр дамжуулж явагдаж байсан бол одоо манай салбар давхар дугуйтай болсон.

Өөрөөр хэлбэл биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг өнгөрсөн онд хэрэгжүүлж эхэллээ.

Энэ хугацаанд мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас богино хугацаанд өртөг, зардал багатайгаар санхүүжилт татах ийм орон зай болсон гэдгийг онцолж хэлмээр байна.

2022 оны эцсээр 45 үнэт цаас гаргагч этгээд 498.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бонд хэлбэрээр биржийн бус зах зээлээс татсан байгаа.

Захиалгынх нь дүн 1 их наяд давчихсан байгаа гэдгийг хэлмээр байна.

Яг өнөөдрийн байдлаар биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа нь эхэлснээсээ хойш 61 үнэт цаас гаргаж 1.42 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 78 компанийн бонд гарсан байна гэдгийг хэлмээр байна.

Нүүрсний арилжааны хувьд өчигдрийн байдлаар 1.2 сая тонн нүүрс 646.5 тэрбум төгрөгөөр биржээр дамжуулж арилжаалагдсан дүнтэй байгааг хэлмээр байна.

Хөрөнгийн зах зээл маань хөгжлийн дараагийн шатад гарахад харьцангуй хууль эрх зүйн зохицуулалтуудаас гадна холбогдох дэд бүтцийн байгууллагууд ачааллыг дааж бэлэн болсон гэдгийг хэлмээр байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын 2 сая 446 мянга 290 иргэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр данстай болсон.

Гэхдээ энэ нь цаашдаа бид иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, ялангуяа санхүүгийн дундын байгууллагуудын чадавхыг сайжруулах, оролцогчдыг мэдээ мэдээллээр хангах

гээд нэлээдгүй ажлууд дээр анхаарч ажиллахаар байгаа гэдгийг хэлмээр байна.

Ер нь топ 20 индексийн бүтцээс нь харах юм бол аж үйлдвэр дийлэнх нь. Уул уурхай, банк санхүүгийн салбар, худалдаа үйлчилгээ, харилцаа холбооны салбарууд энэ топ 20 индекс дотор багтаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Даатгалын салбарын хувьд нэлээдгүй ажил, зорилтыг хэрэгжүүлсэн ийм он байлаа.

Даатгалын санамж салбарын ялангуяа энэ хөрөнгийн зах зээл дээр оролцох оролцогч байдаг. Даатгалын компаниуд болон даатгалын компаниудын нөөц сангууд зайлшгүй хөрөнгийн зах зээлийн үндсэн оролцогч тоглогч нар байдаг.

Энэ хүрээндээ даатгалын компаниудыг чадавхжуулах, энэ нь магадгүй “institutional investor” бий болоход нөхцөлийг нь сайжруулах гээд нэлээдгүй анхаарал тавьж ажиллалаа гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь даатгалын баталгааны эрх зүйн орчныг бүрдүүллээ. Өөрөөр хэлбэл иргэд орон сууцын ипотекийн зээлийн болон урьдчилгаа төлбөр.

Дээрээс нь аж ахуйн нэг бизнес эрхлэгчид тендер зээлийн баталгаанд даатгагчийн баталгаа гаргах ийм хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байгаа.

Энэ хүрээнд ялангуяа компаниудын хувьд аливаа төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тендерт оролцохдоо зайлшгүй банкны баталгаа гаргадаг ийм хүндрэл байхгүйгээр даатгалын компаниудаар баталгаа гаргах орон зайг нээсэн гэдгийг хэлмээр байна.

Энэ тал дээр одоо яг даатгалын компаниуд тухай бүртгээ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаад ажиллаад явж байна.

Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна.

Үүнийг Засгийн газраас өргөн барихаар байгаа. Өөрөөр хэлбэл холбогдох яамдаасаа саналыг нь аваад Сангийн яаман дээр нэгтгэгдээд явж байна. Улсын Их Хурлын чуулгандаа өргөн барина гэсэн төсөөлөлтэй ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь урт хугацааны буюу амьдралын даатгалын компаниудыг бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулах тал дээр онцгой анхаарч байна. Урт хугацааны даатгалын компани 14 жилийн дараа шинээр нэмэгдэж, одоо ийм 2 компани үйл ажиллагаа явуулж байна.

Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлалыг бас даатгалын салбарт шинээр оруулж ирлээ.

Мөн дээрээс нь ногоон санхүүжилтийн энэ эко системийг бүрдүүлэхэд даатгалын салбарын үүрэг, оролцоог нэмэгдүүлж, цаг уурын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдол зэргийг бууруулахад даатгалын салбарын үүрэг нөлөөг нэмэгдүүлэх талаар бас анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь түрүүн хэлсэн. Хөрөнгийн зах зээлийн гол тоглогч байдаг гэж. Тавигддаг тодорхой шаардлагууд байдаг. Үүнийг 10 хувиар чөлөөлж өгснөөр хөрөнгийн зах зээл дээр 183 тэрбум төгрөг даатгалын салбараас орох бололцоог нээсэн.

Өнөөдрийн байдлаар даатгалын 4 компани олон нийтийн хэлбэртэй нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Цаашдаа ч гэсэн бусад компаниуд бас олон нийтийн болох төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хороонд хүргүүлсэн байгаа гэдгийг хэлбэ.

Даатгалын салбарын маань нийт хөрөнгө өнгөрсөн оны мөн үеэс 11.6 хувиар өсөөд 474.9 тэрбум төгрөгт хүрлээ.

Нийт хөрөнгө өссөнтэй холбоотой нөөц сангууд бас өсөж байгаа. Сангийн хэмжээ 12 хувиар өссөн байгаа.

Мөн 2021 онд нөхөн төлбөрт 70 орчим тэрбум төгрөг олгогдож байсан бол 34.9 хувиар өсөөд 2002 онд 94.4 тэрбум төгрөг нөхөн төлбөр хэлбэрээр иргэдэд олгогдоод явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Хорооны хувьд бас нэг даатгалын салбарт анхаарах зүйл бол энэ давхар даатгалын орлогыг Монгол Улсад үлдээх. Өөрөөр хэлбэл давхар даатгалын үндэсний компанийн чадавхжуулах.

Монгол Улсын Засгийн газар болон Улсын Их Хурлаас төрийн болон орон нутгийн өмчийн 25 аж ахуйн нэгжийн 34 хүртэлх хувийг хөрөнгийн биржээр дамжуулж арилжаал гээд тогтоол гарсан байгаа. Үүнтэй холбоотойгоор үндэсний давхар даатгал компани олон нийтийн компани болох энэ үйл явц амжилттай хэрэгжиж байна.

Хорооноос зөвшөөрлөө авчихсан байгаа. 6 сарын хугацаанд энэ олон нийтийн болох үйл явц нь хэрэгжинэ гэж бид хүлээлттэй байгаа.

Тэгэхгүй бол даатгалын салбарын давхар даатгалд ер нь даатгалын хураамжийн орлогын 40 орчим хувь нь гадагшаагаа гараад явчихдаг.

Өнгөрсөн онд гэхэд 300 орчим тэрбумын ердийн болон урт хугацааны хураамжийн орлого орсон байгаа. 300 тэрбум. Үүний 100 тэрбум нь гадагшаагаа давхар даатгал хэлбэрээр гарчихсан байгаагаас энэ дүр зураг харагдаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Банк бус санхүүгийн байгууллагын хувьд хуулиа Улсын Их Хуралд өргөн барьсан. Ажлын хэсэг гарсан. Одоо энэ банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт биш бүр шинэчилсэн найруулга хэлбэрээр ажиллаж байгаа.

Хуулийн төсөл дээр манайхан ажиллаж байгаа.

Тэгээд гол өөрчлөлт 2019 онд Санхүүгийн зохицуулах хороон дээр Эдийн засгийн байнгын хорооны гишүүд очиж ажилласан. Энэ хүрээндээ бас тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээнийх нь чиглэлээр төрөлжүүлэх нь зүйтэй юм гэсэн зөвлөмж өгсөн.

Энэ хүрээнд хууль боловсруулагдаад өргөн баригдсан байгаа гэдгийг хэлмээр байна.

Өөрөөр хэлэх юм бол яг зээлийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, факторингийн үйл ажиллагаа гээд 3 үндсэн чиг үүргээр нь банк бус санхүүгийн байгууллагуудыг ангилаад тэрэнтэй холбоотойгоор тэр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн онцлог тус бүрд нь тааруулаад суулгаж өгсөн байгаа.

Дээрээс нь энэ валют арилжааны чиглэлийн 150 гаруй банк бус санхүүгийн байгууллага зөвшөөрөлтэй байдаг. Тийм.

Тэгээд эдгээрийг бидний хувьд банк бус санхүүгийн байгууллага гэдгээр нь биш валют солих цэг гэдэг хэлбэрээр нь үйл ажиллагааг нь өөрчлөхөөр төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Бас нэг онцлогтой зүйл бол яалт ч үгүй л тогтвортой ногоон санхүүжилтийн орчныг энэ “**green taxonomy**” буюу энэ “ногоон таксоном”-ийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр баталсан байгаа.

Энэ хүрээнд Монголын ногоон таксономи 8 ангиллын хүрээнд ногоон зээлийн бүтээгдэхүүн болон санхүүгийн жендэрийн үзүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлсэн байгаа. Үүнтэй холбоотой мэдээ мэдээллийг цаг тухай бүр салбарын статистик болгож шахаж шаардаж авч байгаа гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь банк бус санхүүгийн байгууллагаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд өр орлогын харьцаа тогтоолоо.

Өөрөөр хэлбэл зээлийн давхардал үүсэхээс зайлах, ялангуяа иргэдэд очих тэр зээлийн дарамтыг багасгах хүрээнд банкны салбарт хэрэгжүүлж байгаа тэр өр орлогын харьцааг банк бус санхүүгийн байгууллагуудын салбарт оруулж ирж мөрдүүлж байна гэдгийг хэлмээр байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 513 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт 1 сая 187 мянга 603 зээлдэгчид байна. Энэ зээлдэгчдийн

дйлэнх нь буюу 78.8 хувь нь финтекийн зээлдэгчид байгаа.

Тэгээд энэ финтек гэдэг нэр томъёог банк бус санхүүгийн байгууллагын хуульд анх удаагаа бид оруулж томъёолж өгсөн байгаа.

Ер нь салбарын дундаж зээлийн хэмжээ 2.3 сая төгрөг байдаг. Гэтэл финтекийн зээл 492.6 мянган төгрөг байгаа.

Ер нь санхүүгийн үйлчилгээний хүртээмж тал дээр банк бус санхүүгийн байгууллагууд ажилладаг гэдгийг хэлэх нь зөв байна.

Гэхдээ цаашдаа энэ салбарт тавих хяналт, зохицуулалтын ажил болон бусад санхүүгийн тэр зохистой харьцааны шаардлагуудыг нь өндөрсгөж байгаа гэдгийг бүр онцолж хэлмээр байгаад байгаа юм.

Өр орлогын харьцаа. Тийм ээ. 70, 30-аар тавигдсан байгаа.

Хадгаламж зээлийн хоршоодын хувьд хадгаламж зээлийн хоршооны шинэчилсэн найруулгын төсөл дээр ажиллаад бэлэн болчихсон. Нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдээр өргөн бариулахаар ажиллаж байна.

Энэ хүрээндээ бид ялангуяа тэр эрсдэлийг буулгах олон шатлал бүхий ийм эрсдэлийн тогтолцоог бий болгохоор зорьж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол хоршоод өөрсдөө эрсдэлийн нөөц сангууд байдаг. Үүний дээр дээвэр холбоо гээд “**mandatory**” буюу заавал гишүүнчлэлтэй байхаар дээвэр холбоог бий болгоод, дээвэр холбоон дээр тогтворжилтын сан. Бүр дээшлэх юм бол хадгаламж

хамгаалалтын даатгалын тогтолцоонд хамруулья гэж ярьж байгаа.

Энэ хэрэгжих юм бол одоо энэ хадгаламж зээлийн хоршоод яг олон улсын жишигт бүрэн нийцэх, эрсдэлээ бүрэн даатгуулах ийм үндэс суурь болно гэж бид төсөөлж ажиллаж байгаа.

2022 оны жилийн эцсээр 196 хадгаламж зээлийн хоршоо ажиллаж байна.

Бүсчлээд харах юм бол баруун бүсэд 40 хадгаламж зээлийн хоршоо, хангайн бүсэд 19 хадгаламж зээлийн хоршоо, төвийн бүсэд 21 хадгаламж зээлийн хоршоо, зүүн бүсэд 9 хадгаламж зээлийн хоршоо үйл ажиллагаагаа явуулж байна.

Яг сумын түвшинд хадгаламж зээлийн хоршоод маань өөрийн гишүүдэд үйлчилдэг байгууллага гэсэн хэдий ч яг санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн хувьд банкнуудын дараа орж яг энэ санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэж байгаа байгууллага хадгаламж зээлийн хоршоо гэж бид ойлгодог.

Мэдээж энэ чиглэлийн үйл ажиллагааг яг тэр олон улсын жишигт нь нийцүүлэх талаар бодлогын болон хууль эрх зүйн зохицуулалтууд дээр өөрчлөлт оруулахаар онцгойлж анхаарч байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Хорооны чиг үүрэгт хоёр салбар байгаа. Санхүүгийн бус бизнесийн салбарууд.

Та бүхэн мэдэж байгаа. Мөнгө угаалт, терроризмын санхүүжилттэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд бид үл хөдлөх эд хөрөнгийн зуучлал болон үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн хяналт, зохицуулалтыг хариуцаж ажиллаж байна.

Бидний хувьд бүтэц, зохион байгуулалттай газар байгуулаад, газар маань бас хяналт шалгалтын функцийг давхар хариуцаж үйл ажиллагааг нь явуулж байгаа. Нэлээдгүй ачаалалтай байдаг.

Ер нь цаашдаа Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд санхүүгийн бус бизнесийн үйл ажиллагаа байх нь зөв, үгүй талаар бид тодорхой газруудтай санал солилцоод өөрсдийнхөө саналыг хүргүүлж ажиллаж байгаа гэдгийг хэлье гэж бодож байна.

Манайхаас тусгай зөвшөөрөл авснаар үл хөдлөх хөрөнгийн зуучлал, худалдан борлуулах, түрээслэх, хөлслүүлэх, үл хөдлөх хөрөнгө зуучлалын менежментийн үйл ажиллагааг хариуцаж явуулдаг байгаа гэдгийг хэлье.

2 мянга виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн ажил хийгдсэн. Энэ хүрээндээ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдэд тодорхой шаардлагуудыг тавьж байгаа.

Өөрөөр хэлбэл үйлчилгээ үзүүлэгчийн этгээдүүдэд тавигдах үйл ажиллагааны журмыг нь баталлаа.

Дээрээс нь зайн болон газар дээрх хяналт шалгалт хийх үйл ажиллагаа хэрэгжээд явж байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хязгаарлалтыг нь тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах, тохиромжтой этгээдүүд ямар нөхцөл шаардлагууд тавьдаг. Тэгээд зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоохоос авхуулаад мэргэжлийн

холбоодод тавигдах шаардлагуудыг журамлаж өгсөн байгаа.

Энэ хүрээндээ 2022 оны эцэст 11 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэсэн. Он гараад нэг нэмэгдээд одоогоор 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээд үйл ажиллагаагаа явуулж байна.

15 компанийн үйл ажиллагааг бүрмөсөн зогсоосон байгаа.

Хяналт зохицуулагчдын зүгээс эдгээр газруудад хийгдэх аудитын шаардлага нэлээн өндөр байгаа. Үүнтэй холбоотой 3 хуулийн этгээдэд аудит хийхээр бүртгэгдсэн.

Дээрээс нь олон улсын хяналт, зохицуулагчид **coin, token**, энэ шилжилт хөдөлгөөнийг нь араас нь мөрддөг ийм “**Chainalysis**” гэж программыг Монгол Улс анх удаа авч ашиглаж байна.

Үүнтэй холбоотойгоор мөнгөний тэр виртуал хөрөнгүүдийн шилжилт хөдөлгөөнийг бас хянадаг болсон гэдгийг хэлмээр байна.

Нийт Монгол Улсад 66 **coin, token** гарсан. Өнөөдрийн байдлаар 25 нь хасагдаад 41 нь арилжаанд байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Сэндбоксын зохицуулалтын орчин.

Энэ нь хэдийгээр хууль эрх зүйн зохицуулалт байхгүй ч гэсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээл дээр гардаг. Хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй учраас хянаж зогсоохоос илүү вакум орчинд буюу туршиж үзээд зах зээл дээр амьдрал дахь чадвар бүхий бүтээгдэхүүн гаргах явцыг Сэндбоксын зохицуулалтын орчин гэж нэрлэж байгаа.

Энэ сэндбоксын зохицуулалтын орчин бий болсонтой холбоотойгоор манай санхүүгийн салбарынхнаас нэлээдгүй олон бүтээгдэхүүн, үйлчилгээний хүсэлт ирсэн.

Энэ хүрээнд ч гэсэн бас энэ вакум орчинд сэндбоксын зохицуулалтын орчинд ажиллаад амжилттай бүтээгдэхүүн болоод гараад явж байгаа нэлээдгүй олон бүтээгдэхүүн, үйлчилгээ байна.

Цахим мөнгөнд суурилсаг дижитал бонд анх удаагаа гарсан.

Дээрээс нь энэ банк бус санхүүгийн байгууллагууд хоорондоо репо хэлцлийн платформ амжилттай үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнөөдрийн байдлаар сэндбоксын албанд нэлээдгүй хүсэлт ирчихсэн байгаа. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 6, **Peer-to-Peer (P2P)**, “**Crowdfunding**”-ийн үйлчилгээ үзүүлэхээр 2.

Анх удаагаа **Peer-to-Peer** болон “**Crowdfunding**”-ийн хууль эрх зүйн зохицуулалт холбогдох хуулиудад шигтгэж суугдаад явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Хэрэглэгчийг таних үйлчилгээ 1, үнэт цаас, өөрийн хэрэгсэл арилжих үйлчилгээ 2, валютын арилжаа, платформын үйлчилгээ 1 гэх мэтчилнээр хүсэлтүүд ирж байгаа.

Тэгээд энэ болгон дээр зохицуулагчийн зүгээс хэдийгээр хууль эрх зүйн орчин бүрэлдээгүй ч гэсэн бид туршаад цаашдаа хэрэгжээд явах боломжтой юм гэдгийг нь хараад хэрэгжүүлээд явж байна.

Мөнгө угаалт, терроризмын санхүүжилттэй тэмцэх ажил хорооны үндсэн үйл ажиллагаанд хамаарагдаж байгаа. Мэдээж дангаараа хэрэгжүүлдэггүй. Хамтын ажиллагааны зөвлөлийн хүрээнд 17 байгууллага байгаа. Гэхдээ зөвхөн төрийн байгууллага гэлтгүйгээр төр, хувийн хэвшил, тэгээд мэргэжлийн холбоод хамтарч ажилладаг.

ФАТФ-аас бодлогын 40 зөвлөмжийн тухай 2019 онд 25 нь шууд буюу шууд бусаар Санхүүгийн зохицуулах хороотой үйл ажиллагаа нь ямар нэгэн байдлаар хамааралтай байсан.

Энэ хүрээнд энэ үйл ажиллагаануудынхаа үнэлгээг сайжруулах, дараагийн түвшинд гаргахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хамтын ажиллагааны зөвлөлийн бүхий л байгууллагууд хамтарч ажилласны хүчинд Монгол Улс хамгийн богино хугацаанд буюу 10 сарын хугацаанд тэр стратегийн дутагдалтай улсуудын жагсаалтаас гарсан байгаа.

Бидийн хувьд нэг анхаарах зүйл үлдсэн. Өөрөөр хэлэх юм ФАТФ-ийн зөвлөмж 8-ын дагуу non-profit organisation буюу ашгийн бус байгууллагыг зохицуулах шаардлагатай байдаг.

Энэ ФАТФ-ийн зөвлөмж тодорхойлноор ашгийн бус байгууллага нь хандив тусламж, шашны болон нийгэм, боловсрол, соёлын зэрэг зорилгоор хөрөнгө татан төвлөрүүлэх, босгох, тараах үйл ажиллагаанд оролцож буй хуулийн этгээд гээд тусгачихсан байгаа.

Ингээд холбогдох газрууд Монгол Улсын Засгийн газраас энэ хуулийг Улсын Их Хуралд өргөн барьж батлуулах байх гэж бодож байна.

Холбогдох газруудаас бүртгэлийг нь сайжруулж байгаа. Татварын байгууллагууддаа мэдээллийг нь өгч холбогдох хяналт, зохицуулалтын түвшинг дээшлүүлснээр одоо энэ 7 сард Ази, Номхон далайн бүсийн хурал болно.

Энд бид ангиллыг нь нэг дахин дээшлүүлэх. Дийлэнхийг нь биелүүлсэн гэдэг ангилал руу оруулахаар зорьж ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Тэгээд бас нэг зүйл нь юу гэдэг юм ямар нэгэн стратегийн дутагдалтай юм уу, онцгой нөхцөл байдалд орсон үедээ анхаарах биш байнгын хийж хэрэгжүүлж анхаарах үйл ажиллагаа энэ мөнгө угаалт терроризмын санхүүжилттэй тэмцэх үйл ажиллагаа байгаа.

Ер нь 2027 онд Монгол Улс харилцан үнэлгээ дахиж хийгдэх байх. 2023 он их онцлогтой. Энэ харилцан үнэлгээ хийхдээ сүүлийн 5 жилийн хугацааг анхаарч үздэг.

Тэгэхээр 2023 оноос эхлээд бидний хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагааг энэ шаардлагад нийцэх эсэх дээр анхаарна.

Тийм учраас бүхий л байгууллагууд мөнгө угаалт, терроризмын санхүүжилттэй тэмцэх үйл ажиллагаанд тогтмол анхаарлаа хандуулж ажиллах зайлшгүй шаардлагатай байгаа гэдгийг хэлмээр байна.

Хяналт шалгалт, зохицуулалтын функц манай хорооны хамгийн том газар байгаа. Энэ дээр түрүүн ярьсан үл хөдлөх хөрөнгө, үнэт чулуу, түүгээр арилжаа эрхлэлтээс бусад салбаруудыг нэгдсэн хяналт, зохицуулалт байдлаар хийгддэг.

Бидний хувьд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо руу аажмаар шилжиж байна.

Ер нь юу гэдэг юм Үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага нэг байцаагчид 70-аас 90 компани хариуцдаг.

Бидний хувьд энэ шийдэл нь хүн нэмэх биш. Цахим шилжилтийг хийх, технологид суурилсан, ялангуяа эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгосноор ажиллагсад, албан хаагчид, манай хянан шалгагчийн ирэх тэр ачааллыг бууруулах ийм үйл ажиллагааг зорьж ажиллаж байгаа.

Гэсэн хэдий ч одоо энэ технологийн шийдэл та бүхэн мэдэж байгаа. Нэлээдгүй их цаг хугацаа, хөрөнгө оруулалт.

Дээрээс нь яг энэ салбарын ажиллагсдын цалин, нөхцөл байдал үүнтэй холбоотой бас амаргүй байгаа гэдгийг хэлмээр байна.

Хороо энэ санхүүгийн салбарын зохицуулагчийн хувьд олон улсын мэргэжлийн холбоодод идэвхтэй гишүүнчлэлтэй ажиллаж байгаа.

Олон улсын хүртээмжийн нийгэмлэг байна. Үнэт цаасны зохицуулагчид, даатгалын салбарын зохицуулагч, бусад энэ донор олон улсын байгууллагуудтай нягт хамтарч ажиллаж байгаа.

Энэ хүрээндээ ч гэсэн зөвхөн гишүүн би биш бүсийн санаачилгуудыг бас тэргүүлж ажилладаг гэдгийг хэлмээр байна.

Хорооны бүхий л шийдвэр судалгаа, шинжилгээнд үндэслэж гарсан байх ёстой гэдэг дээр анхаарч ажиллаж байгаа.

2020 онд Санхүүгийн зохицуулах хороонд шинэ менежмент, удирдлага ирсэнтэй холбоотойгоор бид судалгааныхаа хэлтсийг алба болгоод Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар болгосон. Энэ хүрээндээ нэлээдгүй салбарын нэгдсэн мэдээллийн сантай болохоор зорьж ажиллаж байгаа.

Хэрвээ нэгдсэн энэ зах зээлийн мэдээллийн сантай болчих юм бол магадгүй салбарын нэгдсэн хяналт, зохицуулалт.

Дээрээс нь олон улсын байгууллагуудаас тавьж байгаа шаардлагуудыг бүрэн хангаж ажиллана гэж ойлгож байгаа. Манай Байнгын хорооны гишүүдэд санхүүгийн зах зээл мэдээллийн тоймыг бүр долоо хоног болгон хүргэж байгаа.

Энэ талаар манайхан мэдээлэлтэй байгаа байх гэж ойлгож байна.

Дээрээс нь судалгаануудыгаа бид товхимол хэлбэрээр, санхүүгийн үйлчилгээний салбарын тоймуудыг бас гаргах гэх мэтчилэн олон ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Компанийн засаглалын хувьд нэлээдгүй анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна. Компанийн засаглалын кодексыг шинэчилж баталлаа. Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамжийг гаргасан. Үнэлгээнүүдийг хийж байна. Гэх мэтчилэн ажлуудыг дурдах нь зөв байх.

Дээрээс нь иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг мэдээлэл олгох талд хороо онцгой анхаарч ажилладаг.

Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Монголбанк, Боловсролын яам, Сангийн яамтай хамтраад хөтөлбөрийг хэрэгжүүлээд дууссан байгаа.

Дараагийн шатын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь хэрэгтэй гэж үзээд холбогдох газруудад санал тавиад ажиллаж байна.

Мэдээллийн технологийн хувьд бид ерөөсөө л цаашдынхаа хяналт зохицуулалтын үйл ажиллагаанд цахим гэдэг энэ цахимжилтын үйл ажиллагаанд л онцгой анхаарч ажиллаж байгаа.

Зүгээр нэг дутагдалтай юм бол ялангуяа мэдээллийн аюулгүй байдал, гаднын халдлагад өртөх эрсдэл тодорхой хэмжээнд байна гээд мэргэжлийн байгууллагуудаас үнэлэлт, дүгнэлт өгсөн байгаа.

Өөрийнхөө нөөц боломжийг ашиглаад аль болох мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд ажиллаж байна. Гэхдээ яг шаардлагатай хэмжээнд бүрэн дүүрэн 100 хувь байна уу гэвэл биш байгаа. Энэ дээр илүү сайжруулах илүү их цаг зав, дээрээс нь хөрөнгө нөөцтэй холбоотой анхаарах асуудлууд байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

2023 оны хувьд тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд энэ он маш их онцлогтой байгаа. Ялангуяа Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулга өргөн баригдчихсан. Хэлэлцээд дэмжчихсэн. Одоо ажлын хэсэг нь байгуулчихсан байгаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Даатгалын тухай хуулийн

шинэчилсэн найруулгын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын хууль, Хадгаламж зээлийн орчны тухай хуулийн шинэчилсэн найруулгуудыг тус тус энэ ондоо өргөн бариад хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Дээрээс нь Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, банкны реформын хүрээнд систем нь нөлөө бүхий ангиудын хувьцааг олон нийтийн болгох энэ үйл ажиллагаа цаашаа хэрэгжээд явна.

Өөрөөр хэлбэл энэ хуулийн хүрээнд хоёр онцлог заалт байгаа. Олон нийтийн болох үйл явц 7 сарын нэг гэхэд амжилттай хэрэгжих байх.

Зүгээр хамаарал, холбогдох этгээдүүдийн хувьцаа 20 хувиас их ихгүй байх гэж ийм шаардлага 12 сарын 31-нээр хангагдах ёстой.

Энэ хүрээндээ холбогдох зохицуулагч байгууллагууд Төв банк болон арилжааны банкнуудад бид шаардлагыг нь хүргүүлсэн байж байгаа.

Уул уурхайн гаралтай бараа, таваарыг биржээр дамжуулж арилжаа хийх зохицуулалт бий болсонтой холбоотой нэлээдгүй дэд бүтцийн болон дүрэм журам холбогдох энэ бэлтгэл ажлыг хангуулаад явж байна.

Энэ дээр бас олон улсын байгууллагууд, ижил төстэй олон улсын байгууллагуудтай уулзалтуудыг хийгээд техникийн туслалцаа авахаар яриа хэлэлцээ хийгдээд явж байна.

Даатгагчийн баталгааг нэвтрүүлэх зохицуулалтыг бий болгох гээд хууль эрх зүйн зохицуулалт нь бий болчихсон. Одоо яг хэрэгжүүлэхдээ илүү олон нийтийн оролцоог хангах тал дээр анхаарч байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд бүр үндэсний зөвлөлөө байгуулсан. Холбогдох алба байгуулсан. Тэгээд одоо бүртгэлийн ажиллагаа хийгдэж эхэлж байна.

Энэ үйл явц нэг жилийн хугацаанд хийгдэхээр хуульчлагдсан. Өөрөөр хэлбэл завсрын үеийн зохицуулалт гэж ойлгож болно.

Энэ хүрээндээ барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний үзүүлэгч этгээдүүдийг бүртгэнэ. Нэлээдгүй олон. Тэгээд ялангуяа орон нутагт маш их салбарласан бүтэцтэй байдаг учраас нэлээдгүй ажил, цаг хугацаа, эрч хүч бидний хувьд зарцуулах юм шиг байгаа юм.

Дэвшилтэт технологид суурилсан болон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар нэлээн анхаарч ажиллая гэж бодож байгаа. Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжиж байгаа. Сэндбоксынхоо зохицуулалтын орчныг илүү сайжруулаад, магадгүй зах зээлд гарах иргэдийн санхүүгийн эрэлт хэрэгцээ нийцсэн бүтээгдэхүүнийг дэмжиж ажиллуулна гэж бодож байгаа.

Ялангуяа уур амьсгалын өөрчлөлт, ногоон тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зайлшгүй бодлогоор дэмжиж байна. хүрээндээ анхны олон улсын ногоон модыг ХААН банк 60 сая доллар татсан. Бусад салбаруудад санхүүжилт татах талаар хорооны зохицуулалт нэлээн бодлогоор дэмжиж ажиллаж байгаа.

Ялангуяа ногоон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бондуудыг маш богино хугацаанд хөнгөлөлттэй

хэлбэрээр бүртгэж үйл ажиллагааг нь явуулахаар зохицуулалт хийгдсэн байгаа.

Биржээр арилжаалагддаг сангуудыг байгуулахад хууль эрх зүйн зохицуулалт хийгдэхээр төлөвлөж ажиллаж байна.

Тэгээд хорооны 2022-2025 онд тавигдах стратеги төлөвлөгөөнийхөө хүрээнд зөвхөн жилээр биш дараагийн жил, тэрний дараагийн жил гэдэг байдлаар бүгдийг нь үе шаттайгаар нийт 78 арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлэх зорилт тавиад ажиллаж байна.

Энэ хүрээд миний танилцуулгыг өндөрлөс дөө. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Д.Баярсайхан дарга нэлээн урт танилцуулга хийлээ. Тийм ээ.

Байнгын хорооны гишүүд Санхүүгийн зохицуулах хороон дээр очиж ажилласан Х.Ганхуяг гишүүн надтай очиж ажилласан. Манай 12 гишүүн ажилтай байсан. Тэгээд тэр өдөр жоохон буруу өдөр сонгогдсон байна лээ.

Бид үүнийг зуршил болгочихъё гэж байгаа юм. Байнгын хорооноосоо тайлангаа сонсохын өмнө Санхүүгийн зохицуулах хороон дээр очоод газар дээр нь хамт олонтойгоо уулзаад яриа хөөрөө өрнүүлчихвэл Байнгын хорооны мэдээлэл, тайлан сонсох ажил маань аль аль талаасаа үр дүнтэй болох байх гэж бодсон.

Надад бүгд ойлгомжтой байна. Бид чинь харилцан ярилцаад ганц нэг сэдэв дээрээ санал бодлоо ч илэрхийлсэн. Тийм ээ.

Тэгэхээр манай гишүүд сая мэдээлэл өгчихсөн байгаа. Мэдээллээ давхар харсан байх.

Тэгээд ажлын хэсгээ танилцуулаагүй байгаа юм байна. Тийм ээ. Ажлын хэсгээ танилцуулчихъя.

Д.Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Т.Цэрэнбадрал орон тооны гишүүн, Н.Хүдэрчулуун орон тооны гишүүн, Т.Жамбаажамц Ажлын албаны дарга, Н.Оюунчимэг Зах зээлийн судалгаа хөгжлийн газрын дарга, З.Батболд Даатгалын газрын дарга, Б.Дөлгөөн Үнэт цаасны газрын дарга, Б.Итгэлсүрэн Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга, Ц.Алтантуул Хадгаламж, зээлийн хоршооны дарга, Б.Долгорсүрэн Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга, Ж.Мөнх-Оргил Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Т.Билэгсайхан Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт гэсэн бүрэн бүрэлдэхүүнтэй иржээ.

Ингээд гишүүдээс илтгэлтэй холбогдуулан, тайлантай холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Өнөрболор гишүүнээр тасаллаа. Б.Баттөмөр гишүүн асуултаа асууж, саналаа хэлье.

Б.Баттөмөр: Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд 2022 онд эдийн засгийн өсөлт 4.8 хувиас бусад бүх эдийн засгийн үзүүлэлтүүд нь хасах байгаа юм л даа.

Тэгээд манай эдийн засагт гайгүй гэрэлтэй цэг нь манай Санхүүгийн зохицуулах хороон дээр явагдаж байгаа үйл ажиллагаа харуулаад байгаа.

Банкнуудын IPO-г хийсэн. Үндсэндээ нэг банкнаас бусад нь

хөдөлгөөнд орчихлоо шүү дээ. Тийм ээ. Хөрөнгийн биржийн арилжаа их идэвхтэй сайн явчихсан. Тэгээд цаашаагаа их олон ажлууд. Виртуал хөрөнгийн үйлчилгээний хууль хэрэгжээд эхлээд явж байгаа. Гэх мэтийн их сайн үзүүлэлтүүд гарч байгаа юм.

Тэгээд цаашдаа улам эрчимтэй сайн ажиллах тэр нөгөө санхүүгийн зах зээл, эдийн засгийн толь гэдэг тэр ухагдахуундаа хүрч ажиллах шаардлага байна гэж ингэж үзэж байгаа юм.

Хөрөнгийн захын үнэлгээ 6.9 их наяд төгрөг гэж байгаа юм. Тийм ээ. Энэ чинь дотоодын нийт бүтээгдэхүүний сая Д.Баярсайхан даргын ярьснаар 14 орчим хувь гэж байгаа юм байна. Тийм ээ.

Тэгэхээр яах вэ ер нь сайн өсөж байна. Сайн байна. Эдийн засгийн өгөөж нь ямар юм байдаг юм бэ? Үүнийг та нар их сайн тооцож ажиллах ёстой. Тоо байвал хэлээрэй.

Зүгээр түрүүн надад авсан мэдээллээр Хөрөнгийн бирж дээр арилжаа хийх гэж байгаа 20 компанийн 12 дээр нь үзэхэд арилжаа хийхээс өмнө 3.9 тэрбум төгрөгийн татвар төлдөг байсан бол IPO хийгдсэний дараагаар 15.7 гээд 4 дахин өссөн үзүүлэлт байсан. Энэ IPO хийгдэж байгаа, хөрөнгийн бирж дээр явагдаж байгаа үйл ажиллагаанаас эдийн засгийн өгөөжийг их сайн тооцож байх ёстой байгаа юм. Хамгийн гол нь өгөөж шүү дээ. Тийм ээ. Ямар ч тоо, ямар ч юм байж болно. Энэ өгөөжийг их сайн тооцож байх ёстой гэдгийг би хэлэх гэж байгаа юм.

Даатгалын салбар нөхөн төлбөр 94.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Нийт даатгалын хэмжээ нь хэд байдаг юм. Ер нь хэд орчим хувь нь буцаж олгогддог юм бэ гэсэн нэг дэх асуулт байна.

Банк бус санхүүгийн байгууллагаас 1.7 сая орчим хүн зээл авчээ. Тоо болгон үг хэлдэг. Тийм ээ. Тооны цаана дандаа утга агуулга байгаа шүү дээ.

Би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр маш их олон хүн үйлчлүүлдэг юм байна. Банкны салбарын орон зайг манай банк бус санхүүгийн байгууллагууд нөхөж байна. Энэ хэмжээгээр юу гэхээр банк бус санхүүгийн байгууллагын хүү өндөр байгаа шүү дээ. Тийм ээ. Энэ урьд урьд жилүүдийнхээс ямар байна? Дандаа өсөөд байна уу, буурч байна уу? Цаашдын хандлага юу байна гэсэн хоёр дахь асуудал байгаа юм.

Дараагийн асуулт юу гэхээр гаднын даатгалын байгууллагуудыг Монголтой хамтарч ажиллах. Жишээлбэл, Европын Холбоонд Хермес тэр гээд байдаг шүү дээ. Бизнес тодорхой хэмжээний санхүүжилтийг батлан даадаг. Тэр батлан даалтыг нь үндэслээд тодорхой зээл өгдөг.

Энэ чиглэлээр ямар юу байна? Бизнесийн даатгалын чиглэлээр ажиллах. Та нар юу бодож ажиллаж байна аа?

Монгол Улс хөрөнгө оруулагч үндэстэн болох ёстой. Тийм ээ. Манайх шиг өндөр инфляцтай, ханш нь байнга унаж байдаг ийм нөхцөлд хамгийн ашигтай бизнес хөрөнгө оруулалт.

Санхүүгийн зах зээл дээр хөрөнгийн зах дээр ажиллах. Энэ ард иргэдийг хөрөнгийн зах дээр ажиллах чиглэлээр ер нь ямархуу ажил зохион байгуулж байна аа? Тийм ээ. Яах вэ нийт тоо бол бас нэлээн тоо өндөр л байна л даа. Тэгэхдээ харьцангуй учир дутагдалтай байгаа. Энэ чиглэлд та бүгд ямар ажил хийж байна гэсэн асуултуудад хариулт авъя.

Ц.Цэрэнцунцаг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Д.Баярсайхан дарга хариулъя. Ажлын хэсгийн 3 номер.

Д.Баярсайхан: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Эдийн засгийн хэр үр өгөөжтэй юм бэ. Олон нийтийн компани болсноор тухайн компани хувьцаа эзэмшигчдэдээ ямар үр ашигтай юм.

Дээрээс нь татвар, хураамж, шимтгэл хэлбэрээр байдаг юм уу, улсад тийм ээ, ямар тийм үүрэг оролцоотой байгаа вэ гээд асууж байна. Тэгээд бид нэг судалгаа хийж үзсэн юм.

Ер нь 2017 оноос эхлээд хөрөнгийн зах зээл дээр компаниуд олон нийтийн болох үйл явц хэрэгжиж эхэлсэн. Идэвхжил нь хамгийн өндөр үе дээрээ явж байна.

Тэр 6.8 их наяд 2022 оны жилийн эцсийн тоо. Яг өнөөдрийн байдлаар 9 их наяд давчихсан байна.

Нийт 12 компани IPO гаргахын өмнө 2.8 тэрбум төгрөгийн орлогын албан татварт төлсөн байсан бол IPO хийсний дараа онд 5.9 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 108 хувь буюу 2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Түүнчлэн 12 компани нь 2023 оны онд нийтдээ 15 тэрбум орчим төгрөгийн орлогын албан татвар төлсөн нь IPO гаргахын өмнөх онтой харьцуулахад 422 хувь буюу 5 дахин нэмэгдсэн гэсэн статистик байна.

Гэхдээ мэдээж харьцуулахад юу гэдэг юм тухайн жилүүдийн нөхцөл байдал онцлог өөр байсан гэдгийг хэлэх нь зөв байх.

Тэгээд тал дээр цаашдаа бид ажиллаж байгаа. Тодорхой судалгаануудыг гарахаар Та бүхэнд хүргүүлье гэж бодож байна. Олон нийтийн болох үйл явц амжилттай хэрэгжээд явж байна.

Ер нь хөрөнгийн зах зээл дээр нэг үеэ бодоход лангуу хоосон биш. Бүтээгдэхүүнтэй болчихсон. Зүгээр хорооны нэг анхаарч байгаа зүйл бол өсөлтийг хэрхэн тогтвортой байлгах вэ? Ирэх жилүүдэд хийгдэх хөрөнгийн зах зээл дээр бүтээгдэхүүн, үйлчилгээнд оролцох хөрөнгө оруулагчдын оролцоо хэр байх вэ гэдэг тал дээр нэлээдгүй санаа зовж байна.

Ингээд нийлүүлэлт их байгаа ч гэсэн эрэлт тодорхой хэмжээнд буурах тийм эдийн засгийн сигнал байгаа гэдгийг хэлмээр байна.

Ер нь нь зөвхөн Монгол Улсад биш дэлхийн эдийн засаг 2.3 хувь, ирэх жил 3 хувь өсөхөөр хүлээлттэй байж байгаа. Инфляц бас л нэг 7 орчим хувьд байгаа. Тэгээд хүрээндээ ч гэсэн манайд нөлөөлөл өндөр байна л гэж бид харж байгаа.

Даатгалын салбарын хувьд нэлээдгүй ажлууд хийгдэж байна. Түрүүн хэлсэн. 2021 оны эцсээр даатгалын нөхөн төлбөрт 70 тэрбум олгож байсан бол одоо 2022 онд 94.4 тэрбум төгрөг олгогдсон байна.

Ердийн болон урт хугацааны хураамжийн орлого 300 тэрбум төгрөг орчимтой байж байгаа. Тийм. Тэгээд энэ хувиар бид харах юм бол даатгал аливаа эрсдэлийг урьдчилан хаах, эдийн засаг, санхүү, нийгмийн үйл ажиллагааг илүү итгэлтэй ийм төгс болгоход зайлшгүй бүтээгдэхүүн байгаа.

Тэгээд үүнийгээ илүү хөгжүүлэх тал дээр нэлээн анхаарч байна. Ялангуяа суурь баазыг өргөтгөх. Өөрөөр хэлбэл.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: 3 номер дээр гүйцээж хариулья.

Д.Баярсайхан: Заавал даатгалын нэр төрлийг олшруулах тал дээр суурь баазыг нь өргөтгөө гэдэг тал дээр онцгой анхаарч байгаа.

Багц хуулийн гол агуулга ч гэсэн тэгж тусгасан байгаа. Одоо жишээлбэл албан журмын даатгал 24 салбарын хууль, эрх зүйн зохицуулалт дээр байж байгаа. Жишээлбэл, багшийнх, эмчийнх, нотариатынх. Гэтэл хэрэгждэггүй. Үүнийг хэрэгжүүлдэг болгохоор бид ажиллаж байна.

Дээрээс нь даатгалын салбарт олж байгаа хураамжийн орлогыг Монгол Улсад авч үлдээдэг болох тал дээр онцгой анхаарна гэж ойлгож байгаа.

Энэ хүрээндээ үндэсний давхар даатгалын компани олон нийтийн компани болохоор хорооноосоо зөвшөөрлөө авсан.

Энэ дээр гаднын нэлээдгүй даатгалын компаниуд. Албан ёсоор зарлаагүй байгаа учраас. Сонирхож байгаа юм билээ. Ялангуяа Европын 2 ч тийм давхар даатгалын компани энэ даатгалын салбарын давхар даатгалын компанид тодорхой хувь хэмжээ эзэмшье. Хөрөнгө оруулья гэдэг урьдчилсан байдлаар яриа хэлцэл хийгдэж байгаа.

Банк бус санхүүгийн байгууллагын хувьд зүгээр нэг онцлогтой юм нь би түрүүн хэлсэн. Ялангуяа финтекийн зээл нийт зээлийнх нь ерөөсөө бараг 80 хувь нь байгаад байгаа юм. 78.8 хувь. 492.6 мянган төгрөг авч байгаа.

Ингэхээр энэ бол одоо ерөөсөө л хэрэглээний чиглэлийн зээл дийлэнхийг нь эзэлж байна. Маш богино хугацаанд олгогддоогоороо хүрч байна.

Дээрээс нь энэ салбарт цахимжилт маш их түргэн явж байна. Нөгөө талдаа бид харин магадгүй иргэдийн санхүүгийн мэдлэг мэдээлэл дутмагтай холбоотойгоор хохирогч болчих вий. Тийм ээ. Зээлийн өрөнд орох аюул урьдчилан сэргийлэх хүрээнд өр орлогын харьцааг 70, 30 гэдэг хэлбэрээр тусгаж өгсөн байгаа гэдгийг хэлмээр байна.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн нэмэлт асуулт асууя.

Б.Баттөмөр: Ямар ч байсан эдийн засгийн үр өгөөжөө их сайн нарийн тооцож байх ёстой шүү. Тийм ээ. Тухайлбал, сая жижиг Тавантолгой гэхэд л 141 тэрбум төгрөгийн ногдол ашиг тарааж байгаа шүү дээ.

Тэр хэмжээгээр улсын төсөвт төвлөрч төлж байгаа татвар бас нэмэгдсэн байгаа.

Тийм учраас Санхүүгийн зохицуулах хороо эдийн засгийн өгөөжийг маш сайн тооцох ёстой гэж би зүгээр санал хэлчихье. Хүмүүс олон асуулт асуух учраас.

Дараагийн асуудал биржийн бус арилжаа гээд нэг гайгүй явж байгаа юм байгаа. Миний мэдсэнээр 2022 онд 974 тэрбум төгрөгийн хөдөлгөөн арилжаа хийгдсэн гэж. Тэгээд энэ маань дандаа бүтээн байгуулалтын салбарынхан орж байгаа гэж байгаа юм. Тэгээд энэ бол их дэмжиж цаашаа явах ёстой. Тэр эрх зүйн орчин нь ямархуу байдаг юм.

Тэрийг сайн мэдэхгүй байна. Хэрвээ эрх зүйн орчныг нь сайжруулах

шаардлага байвал сайжруулаад ингээд явах шаардлагатай ажил гэж үзэж байна.

Ц.Цэрэнпунцаг: Санал хэлчихлээ. Ингээд Д.Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Оройн мэнд хүргэе.

Манай Санхүүгийн зохицуулах хорооныхон маань ерөөсөө орохгүй ч салбаргүй болсон, үйл ажиллагаа өргөн болсон байх чинь ээ. Цар хүрээ.

Тэр чинээгээрээ үр дүн гаргаад байгаа нь хамгийн чухал байна. Сайн байна гэж хэлмээр байна.

Тэгээд одоо би зүгээр кэйс асуух гэж байгаа шүү. Та бүхний тайлан дээр даатгалын нөхөн төлбөр 94.2 тэрбум төгрөг олгосон байна гэж мэдээлэл гарлаа.

Тэгэхээр даатгалын компаниуд маань тухайлах юм бол автомашины бүрэн даатгал, жолоочийн хариуцлагын даатгал гэж авчхаад эргээд ямар нэгэн асуудал гарахад тухайн автомашин гэмтэл авсан байлаа гэхэд мэргэжлийн байгууллагаар үнэлгээг нь гаргасны дараа тухайн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүйгээр өөрсдийнхөө үнэлгээгээр ч юм уу нөхөн төлбөр олгодог асуудал. Үүнийг хэрхэн шийдэж болох вэ.

Ер нь ямар гарц байгаа гэж харж байгаа юм?

Үүнээс болоод ямар асуудлууд үүсдэг вэ гэхээр мэргэжлийн тэр үнэлгээний баг нь болохоор нэг дүн хэлдэг. Даатгалын компани нь өөр нэг дүн хэлдэг. Тэгээд дунд нь баахан мөнгөний асуудал гардаг. Тэгээд хохирсон нөхөр нөгөө асуудлаа шийдэхийн тулд шүүхэд ханддаг. Шүүхэд очингуут шүүх нь жил, хоёр

жилийн дараа тэр асуудал нь шийдэгдэхээр нөхцөл байдал үүсдэг.

Ингээд нөгөө шүүх дээрх ачаалал нэмэгддэг. Хэрэг шийдэгдэхгүй байгаа гээд иргэдийн бухимдал төрдөг гээд л, ингээд л нийгэмд нэлээн тийм бухимдлууд төрөөд байгаа асуудлууд бас байна л даа.

Тэгэхээр даатгалын компанитай холбоотой, үнэлгээтэй холбоотой. Эргээд үүнийг нөхөн төлбөр олгохдоо бүрэн шийддэг. Тэр тухайн үнэлгээний компанитайгаа бүр нийцсэн байдлаар үнэлгээ гаргадаг боломжийг бүрдүүлэх боломжтой юу гэдэг. Энэ дээр нэг хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь, би түрүүн хэлсэн. Орохгүй салбар алга гээд.

2021 онд эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийг хэрэгжилт хэрхэн биелэгдэж байгаатай холбоотой ажлын хэсэг гарч ажилласан. Тэгээд үүнээс Монгол Улсын Засгийн газарт 16 зүйл, заалт бүхий чиглэл өгсөн. Тэр дотор эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа ажилтан албан хаагчдыг эрсдэлийн даатгалд хамруулах асуудал орсон байгаа. Тэгээд энэ тал дээр тодорхой шийдэл гарахгүй яваад байгаа.

Тэгэхээр боломж бололцоо ер нь байдаг юм уу? Энэдээр манай Санхүүгийн зохицуулах хорооныхон ямар байдлаар ажиллаж байгаа вэ гэдэг дээр нь хариулт өгөөч ээ.

Гуравдугаарт нь, бид биржээр уул уул уурхайн бүтээгдэхүүнээ борлуулж байгаа. Их сайн зүйл гэж харж байна. Илүү өгөөжөө өгөх, илүү тийм өндөр үнэтэйгээр худалдах, борлуулах боломжууд бүрдэж байгаа гэж харж байгаа. Урд нь үүссэн байсан янз бүрийн хулгай, луйвартай холбоотой асуудал ч

гэсэн үүнээс улбаалаад алга болж байна гэж.

Тэгэхээр бид байгалийн баялаг болгон дээрээ бас нэг тодорхой анализ хийсэн байх ёстой гэж харж байгаа юм л даа. Тухайлбал, зэс, алт гээд үнэт металлын хувьд мэдээж олон улсын зах зээлийн, дэлхийн зах зээлийн үнэ ханшаар явчихдаг.

Нүүрс агуулгаасаа юм уу, шинж чанараасаа хамаарсан үнэлгээтэй байна. Тус тусдаа.

Жонш гэхэд мөн адилхан. Магадгүй тэгээд бид аль улсад геополитикийн хувьд ямар улс орнуудтай харьцаж бизнес хийж байгаа вэ гэдэг тал дээр анализ хийж ажиллах ёстой гэж харж байгаа юм.

Тэгэхээр үүн дээр. Одоо жишээлбэл, Ашигт малтмалын тухай хууль орно. Өөрчлөлтүүд дээр Санхүүгийн зохицуулах хороо маань яг үүн рүү чиглэсэн ямар бодлого барьж ажиллах, ямар санал, дүгнэлтийг өгөх бодолтой байгаа вэ гэдэг дээр хариулт өгөөч. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 1 номер хариулъя.

Т.Жамбаажамц: Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга Т.Жамбаажамц Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Даатгалын салбар дээр, ялангуяа арилжааны даатгалын салбар дээр даатгалын тохиолдлууд маш их үүсдэг. Даатгалын гэрээн дээр үндэслэсэн тохиолдлууд.

Үүн дээр яг таны хэлж байгаа даатгалын хохирлын үнэлгээн дээр маш олон маргаанууд байдаг. Өнөөдрийн

үйлчилж байгаа хууль, эрх зүйн зохицуулалт 2003 онд батлагдсан Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар өөрөөр хэлбэл 20 жил энэ даатгалын харилцаа зохицуулагдаж ирсэн.

Тэгээд хуулийн зохицуулалтаар өнөөдөр даатгалын хохирлын үнэлгээ зайлшгүй гарна. Тэр хохирлын үнэлгээг даатгагчийн томилсон даатгалын хохирлын үнэлгээний компани хохирлыг гаргаад түүн дээр үндэслэж даатгалын нөхөн төлбөр олгоно л гэсэн зохицуулалттай.

Түүрүүн хороон дарга танилцуулга дээр маш тодорхой хэлсэн. Даатгалын салбарын саяын миний дурддаг хоёр хууль. Нэмээд Жолоочийн даатгалын албан журмын даатгалын тухай хуультай. Энэ 3 хуулийг бид бүхэн боловсруулаад Засгийн газраас өргөн барихаар ажиллаж байгаа. Хороод боловсруулсан. Сангийн яамтай хамтраад.

Энэ хуулийн хүрээнд одоо яг мэргэжлийн байгууллагууд, ялангуяа Эд хөрөнгийн хохирлын үнэлгээний байгууллагууд, Замын цагдаагийн тодорхойлолт гээд одоо яг иргэдэд даатгалын нөхөн төлбөрийг олгоход үнэхээр хүндрэлтэй байдаг. Таны хэлж байгаа энэ асуудлуудыг яг хууль эрх зүйн орчинд маш тодорхой зохицуулья гэсэн ийм хуулийн төсөл боловсруулагдаж явж байгаа.

Энэ хаврынхаа чуулганд Эдийн засгийн байнгын хороогоор дамжаад Их Хуралд хэлэлцэгдээд явна гэдгийг Та бүхэнд хэлье.

Зүгээр Д.Батлут гишүүний асуудал дээр нэмээд саяынх дээр хэлэхэд ерөнхийдөө албан журмын даатгал, сайн дурын даатгалын хоёр төрөл байгаа. Зүгээр албан журмын даатгал дээр

харьцангуй олголт тогтвортой явдаг. Сайн дурын даатгал дээр хохирлын үнэлгээн дээр даатгалын үнэлгээн дээр нэлээн маргаанууд байдаг.

Дараагийн дугаарт нь та тэр эрүүл мэндийн ажилтны даатгалыг гээд маш чухал асуудал хөндлөө.

Яг энэ асуудлаар С.Чинзориг сайд, хороон дарга хоёрын хамтарсан ажлын хэсэг тушаал батлагдсан. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн ажилтны хоёр төрлийн даатгал байгаа юм. Өөрөөр хэлбэл нөгөө хариуцлагын даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгал, нөгөө талаас эмч, эрүүл мэндийн ажилтны өөрийн даатгаж байгаа даатгал.

Энэ хоёрын эрсдэлийн даатгал. Өөрөөр хэлбэл маш эрсдэлтэй орчинд үйл ажиллагаа явуулдаг. Тэрийг нь даатгана. Нөгөө талдаа мэргэжлийн хувьд орчин тойрондоо асар эрсдэлтэй үйл ажиллагаа явуулдаг учраас тэрийг нь даатгана гэсэн ийм хоёр төрлийн бодлого яваад яг энэ дээр эрүүл мэндийн ерөнхий хуульд нь өөрчлөлт оруулахаар хамтарсан ажлын хэсэг гараад хуулийн төсөл эцэслэгдээд боловсруулчихсан хэлэлцэгдээд явж байгаа.

Тэгэхээр хүрээндээ Эрүүл мэндийн яамнаа, Засгийн газраас хороотой хамтраад яг Эрүүл мэндийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулаад асуудлыг заавал даатгал дээр нь зайлшгүй болгох ёстой юм байна лээ. Яагаад гэхээр орчин тойрондоо эрсдэлтэй орчинд үйл ажиллагаа явуулдаг мэргэжил, мэргэжлийн хариуцлагын даатгал. Нөгөө талдаа өөрийнх нь эрсдэлийг даатгасан ийм хоёр төрлийн даатгалыг заавал даатгалтай болгохоор ажиллаж байгаа.

Энэ хууль, эрх зүйн орчин зохицуулалттай болох юм бол эрүүл

мэндийн салбарын 50 орчим мянган эмч, эмнэлгийн ажилтны даатгалын асуудал зохицуулагдаад, хамгаалагдаад явах юм.

Тэрийг нь хувийн арилжааны даатгалын компаниуд чөлөөт өрсөлдөөний үндсэн дээр хийгээд явна гэж ойлгож болно. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Хариулт хангалттай юу? Д.Батлут гишүүн ээ.

Ажлын хэсэг 4 номер дээр.

Б.Дөлгөөн: Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн Д.Батлут гишүүний гурав дахь асуултад хариулья.

Улсын Их Хурлаас ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын харилцааг ил тод болгох, Монгол Улсын экспортолж байгаа ашигт малтмалын үнийг цэвэр нээлттэй өрсөлдөөнд тулгуурлаж үнэлгээг тодорхой хэмжээнд бодитой шударга тогтох ийм бодлогын хүрээнд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг өнгөрсөн оны 12 дугаар сард баталсан.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Монгол Улсад уул уурхайн бүтээгдэхүүний биржийн харилцааг зохицуулах хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын бодлогыг дэмжих хүрээнд тодорхой ажлуудыг хийгээд ерөнхийдөө амжилттай явагдаж байна.

Хуулийн хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн харилцаа маань энэ оны 06 дугаар сарын 30-наас буюу 07 сарын 01-нээс эхэлж мөрдөгдөхөөр хүлээгдэж байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс шаардлагатай дүрэм журмуудынхаа төслүүдийг боловсруулж

олон нийтээс санал авахаар өөрийн цахим хуудсандаа байршуулсан байгаа.

Түүнээс гадна яг биржийн үйл ажиллагаатай холбоотой ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Сангийн яам болон бусад хөрөнгийн зах зээл, бусад дэд бүтцийн байгууллагуудтай хамтарсан ажлын хэсгийг байгуулж Санхүүгийн зохицуулах хорооны дэд даргын ажлын хэсгийн ахлагчаар томилсон ажлын хэсэг ажиллаж байна.

Энэ хүрээнд тодорхой дүрэм журмуудыг ижил төстэй гадаадын туршлагатай байгууллагуудын санал, зөвлөгөөг авахаар хамтран ажиллаж байна.

Энэ хүртэл хугацаанд энэ оны 1 дүгээр сараас эхэлсэн Засгийн газраас баталсан экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журмын дагуу тодорхой арилжаанууд хийгдсэн.

Нийтдээ 1 сая гаруй тонны нүүрсийг амжилттай арилжаалсан. Эдгээр арилжааны тухайд өмнө нь хаалттай хүрээнд олон нийт мэдээлэл нь тодорхойгүй байдаг байсан бол илүү нээлттэй тодорхой болж эхэлсэн. Энд Хятад Улсын юаниар илэрхийлж бүтээгдэхүүнээ зарах. Мөн Америкийн Нэгдсэн Улсын доллароор илэрхийлсэн арилжаанууд хийгдсэн.

Энэ арилжааны үр дүнд биржийн арилжаа дунджаар 8 хувиар өссөн. Юанийн арилжаан дээр. Ам.долларын арилжаан дээр дунджаар 2 хувийн өсөлт үзүүлсэн байгаад байгаа юм.

Эдгээр өсөлтүүд зөвхөн биржийн арилжааны өсөлтүүд байгаа.

Өмнө нь зарагддаг байсан нүүрсний үнээс даруй маш өндөр хувийн өсөлт үзүүлсэн. Өөрөөр хэлбэл 90-ээс 100

долларын үнэлгээтэй байсан нүүрсний арилжаа биржийн буюу цахим арилжаагаар явагдсанаар 179, 180 америк доллар хүртэл цэвэр өсөлтийг үзүүлж чадсан байгаа.

Ингээд олон өрсөлдөгч арилжаа явагдах тусам олон худалдан авагч нар биржид бүртгүүлж арилжаанд оролцох хүсэлтээ илэрхийлж оролцсон. Үүний үр дүнд биржийн арилжаа эхэлснээс хойш нийтдээ дунджаар. Түрүүн хэлсэн. Юанийн хувьд 8 хувь, америк долларын арилжаанд 2 хувийн өсөлтийг үзүүлээд явж байгаа ийм бас томоохон үзүүлэлт гарсан.

Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан байдаг стратегийн орд газрууд 10 хувиа Монголын хөрөнгийн биржээр дамжуулж иргэдэд нээлттэй арилжаалах ёстой. Нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байх ёстой. Үүнтэй нь холбогдуулаад Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дэд бүтцийн болон бусад шаардлагатай. Ялангуяа гаднын хөрөнгө оруулагчийг татах чиглэлээр шаардлагатай дүрэм журам, зохицуулалтынхаа орчныг бэлэн байдлыг хангасан байгаа.

Тэгэхээр эдгээр харилцаанууд маань цаашдаа Засгийн газрын бодлого, Улсын Их Хурлын бодлогын хүрээнд явагдах байх.

Түүнээс гадна мэдээж ашигт малтмал буюу ашигт малтмалын орд газруудын үнэлгээ ерөнхийдөө арай өөрөөр тогтдог. Бизнесийн үнэлгээнээсээ гадна.

Тэгэхээр тэр ашигт малтмалын үнэлгээ тогтох стандартуудыг нэвтрүүлэх ажилд Санхүүгийн зохицуулах хороо хамтраад ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн тодруулж нэмэлт асуулт асууя.

Д.Батлут: Баярлалаа.

Ер нь иргэдийн өмнө тулгамдаад байгаа, хууль эрх зүйн хувьд зохицуулалтууд нь дутуу болчихсон ч юм уу, хуучирчихсан яг тухайн цаг үеийнхээ нөхцөл байдлыг хангаж чадахгүй байгаа олон зүйлүүдийг харж санаачлаад оруулж ирж байгаа нь туйлын бахархалтай байна.

Та бүхэн маань яг асуудлуудаа маш хурдан өргөн барьж Улсын Их Хурлаар батлуулаарай.

Ингэснээрээ бид иргэдийн өмнө тулгамдаг, бухимдал төрүүлдэг, иргэдээ эрсдэлээс хамгаалсан олон чухал үр дүнгүүдийг гаргах боломж бололцоо бүрдэнэ шүү гэдгийг Та бүхэндээ хэлье. Тэгээд баярлалаа.

Санхүүгийн зохицуулах хорооныхоо хамт олонд ажлын амжилт хүсье.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Ундрам гишүүн асуулгаа асууя. Саналаа хэлье.

Ч.Ундрам: Миний хувьд санаа зовж байгаа нэг зүйл байгаа юм.

Яах вэ сүүлийн жилүүдэд одоо энэ хөрөнгийн биржийн арилжаа өсөөд тэгээд үйл ажиллагаа нь нэлээн идэвхжиж байгаа. Энэ нь мэдээж Их Хурал Засгийн газрын гаргаж байгаа шийдвэр нэлээн нөлөөлж байгаа байх гэж бодож байна.

Жишээлбэл, Зээлийн хүүг бууруулах стратеги төлөвлөгөө, түүний хүрээнд батлагдсан Банкны тухай хууль. Тийм ээ. Банкнууд IPO хийх.

Тэгээд Засгийн газрын шийдвэрүүд. Ингээд олон юм нөлөөлж байгаа л даа.

Гэтэл одоо энэ хөрөнгийн зах зээлийн өсөлтийг хэрхэн хадгалах вэ гэдэг асуудал байгаа гээд Санхүүгийн зохицуулах хорооны дарга хэлж байна.

Тэгээд хөрөнгийн зах зээлийн өсөлтийг хадгалах 2 зүйлээс л хамаарна гэж би хараад байгаа юм.

Нэгдүгээрт, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах асуудал байгаа. Манай жижиг хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авч чадахгүй байгаа юм зөндөө байна. Шийдвэр гаргалтад огт оролцож чадахгүй. Ерөөсөө эрх ашиг нь хангагдахгүй байгаа гэж ер нь би үзэж байгаа.

Хоёрдугаар асуудал энэ хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын тайлагналын ил тод байдал бас төдийлөн хангалттай биш байна гэж бодож байгаа. Ерөөсөө энэ хоёр шалтгаанаас болоод л бид хоёрдогч зах зээл дээр бидний хувьцааны үнэ унаж байгаа.

Тэгэхээр саяын хоёр миний хэлсэн асуудал руу чиглэсэн ямар нэгэн арга хэмжээ Та бүхний тайлан дээр нэг их тийм тод харагдахгүй байна л даа.

Хэрвээ би хараагүй надад тодруулж өгөөч. Эсвэл цаашид энэ чиглэл рүү юу хийх нь зөв юм бэ ч гэдэг юм уу. Тийм ээ. Цаашдын төлөвлөгөө байвал.

Тэгээд ер нь өнөөдөр олон иргэд хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байгаа нь Төв банкны бодлогын хүү бага байгаа учраас тэгж байгаа шүү дээ. Буцаад Төв банкны бодлогын хүү өсчихвөл хүмүүс угаасаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх нь хангагдахгүй

байгаа юм чинь банканд мөнгөө хадгалуулаад сууж байсан нь дээр болчихно шүү дээ. Тэр үед л буцаад л арилжааны хэмжээ чинь буурчихна.

Тэгэхээр саяын миний санаа зовж байгаа хоёр асуулт дээр хариулт өгөөч ээ.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 4 номер. Т.Цэрэнбадрал дарга хариулъя.

Т.Цэрэнбадрал: Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн Т.Цэрэнбадрал Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Ч.Ундрам гишүүн Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангах талаар хэрэгжүүлэхээр манайд төлөвлөж байгаа ажлуудтай яг саналд нэгдсэн асуудлыг хөндөж тавилаа.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах асуудал Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн нэг номерын асуудал байгаа. Энэ хүрээндээ Санхүүгийн зохицуулах хорооны хувьд нэлээд хэдэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Мөн жижиг хувьцаа эзэмшигчид маань хувь нийлүүлэгчдийн хуралдаа орж чадахгүй асуудал байсан. Үүнийг бид КОВИД-ын үед болон хорооноос холбогдох журамдаа өөрчлөлт оруулаад цахимаар орон зай, цаг хугацаа хамаарахгүй оролцох боломжийг нь нээж өгсөн.

Энэ дээр үндсэн тодорхой мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд оролцоод явж байгаа. Энэ оролцоо нэмэгдэх хандлага байгаа.

Мөн бид Сорсын сантай хамтраад судалгаа хийж үзсэн. Энэ дээр үнэхээр жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьд хуралдаа оролцох боломж бололцоо нь бага байна гэсэн дүгнэлт гарсан. Хоёр жилийн өмнө. Энэ дээр бид анхаарч ажиллаж байгаа.

Хоёрт, ногдол ашигтай холбоотой асуудал байгаа. Яалт ч үгүй ийм асуудал байсан.

Компанийн тухай хуулиараа ногдол ашгийг компани өөрөө мөнгөн хөрөнгөөр бусад хэлбэрээр тараах боломжтой байдаг.

Жижиг хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа цаг тухайд нь авч чадахгүй байх асуудал үүссэн. Үүнийг Санхүүгийн зохицуулах хороо 2020 онд холбогдох тогтоолоо гаргасан. Ингээд төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулаад жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг тарааж байхыг журамлаж өгсөн. Энэ асуудал үндсэндээ шийдэгдсэн байгаа гэдгийг уламжилъя.

Хоёрт, дараагийн нэг том хийсэн ажил маань жижиг хувьцаа эзэмшигчдийн компанийн засаглалд оролцох оролцоог нь хангах асуудал байсан. Энэ хүрээндээ бид компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгохдоо жижиг хувьцаа эзэмшигчид өөрийн төлөөллийг оруулах боломжийг нь нээж өгсөн.

Өөрөөр хэлбэл манай журмын дагуу жижиг хувьцаа эзэмшигчид хамтарч нэгдэж нягтраад ойролцоогоор 8 хувийг эзэмшиж байгаа тохиолдолд компанийн ТУЗ-д төлөөллөө оруулах боломжийг нь нээж өгсөн.

Гуравт, бид хийж байгаа асуудал маань хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан жижиг хувьцаа эзэмшигчид

оролцох, улмаар кастодиан банк, сангаар дамжуулаад өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалах боломжийг нь нээж өгсөн. Энэ хүрээндээ нээлттэй 2 сан үйл ажиллагаа явуулж байна.

Сангуудын үйл ажиллагаа маань эхлээд жил гаруй болж байгаа. Цаашид илүү хийх, сайжруулах асуудлууд байгаа. Энэ хүрээндээ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд холбогдох өөрчлөлтүүдээ саналаа өгөөд оруулаад явж байгаа гэдгийг хэлье.

Дараагийн нэг асуудал бл яалт ч үгүй мэдээллийн ил тод байдал байгаа. Яалт ч үгүй үнэт цаасны зах зээлийн тухай хууль дээр хөрөнгө оруулагчид маань Хөрөнгийн биржээр дамжуулна үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 62 дугаар зүйл байгаа байх. Энд аливаа компани хувьцааны үнэ ханшид болон нөлөөлж болохуйц мэдээллийг Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх. Өөрсдийн веб сайтаараа дамжуулах, олон нийтэд хүргэх тийм зохицуулалттай байгаа.

Энэ ирсэн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны хувьд хянах, хөрөнгийн бирж олон нийтэд хүргэх гэсэн зохицуулалт байгаа. Энэ дээр бид бас нэлээдгүй арга хэмжээг хэрэгжүүлж байгаа.

Энэ хүрээндээ одоо Санхүүгийн зохицуулах хорооноос Хөрөнгийн биржтэй хамтраад жижиг хувьцаа эзэмших шаардлагатай байгаа тэр сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн мэдээлэл, их хэмжээний хэлцэл хийсэн мэдээлэл, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг шинэчилж Хөрөнгийн биржийн сайтаар дамжуулан энэ жилдээ дахин шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхээр манай хяналт шалгалтын газар арга хэмжээ авч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Цаашид Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийн идэвхжилийг хангах, хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нэг талдаа бид хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлд орох аливаа хүндрэл, чирэгдэл, зардлыг бууруулах тал дээр анхаарч ажиллаж байна.

Хоёрт, хөрөнгө, үнэт цаас гаргагчдын хувьцаат компаниудаа татварын бодлогоор дэмжих тал дээр ажиллаж байж байна. Өөрөөр хэлбэл өнгөрсөн онд хөрөнгийн зах зээлийг дэмжсэн татварын хуульд 3 том өөрчлөлт орсон.

Нэгд, IPO хийж байгаа компаниудын зардлыг 120 хувиар тооцож татвар ногдох орлогоос хасах.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Манай Санхүүгийн зохицуулах хороо нь цагаа бүрэн дүүрэн ашиглаж байна шүү.

Манай Санхүүгийн зохицуулах хороо хангалттай их ажил хийсэн, сайн ажил хийсэн учраас ингээд нүүр бардам. Хариулчих юмсан гээд бадрангуй сууж байна шүү дээ.

Ч.Ундрам гишүүд та нэмж асуух уу? Хангалттай хариулахаар чинь.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хамгийн гол нь Санхүүгийн зохицуулах хорооныхондоо Байнгын хорооныхоо нэрийн өмнөөс Та бүхэн сайн ажиллаж байна. Манай гишүүд маань ч дүгнэж байна шүү дээ.

Тэгээд цаашдаа бүр ихийг бүтээж сайн ажиллаарай гэж Байнгын хорооны гишүүдийнхээ өмнөөс Байнгын хорооны нэрийн өмнөөс Та бүхэндээ хүсье.

Сая нэг ажил давхацсан гээд би түрүүн хэлсэн. Тийм ээ. Ер нь Байнгын хороогоор бүрэн бүрэлдэхүүнээрээ ер нь намрын чуулганы үеэр нэг ажиллахыг бодно.

Ялангуяа одоо явж байгаа үнэт цаасны хууль дээрээ танилцуулга хийхдээ бид танилцуулгаа Байнгын хороон дээр нэг танилцуулчихад илүүдэхгүй байх. Эсвэл манай Байнгын хорооны даргын өрөөнд цөмөөрөө цуглаж байгаад хуулиа сайхан танилцуулаад, ерөнхийдөө агуулга, гол үзэл санаа, баримтлалын нэг сайхан танилцуулга хийчээрэй. Тэгвэл Та бүхэнд дэмжлэг болохгүй байх шүү гэж Та бүхэнд зөвлөгөө өгчихье. Тийм ээ. Баярлалаа. Та бүхэн явж болно.

Зургаа. Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан

Дараагийн асуудалдаа орёе. Хамгийн сүүлийн асуудал.

Үндэсний статистикийн газрынхныг оруулаарай. Б.Батдаваа дарга.

Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Тайлангийн танилцуулгыг Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа хийнэ. Б.Батдаваа даргын

микрофоныг нээе. 3 номер. Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Б.Батдаваа: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг өмнө хүргүүлсний дагуу тус хорооноос өнгөрсөн жилд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар товч танилцуулъя.

Бид өнгөрсөн 2022 онд улсын хэмжээнд 2 тооллого, 9 түүвэр судалгааг зохион байгууллаа. Тухайлбал, 10 жил тутам зохион байгуулдаг хөдөө аж ахуйн тооллогыг өнгөрсөн онд зохион байгуулж, уг тооллогоор улсын хэмжээнд 297 мянган өрх, 2.9 мянган аж ахуйн нэгж хамрагдсан.

Энэ удаагийн тооллогод сансрын өндөр нарийвчлалтай зургийн мэдээллийг ашиглаж хөдөө аж ахуйн талбай, өрх, аж ахуйн нэгжийн байршлыг тэмдэглэснээрээ онцлог боллоо.

Цаашид уг мэдээллийг ашиглаж сансрын зургийн тусламжтайгаар хөдөө аж ахуйн ургацын мэдээллийг шууд тооцоолох боломжтой болсноороо энэ удаагийн тооллогын гол онцлог оршиж байна.

Мөн бид жил тутам зохион байгуулдаг мал, тэжээвэр амьтдын тооллогыг 2022 онд зохион байгуулж уг тооллогоор улсын хэмжээнд 71.1 сая толгой мал тоологдсон болно.

Өнгөрсөн онд бид жил бүхэн мөн тогтмол зохион байгуулдаг өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болон ажиллах хүчний судалгаанаас гадна хүүхдийн хөдөлмөрийн судалгаа, албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааг анх удаа улсын хэмжээнд бие даасан хэлбэрээр

зохион байгууллаа. Эдгээр тооллого, судалгаа нь цаашид тогтвортой хөгжлийн зорилтууд болон төр, хувийн хэвшлийн шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээллийн эх үүсвэр болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Өнгөрсөн оны хувьд бид статистикийн үйл ажиллагааны загварыг олон улсын сайн жишигт нийцүүлэх, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах хүрээнд хэд хэдэн системтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгаа.

Энэ хүрээнд статистикийн мэдээллийн өгөгдөл, чанар, арга зүйн нэгдмэл байдал сайжрах үндсэн сууриуд тавигдсан гэж хэлж болно.

Мөн бид статистикийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог дотоод үйл ажиллагаандаа хийж, хэрэгжүүлж эхлээд байна.

2022 оны хувьд бид инфляцад тооцдог хэрэглээний үнийн сагсыг 2018-2020 оны суурьтай болгож шинэчилсэн байгаа. Ингэснээр өнөөдөр инфляцад тооцож байгаа хэрэглээний бараа, бүтээгдэхүүний сагс маань ард иргэдийн хамгийн сүүлийн үеийн хэрэглээний өдөр тутам хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүний үйлчилгээгээр баяжсан байгаа.

Түүнчлэн Үндэсний статистикийн хорооноос судалгааны чадавхыг бэхжүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна.

Энэ хүрээнд бид Монгол Улсын Их Сургууль, олон улсын байгууллагууд болон их дээд сургуулиудын профессоруудтай хамтарч хэд хэдэн судалгааны ажлуудыг гүйцэтгэж, судалгааны ажлуудаа Үндэсний статистикийн сэтгүүлд хэвлүүлж ажиллалаа.

Статистик мэдээллийг хэрэглэгчдэд илүү ойлгомжтой хүргэх, статистик мэдээллийн боловсролыг сайжруулах чиглэлээр бид өнгөрсөн онд хэд хэдэн ажил хийж хэрэгжүүлсэн байгаа.

Эдгээрийн нэг жишээ бид статистикийн цахим мэдээллийн сан буюу статистикийн цахим хуудсаа шинэчилсэн байгаа.

Энэ хуудас маань тоон өгөгдлийг олоход хялбар болгосон. Хайлтын систем шинээр нэвтрүүлснээрээ онцлог байсан.

Бид дээр нь статистик мэдээллийг хэрэглэгчдэд илүү хялбар хүргэх зорилгоор видео контент, ярилцлага, тухайлсан сэдэвчилсэн тайлан, судалгаа болон зурагт хуудсуудыг ихээхэн тархааж ажиллалаа.

Мөн бид иргэдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд өнгөрсөн онуудад статистикийн сургалт, мэдээллийн цагуудыг төр, хувийн хэвшлийн ажилчид болон олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчийн газрын ажилтнуудад системтэйгээр орсон байгаа. Үүнд нийтдээ 1100 гаруй хүн хамрагдсан байна.

Бид салбарын цахимжилтыг эрчимжүүлэх ажлыг мөн анхаарч ажиллаж байна.

Өнгөрсөн оны хувьд бид статистикийн мэдээлэл цуглуулахаас эхлээд боловсруулах, нийтэд хүртээх хүртэлх бүх үе шатыг цахимжуулсан системийн нэвтрэлтийг эрчимжүүлээ.

Мөн тооллого, судалгааг цаасаар цуглуулдаг байсныг бүрэн халж, хөдөлгөөнт төхөөрөмж, цахим хуудас

болон утсаар тооллого, судалгааны мэдээллийг 100 хувь цуглуулдаг боллоо.

Ингэснээр мэдээлэл цуглуулах, боловсруулахад гардаг цаг хугацаа хэмнэгдэхээс гадна тухайн мэдээллийг тогтсон байршил, өрх, аж ахуйн нэгжээс авч байна уу гэдгийг бид хянах боломжтой болж анхдагч мэдээллийн чанарыг сайжруулахад эрс өөрчлөлт гарч байгаа гэж итгэж байна.

Мөн байгууллагын хэмжээнд үйл ажиллагаагаа бүрэн цахимжуулж, үүний үр дүнд албан хаагчдын бүтээмж, цаасны хэрэглээ эрс багассан гэж хэлж болно.

Эдгээр ажлуудын үр дүнд 2022 онд дэлхийн статистикийн байгууллагуудын мэдээллийн нээлттэй байдал, хүртээмжтэй байдлыг үнэлдэг **“Open Data Watch”** байгууллагын үнэлгээгээр Үндэсний статистикийн хороо 192 улсаас 8 дугаар байрт, Зүүн Азийн бүсдээ нэгдүгээр байрт эрэмбэлэгдэж, энэ үзүүлэлт маань бидний 2020 оны үзүүлэлтээс нэг шатаар ахисан байгаа.

Статистикийн салбарыг орчин үеийн өгөгдлийн шинжлэх ухааны суурьтай хөгжүүлэх зорилгоор бид төрийн нэгдсэн мэдээллийн сан буюу төрийн их өгөгдөл төслийг Улсын Их Хурлын санаачилгатайгаар 2021 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бид Азийн хөгжлийн банк болон Солонгосын статистикийн газраас шийдвэрлэж, энэ жилээс эхлээд төсөл маань хэрэгжиж эхэлж байна.

Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын хэмжээнд өгөгдлийн засаглал бэхжиж, статистикийн мэдээллийн чанар, хамралт, задаргаатай байдал эрс сайжирч,

эдгээр мэдээллүүдийг төр, хувийн хэвшлийн шийдвэр гаргалтад ашиглах боломж бүрдэж чадна гэдэгт бид бүрэн итгэлтэй байна.

Өнгөрсөн 2022 оны хувьд бид гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа сайжруулах чиглэлд идэвхтэй ажиллалаа.

Энэ хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Статистикийн хорооны 8 дугаар хурлын даргаар Үндэсний статистикийн хорооны дарга сонгогдон ажиллаж байна.

Мөн бид бүс нутгийн болон дэлхийн түвшний статистикийн байгууллагуудын ажлын хэсэг, санаачилгад Үндэсний статистикийн хорооноос төлөөлөл орж идэвхтэй ажиллаж байна.

Түүнчлэн статистикийн салбарыг орчин үеийн өгөгдлийн шинж чанартай хөгжүүлэх зорилгоор бид “XXI зуунд Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл” /PARIS21/ байгууллагаас техник туслалцаа авч Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт боловсруулах хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна.

2023 оны хувьд Үндэсний статистикийн хорооны өмнө **“Төрийн нэгдсэн мэдээллийн сан”** буюу “Төрийн их өгөгдөл” төслийг амжилттай хэрэгжүүлэх, мөн хуульд заасан нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа болон цаг ашиглалтын судалгаа зэрэг томоохон түүвэр судалгаануудыг хийх ажил хүлээгдэж байна.

Үүнээс гадна бид анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах, статистик мэдээллийн уялдаа,

хүртгэмжтэй байдлыг сайжруулахад анхаарч ажиллах болно.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланд анхаарлаа хандуулсан Та бүхэнд талархал илэрхийлье.

Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн танилцуулъя. Б.Батдаваа даргад баярлалаа.

Б.Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Д.Лхамсүрэн Үндэсний статистикийн хорооны дэд дарга, Ш.Ариунболд Үндэсний статистикийн хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга, Ц.Тэгшжаргал Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга, Э.Мягмарханд Үндэсний статистикийн хорооны Хөдөө, аж ахуй, байгаль орчны статистикийн хэлтсийн дарга, Б.Саранчимэг Үндэсний статистикийн хорооны Нэгдсэн статистикийн газрын дарга, Э.Гантуяа Үндэсний статистикийн хорооны Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн ахлах статистикч.

Гишүүдээс танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Ч.Ундрам гишүүнээр тасаллаа. Б.Баттөмөр гишүүн асуултаа асууж, үгээ хэлье.

Б.Баттөмөр: Статистикийн байгууллага бол Монгол Улсын хөгжилд бодит хувь нэмэр оруулж байгаа байгууллага гэж үзэж байгаа.

Бид ярьдаг шүү дээ. Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт гэж. Тэгээд нотолгоо гэдэг маань статистик мэдээ орно л доо.

Тэгээд үүнийгээ бид хэр зэрэг ашигладаг юм доо. Муу ашиглаад байх шиг байдаг юм. Тэгээд үүнийг маш сайн ашиглах ёстой.

Манай статистикийн байгууллагаас гаргаж байгаа мэдээллийг уншихаар их аятайхан аятайхан мэдээллүүд, санаа авмаар янз бүрийн юмнууд их байдаг. Үүнийг тэгээд цаашаагаа бид сайн ашиглах шаардлагатай гэж ингэж үзэж байгаа.

Статистикийн байгууллагын хувьд ч гэсэн материаллаг бааз нь бэхжиж байгаа. Янз бүрийн программ хангамжууд нэвтэрч байгаа. Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар нэг төсөл хэрэгжих ёстой байх гэж ингэж бодож байгаа.

Тэгээд тэр нөгөө “1212.mn” гээд. Тийм ээ. Энэ цахим хуудсыг мэдээллийг шинэчилсэн хайлтын тийм программуудыг нэвтрүүлсэн. Бас юм хайж барихад их эвтэйхэн болчихсон харагдана лээ.

Тэгээд яах вэ, ер нь өнөөдөр. Зүгээр яах вэ, байгууллага дээр яаж ажиллаж байгаа нь мэдэхгүй.

Б.Батдаваагийн хувьд залуу хүний хувьд хийж байгаа ажлыг нь харахад манлайлал гайгүй байх шиг харагддаг юм.

Ази, Номхон далайн тэр том хурлын даргаар ажилласан. Бас бүс дундын шинжээчдийн бүлэг гээд юун дээр бас төлөөлөх гишүүнээр сонгогдоод ажиллаж байсан.

Тийм учраас би гайгүй ажиллаж байгаа болов уу гэж байгаа. Залуу хүний хувьд сурах юмнууд нэлээн байгаа байх гэж ингэж бодож байна.

Тэгээд хэд хэдэн асуултууд байна.

Нэгдүгээрт нь, статистик мэдээллийн дэлхийн чиг хандлага ер нь аль руу явж байна аа? Энэ дээр нөгөө “big data”, тэр хиймэл оюун ухааныг ашиглах чиглэлд та нар ямар бодлого хэрэгжүүлж байна гэж.

Тэр өгөгдлийн засаглал гээд байдаг. Тийм ээ. Тэр өгөгдлийн засаглал. Энэ чиглэлд та нар ямар ажлууд хийхээр төлөвлөж байна аа?

Төрийн байгууллагуудаас мэдээллийг авчхаж чадаж байгаа байх.

Хувийн хэвшил. Одоо манай эдийн засгийн чинь зарим салбарыг жишээлбэл аялал жуулчлал ч юм уу, эм хангамж ч гэдэг юм уу, тодорхой салбаруудыг хувийн хэвшлийнхэн нь авч явж байна шүү дээ. Газар тариалан, мал аж ахуй гээд.

Энэ чиглэлд та нар мэдээллийг авах чиглэлд, боловсронгуй болгох чиглэлд ямар юм хийгдэж байна? Юу бодож байна гэсэн ийм хоёр дахь асуулт байна.

Гурав дахь асуулт юу гэхээр далд эдийн засгийн асуудал.

Манай статистикийн 11 хувь гэж ярьдаг. Манай Сангийн яамныхан ярихдаа 9 хувь гэж ярьдаг.

Монгол Улсын Ерөнхий сайд хэлэхдээ дотоодын нийт бүтээгдэхүүнтэй тэнцүү байна гэдэг. Би Ерөнхий сайдтай санал нэг байгаа.

Сая Тавантолгойд гарсан нүүрсний хулгай гээд. Энэ тэгээд бусад ашигт малтмал тойрсон, алт тойрсон энэ далд эдийн засгийн юмнууд. Ченжүүд. Энэ юм ингээд нийлэх юм бол маш том тоо гарна.

Энэ далд эдийн засгийг гүйцэд тооцох. Та бүгдийн гаргаж ирж байгаа судалгаа шийдвэр гаргалтад их чухал нөлөө болно.

Магадгүй далд эдийн засагтайгаа олигтой тэмцэхгүй байсныг нь Та бүгдийн 8, 9 хувь байдаг. Дэлхийн дундажтай тэнцүү байна гэж ингэж ойлгоод байсантай ч байж магадгүй.

Яаж ажиллах гэж байна аа? Энэ чиглэлд та нар ямар дүгнэлт хийж байгаа вэ? Ийм асуултуудад хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Б.Батдаваа дарга хариулъя. Ажлын хэсгийн 3 номер.

Б.Батдаваа: Улсын Их Хурлын эрхэм гишүүн Б.Баттөмөр даргын асуултад хариулъя.

Дэлхийн статистикийн байгууллагуудын чиг хандлага ер нь их өгөгдөлд суурилсан чиглэл рүүгээ хөгжиж байна гэж хэлж болж байгаа.

Энэ ч утгаараа Үндэсний статистикийн хороо Улсын Их Хурлаас чиглэл авсны дагуу эхний ээлжид “Төрийн нэгдсэн мэдээллийн сан” буюу “Төрийн их өгөгдөл” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Энэ маань төрийн байгууллагууд дээр цугларч байгаа мэдээллийн сангуудын хоорондоо уялдаатай байдал, зөрүүгүй байх.

Энэ мэдээллийн сангуудыг төрийн байгууллагууд нууц гээд өөр дээрээ хадгалаад байх биш эргэлтэд оруулж шийдвэр гаргалтад ашиглах ийм цогц өгөгдлийн засаглалыг хөгжүүлэх төсөл байгаа.

Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бид нийтдээ 4.2 сая долларын буцалтгүй тусламжийг одоогийн байдлаар шийдээд, төслийн ажлын хэсэг нэгж байгуулагдахаар ажиллаад явж байна.

Энэ жилээс эхлээд төрийн өгөгдлийн каталог, шинээр төрийн мэдээллийн сангуудыг холбосон шинэ шинэ шийдвэр гаргалтад ашиглах ажлууд шинээр хийгдэнэ.

Энэ дотроо бид нарын хамгийн голлон анхаарч ажиллаж байгаа “өгөгдлийн засаглал” гэдэг ажил байгаа. Асуудал байгаа.

Энэ юуг хэлж байгаа вэ гэхээр улсын хэмжээнд нэгдсэн өгөгдлийн засаглал байх ёстой гэж үзэж байгаа. Энэ нь юу гэж байгаа вэ гэхээрээ хоёр, гурван байгууллагууд дээр иргэнээс юм уу, аж ахуйн нэгжээс зэрэг мэдээлэл цуглуулаад байж болохгүй. Нэг л удаа авах ёстой.

Тэр цуглуулж байгаа мэдээлэл чанартай байх ёстой. Алдаагүй байх ёстой.

Тэр мэдээллийг эргээд аль байгууллага, ямар түвшиндээ, ямар нууцлалтайгаар хадгалах вэ гэдэг бүх зохицуулалтууд маш тодорхой байх ёстой.

Энэ мэдээллүүд маань буцаад эргээд бусад төрийн байгууллагын мэдээллийн сангуудтайгаа холбогдож бид иргэн, аж ахуйн нэгжүүдийн талаар төрөөс болон хувийн хэвшлээс авч байгаа

шийдвэрүүд маань ухаалаг гарч байж төсвийн үр ашигтай байдал болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын эрсдэлүүд буурна гэж үзэж байгаа.

Энэ утгаараа төсөл маань цаашдаа Монгол Улсын хэмжээнд өгөгдлийн засгийг хөгжүүлэхэд голлон анхаарах юм байгаа юм.

Хоёрдугаар асуултын хувьд хувийн хэвшлээс бид мэдээллүүдийг одоогийн байдлаар цаасан хэлбэрээр цуглуулдаг байсныг ихэнхийг нь цахим хуудас хэлбэр лүү шилжүүлж байгаа.

Дээрээс нь статистик мэдээллийг шинээр тооцох эх үүсвэрүүдийг бид тодорхойлоод. Одоо жишээлбэл гар утасны оператор компаниудаас гар утасны эх өгөгдлийг авч дотоодын аялал жуулчлалд шилжилт хөдөлгөөний статистик тооцоогоор ажиллаж байна.

Ерөнхийдөө энэ төрийн байгууллагуудын мэдээллийг ашиглах болон хувийн хэвшлийн мэдээллүүдийг ашиглах дээр гарч байгаа нэг хүндрэл бол тухайн мэдээллийн нууцлалын асуудал байдаг.

Үүнийг бид статистикийн тухай хууль дээр тодорхой нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах саналтай байгаа. Үүнийг бид олон улсын байгууллагын техник туслалцаагаар энэ хуулийн төслийг боловсруулж байгаа.

Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулахаар бид Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ танилцуулаад буюу хууль санаачлагчаараа дамжуулж хандах ийм хүсэлттэй ажиллаж байгаа.

Үүнийг өчигдөр Эдийн засгийн байнгын хорооны дарга болон гишүүд Үндэсний статистикийн хороон дээр

ажиллахад товч мэдээлэл өгч танилцуулсан байгаа.

Гуравдугаар асуулт. Далд эдийн засгийн хувьд уламжлалт статистикийн тооцооны аргачлалаар далд эдийн засагт гэдэг дээр биеэ үнэлэх, мансууруулах бодис, мөрийтэй тоглоом гэх мэт тодорхой хэдэн салбаруудыг авчихсан. Эдгээрийн талаар мэдээлэл цуглуулж тооцдог аргачлал байгаа.

Энэ аргачлалаар тооцсон далд эдийн засгийн хэмжээ маань 9.3 хувь гэсэн тооцоо байдаг. Тэгвэл Монгол Улсын уул уурхайн баялаг.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээж хариулъя. 3 номер дээр гүйцээгээд хариулчихъя.

Б.Батдаваа: Тэгэхээр далд эдийн засгийг тооцдог аргачлал маань яг гурван үндсэн чиглэл рүүгээ хандчихсан байдалтай буюу 9.3. хувь гээд тооцож байгаа.

Өнөөдөр гараад байгаа уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт, тээвэрлэлт болон үүнтэй холбоотой асуудлууд дээр бид Монголбанк, Гаалийн ерөнхий газартай хамтарч ажиллаж байгаа.

Яагаад вэ гэхээр одоо жишээлбэл Монгол Улсын нийт экспорт 2022 оны байдлаар гаалийн мэдээгээр 12.5 тэрбум долларт хүрсэн байгаа. Жишиг үнэ нь ашиглаад гэсэн үг.

Гэтэл энэ яг гэрээний үнээр нь тооцоод үзэхэд маань 9.8 тэрбум болоод буурчих жишээний.

Тэгэхээр үнэлгээтэй уул уурхайн бүтээгдэхүүн маань салбар маань өөрөө ил тод байдал маш чухал учраас ил тод

байдлыг хангаагүйгээс шалтгаалсан энэний ард явагдаж байгаа үйл ажиллагааг бид илүү гаргаж ажиллах дээр хамтарч ажиллаж байгаа.

Энэ зөрүү мэдээллийг төлбөрийн тэнцлийн статистик дээр бид залруулгыг нь ороод ажиллаж байгаа гэж хэлж болно. Ерөнхийдөө 2.7 орчим тэрбум долларын зөрүү энэ гаалийн жишиг үнэ болон гэрээний үнэ дээр гараад байгаа.

Ер нь цаашдаа уул уурхайн бүтээгдэхүүний ил тод байдлыг хангах, үүнийг статистик мэдээлэл дээр үнэн зөв тусгах асуудлын хүрээнд өмнө нь Санхүүгийн зохицуулах хороо танилцуулсан байх. Уул уурхайн биржээр дамжуулдаг. Үүнийг гадаад худалдаатай холбох, боомтын захиргаа буюу Боомтын үндэсний хороо энэ бүх мэдээллүүдийг нэгдсэн байдал руу оруулахаар бид хамтарч ажиллаж байгаа.

Энэ дээр түрүүн ярьдаг нөгөө төрийн байгууллагуудын мэдээллийн санг холбох буюу төрийн нэгдсэн мэдээллийн сан гэдэг зүйлийг холбож ажиллах юм гэдэг дээр хариу өгье. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн нэмэлт асуулт асууя.

Б.Баттөмөр: Дэлхий нийтийн байдал өөрчлөгдөж байгаа. Тийм ээ. Геополитикийн асуудал.

Одоо сүүлийн үед болж байгаа энэ асуудал дэлхийн эдийн засаг нэг нэгдмэл байсан бол сүүлийн үеийн байдлаас блоклогдох хандлагатай болчихсон байна шүү дээ. Тийм ээ. Сая тэр Баоагийн уулзалттай яригдаж байгаа юмыг Та бүгд сонссон байх.

Тэгээд Монгол Улс чинь хоёр хөршийн дунд байдаг. Далайд гарцгүй. Эрсдэл ихтэй.

Тэгэхээр нийгэм, эдийн засгийн эрсдэлийг тооцох чиглэлээр Хөгжлийн яам, Сангийн яам, холбогдох байгууллагуудтай хамтарч энэ чиглэлд Та бүгдийн бодож санаж байгаа юм юу байна. Ийм эрсдэлүүд байж болшгүй шүү гэж гарч байгаа тоо статистик дээр үндэслээд ингэж өгдөг тийм юм байж болох уу? Гаргаж болох уу? Энэ чиглэлд хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: 3 номрыг хариулах уу? 3 номер. Б.Батдаваа дарга хариулъя.

Б.Батдаваа: Улсын Их Хурлын эрхэм гишүүн Б.Баттөмөр даргын асуултад хариулъя.

Монгол Улсын өмнө тулгамдаад байгаа нийгэм, эдийн засгийн сорилт болон эрсдэлийг бид бас тоон мэдээллээр харуулах. Үүнийг холбогдох бодлогын шийдвэр гаргадаг байгууллагуудад хүргэх чиглэлээр тодорхой ажлуудыг шинээр хийж байсан байгаа. Тухайлах юм бол 2021 оноос эхлээд бид эдийн засгийн аюулгүй байдлын тайлан гэж боловсруулж гаргаж байгаа.

Энэ дээр бид Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид тусгасны дагуу эдийн засгийн бид тогтвортой байдлаа, урт хугацааны тогтвортой байдлаа хадгалахад шаардлагатай гадаад худалдаа, гадаад өр, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, ядуурал гэх мэт нийгэм, эдийн засгийн эмзэг байдлын үзүүлэлтүүдээр ямар өөрчлөлтүүд гарч байна, юу хамаарч байна, цаашдаа эрсдэлүүд юу байна гэдэг дээр тайлангуудыг жил болгон гаргаж бодлогын шийдвэр гаргадаг

байгууллагууд болон Улсын Их Хурлын.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Ингээд Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа.

Статистикийн хороог манай гишүүд үнэлж байгаа. Та бүхнийг сайн ажиллаж байгаа шүү. Ингээд цаашдаа улам сайн ажиллаарай гэж Та бүхэндээ урам өгч байгаа шүү.

Бид өчигдөр сайн ярьсан л даа. Б.Баттөмөр дарга аа. Бид очиж, одоо оффисоосоо авхуулаад л өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглаад л засвараа, тэр технологийн шаардлага хангасан дата төв энэ тэрээ. Ялангуяа тэр сервер эд нарынхаа наагуур ажиллаж байгаа тэр орчноо их сайхан тохижуулж янзалсан байна лээ.

Дээрээс нь өөрсдөө гадаадын байгууллагууд руу хандаад 2 ч төслийг санхүүжилтийг нь босгочихсон ажиллаж байгаа. Тийм ээ. Ерөнхийдөө нийт 3 гаруй сая долларын төсөв босгочихсон ажиллаж байгаа. Ингээд бид статистикийн хамт олондоо урам өгч ажиллах ёстой байгаа юм.

Дээрээс нь сая Санхүүгийн зохицуулах хорооныхонд бас нэг хуультай. Үнэт цаасны тухай хууль оруулж ирэх гэж Байнгын

хорооныхондоо танилцуулга хийе, үзэл санаа, үзэл баримтлалыг нь сайн танилцуулъя гэж байгаа.

Та бүхэн ч бас хуулиа Байнгын хороогоор оруулж ирээд миний өрөөнд нэг зохион байгуулдаг шүү дээ. Нэг хэлбэрээр хуулийнхаа гол үзэл санаа, үзэл баримтлалыг нь танилцуулга хийгээд явчхаарай. Дэмжлэг гишүүдээсээ, Байнгын хорооныхоо гишүүдээс голлож авч явах учраас энэ талдаа Та бүхэн идэвхтэй ажиллаж байгаад хаврын чуулган өндөрлөхөөс өмнө гишүүд маань ойлголттой болчихвол зүгээр байх.

Та бүхэн цөмөөрөө Байнгын хорооныхоо ажлын албаныхантай ярьж байгаад тэгээд нэг хуваарь гаргаад зохицуулчхаж болох байх гэж бодож байна.

Ингээд Та бүхэндээ баярлалаа.

Ингээд өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Статистикийн газрынхан Та бүхэн явж болно.

Дээрээс нь нэг юм мартсан байна шүү. Түрүүн 2024 оны жилийн төлөвлөгөөний санал, дүгнэлтийг Д.Батлут гишүүн унших байсныг өөрчлөөд Д.Өнөрболор гишүүн уншихаар болсон шүү.

Хуралдаан 4 цаг 05 минут үргэлжилж, 18 цаг 23 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД